ЗОГСОНГИ застойный stagnant;
зогсонги байдал застой, упадок stagnation. depression;
зогсонги байх находиться в застое be stagnant;
аж үйлдвэрийн зогсонги байдал застой в промышленности industrial stagnation.

ЗОГСОО: *зогсоо зайгүй* беспрестанно, беспрерывно continually, uninterruptedly. unceasingly, restless;
зогсоо зайгүй утасдах звонить беспрерывно phone without break, phone uninterruptedly.

ЗОГСООЛ место стоянки, стоянка, остановка stop, station, halt, stand;
автобусны зогсоол/буудал остановка автобусов, автобусная остановка bus stop, bus station;
эцсийн зогсоол, эцсийн буудал конечная остановка terminal;
таксины зогсоол/буудал стоянка такси taxi-stand;
галт тэрэгний зогсоол железнодорожная станция railway station.

ЗОГСООХ останавливать, приостанавливать, прекращать, прерывать stop, bring to a stop, make stand up, make an end; interrupt, cease;
ажлаа зогсоох прекращать работу stop one's work;
машинаа зогсоох остановить машину stop one's car;
гал зогсоох прекратить огонь cease fire;
дайн зогсоох прекратить войну, положить конец войне halt the fighting, put an end to the war;
цөмийн зэвсэгийн туршилтыг зогсоох запретить испытание ядерного оружия discontinue nuclear weapons tests;
гүдамжны хөдөлгөөнийг зогсоох остановить уличное движение bring traffic to a standstill.

ЗОГСОХ 1) стоять, торчать stand, stop;
2) останавливаться; приостановливаться, прекращаться; переставать, come to a stop, stand still. cease, pause. abate;
гэнэт зогсох внезапно остановиться stop short;
дугаарлан зогсох стоять в очереди stand in a queue;
ажил зогслоо работа стоит the work has come to a stop;
галт тэрэг энд арван минут зогсдог поезд здесь стоит десять минут the train stops here ten minutes;
цаг зогсжээ часы стоят the watch has stopped;
харуулд зогсох, мананд зогсох стоять на страже, стоять на часах be on guard, stand guard;

бидний өмнө (зогсож) байгаа зорилт задачи, стоящие перед нами the tasks confronting us;
бороо зогсов дождь перестал the rain has stopped;
хөл дээрээ зогсох стоять на ногах stand on one's feet;
өлмий дээрээ зогсох стоять на цыпочках stand on tip-toe.

ЗОГГУСАХ вдруг остановиться stop suddenly.

ЗОГЬСОХ икать hiccup, hiccough.

ЗОДООН драка fight, scuffle;
зодоон гаргах затевать драку start a fight;
водоон цохиондоо хүрэх доходить до драки come to blows.

ЗОДОЛДОХ драться fight, scuffle;
хүнтэй зодолдох драться с кем-либо fight with somebody;
гадаа гудамжинд зодолдож байна на улице дерутся there is a fight in the street.

ЗОДОХ бить, избивать, колотить beat, hit;
зодож нүдэх, зодож жанчих избивать beat.

ЗОЛ счастье, удача luck, good fortune;
зол заяа счастье good luck, happiness;
зол завшаан удачный случай, возможность lucky chance.
зол болох везти be lucky, be successful;
золоор к счастью fortunately, luckily;
та золоор хожимдсонгүй, хожимдоогүй нь таны зол болжээ к счастью, вы не опоздали; ваше счастье, что вы не опоздали fortunately, you are not late; you are lucky not to be late;
золтой хүн удачливый / счастливый человек lucky man, successful person;
золгүй неудачливый, несчастливый unlucky, unsuccessful
золгүй явдал невзгода, несчастный случай, несчастье adversity, casuality, accident;
золгүй өдөр злополучный день, несчастливый день ill-omened day, day of bad luck.

ЗОЛБИН бродячий stray;
золбин нохой бродячая собака stray dog.

ЗОЛБОО великолепие, сияние, красота, бодрость; удачливость glory, splendour, cheerfulness; luck;
цог золбоо, золбоо хийморь великолепие, величие, бодрость greatness, splendour; cheerfulness;
золбоотой хүү бодрый мальчик, удачливый мальчик cheerful boy, lucky boy.

ЗОЛГОХ приветствовать; встречаться, встречать greet, meet.

ЗОНХИЛОХ преобладать, доминировать prevail, predominate, dominate
зонхилох нь, зонхилох олонх нь подавляющее большинство, преобладающее большинство, доминирующая часть overwhelming majority, vast majority.

ЗООГ еда, кушанье food, meal;
зоогийн газар ресторан restaurant;
зоог барих дать обед; подавать кушать offer food.

ЗООГЛОХ кушать have a meal.

ЗООРИЛОХ хранить что-либо в подвале store in a cellar pit.

ЗООРЬ погреб, подвал cellar, storing pit.

ЗООС монета coin;
алтан зоос золотая монета gold coin;
хуурамч зоос фальшивая монета false coin;
зэс зоос, сохор зоос медная монета copper coin.

ЗООХ вкапывать, закапывать, врывать; вбивать, всаживать, посадить dig in, stick in, put in, insert, install;
утасны шон зоох вкопать телеграфный столб install a telegraph pole.

ЗОРГО своеволие, произвол self-will, wilfulness;
дур зоргоороо аашлах (загнах) авирлах самовольничать, своевольничать, действовать по своему произволу be self-willed, be wilful, act wilfully.

ЗОРИГ смелость, храбрость, сила воли courage, boldness, will power;
шийдвэр зориг решимость, решительность resolution;
шийдвэр зориг дүүрэн / төгс байх быть полным решимости be fully resolved;
эрэлхэг зориг гаргах проявить мужество show courage;

вориг ерох набираться храбрости, собираться с духом gain courage;
вориг мохох, вориг шантрах, вориг алдрах не хватать смелости, не осмеливаться, терять присутствие духа lo e courage, despair;
вориг бадрангуй воодушевлённый, полный энтузиазма inspered, full with enthusiasm;
вориг дүүрэн ажиллах работать с энтузиазмом work with gusto;
вориг эрмэлзэл намерение, стремление intention, aspiration;
вориготой смелый, храбрый courageous, daring, brave;
вориготой тулалдах сражаться храбро fight courageously;
ворииүй несмелый, нерешительный weak-willed, irresolute
вориг бүхнийг ялна смелость города берёт courage overcomes all obstacles.

БОРИЛГО цель, намерение, задача aim, task, goal, target, purpose;
тодорхой зорилго ясная цель clear aim;
гол зорилго, үндсэн зорилго главная цель, основная задача the main task, chief aim;
ээлжит зорилго очередная задача immediate task
цаашдын зорилго дальнейшая задача further task;
зорилго тавих ставить задачу, поставить цель put a task, set an aim, set the task;
өөртөө зорилго тавих, өөнөө зорилго тавих поставить задачу перед собой, ставить себе целью set oneself the task, undertake the task, set oneself as an object;
зорилгодоо хүрэх достичь цели achieve one's object, gain one's object;
зорилгод таарах / тохирох отвечать цели answer the purpose;
ямар зорилгоор с какой целью for what purpose;
зорилготой байх иметь целью have for an object;
зорилгоор с целью, в целях for the purpose, with a view.

ЗОРИЛТ см. Зорилго see Зорилго.

ЗОРИМОГ смелый, отважный, решительный resolute, bold wilful; decided.

ЗОРИУД намеренно, нарочно, с целью, умышленно, специально intentionally, premeditatedly, purposely; especially;
зориуд хийх сделать нарочно do purposely;
зориуд хэлэх сказать преднамеренно нарочно say intentionally.

ЗОРИУЛАГДАХ посвящаться, быть посвященным be devoted, be dedicated

ЗОРИУЛАХ 1) посвящать, предназначать devote, dedicate, allocate;
2) направлять, устремлять direct toward;
өөрийгөө зориулах, биеэ зориулах посвящать себя devote oneself;
анхаарлаа зориулах обращать внимание direct one's attention to;
шинжлэх ухаанд амьдралаа зориулах посвящать свою жизнь науке devote one's life to science;
хүчээ зориулах направлять / отдать силы direct one's energies.

ЗОРИХ 1) стремиться, намереваться intend, strive;
2) направляться move in the direction of, make one's way (to), direct one's steps (to, into);
зорьсондоо хүрэх достичь цели achieve one's object, reach one's aim.

ЗОРОХ строгать, обстругивать shave off, plane, pare off;
хутгаар зорох обстругивать ножом pare off with a knife;
мод зорох резать по дереву carve in wood.

ЗОРЧИХ шествовать, идти, ехать walk, go, travel.

ЗОРЧИГЧ пассажир passenger, traveller.

ЗОХИОГЧ создатель, творец, автор creator; author;
зохиогчийн эрх авторское право copyright.

ЗОХИОЛ сочинение, произведение, создание, творение work, writting composition, production; creation;
ардын аман зохиол устное народное творчество, фольклор folklore
сонгодог утга зохиол классическая литература classical literature;
түүвэр зохиол избранные произведения selected works;
үргэлжилсэн үгийн зохиол прозаическое произведение, проза prose,
хөгжмийн зохиол музыкальное произведение musical composition;
хүүхдийн зохиол детская литература juvenile literature;
шог зохиол сатира satire;
ном зохиол книги works, books.

ЗОХИОЛЧ писатель, автор, составитель writer, author;
залуу зохиолч молодой писатель young writer;
уран зохиолч писатель writer;
жүжгийн зохиолч драматург playwright, dramatist;
хөгжмийн зохиогч композитор composer.

ЗОХИОХ сочинять, создавать, творить, конструировать write, compose, create, construct;
шүлэг зохиох сочинять стихи write verses;
ая зохиох написать музыку, сочинять мелодию compose a song, write a music;
зохион бүтээх конструировать, создавать construct, create, invent;
зохион бүтээгч создатель, конструктор creator, inventor, designer;
зохион байгуулах организовывать organize, arrange;
зохион байгуулалт организация, структура organization, construction;
зохион байгуулагч организатор organizer.

ЗОХИОМОЛ искусственный artificial;
зохиомол хээлтүүлэг искусственное осеменение artificial insemination.

ЗОХИС подходящий случай, уместность, приспособляемость, propriety, suitability;
зохистой подходящий, годный, соответствующий proper, right; suitable;
зүй зохисоор нь соответствующим образом act accordingly;
зохистой үе подходящий момент right moment;
зохисгүй неподходящий, несоответствующий, недопустимый unsuitable, inappropriate, disagreeable.

ЗОХИХ соответствовать, подходить, годиться suit, fit, be suited, be appropriate;
зохих арга хэмжээ авах принимать соответствующие меры take appropriate measures;
зохих хугацаа соответствующий срок, подходящее время the right time, the right moment;
зохих хэмжээгээр в соответствующей мере in some degree;
тэгвэл зохино следует сделать так; так надо (one) should do (it) that way;
зохихгүй несоответствующий, неподходящий inappropriate, unfit, improper.

ЗОХИЦОХ соответствовать, совпадать, согласовываться, быть в согласии suit, fit, coincide, agree, conform, be harmonious, be in agreement;

ЗОХИЦУУЛАХ приводить в соответствие bring into harmony, brind to conformity.

ЗОЧИН, ЗОЧИД гость, гости guest, guests, visitor;
зочин хүлээн авах принимать гостей receive guests;
вочноор очих идти в гости visit, pay a visit;
хүндэт зочин почётный гость guest of honour;
зочид буудал гостиница hotel, inn;
зочдын өрөө гостиная guest room, sitting room;
гадаадын зочид иностранные гости foreign visitors.

ЗОЧЛОМТГОЙ гостеприимный hospitable,
зочломтгой байдал, зочломтгой зан гостеприимство hospitality.

ЗОЧЛОХ 1) гостить, быть в гостях be on a visit;
2) принимать гостей, угощать гостей receive guests, receive visitors.

ЗОЧМОГ внезапно, вдруг suddenly, all of a sudden;
зочмог уур горячность, вспыльчивость hostiness, hot-tempered, quick-tempered.

ЗӨВ 1) правильный, верный, справедливый, точный right, true, correct, exact;
2) правый right;
зөв буруу справедливость, ошибочность и безошибочность justice, right and wrong;
зөв шийдвэр правильное решение sound decision, correct decision;
зөв шаардлага справедливые требования just demands;
зөв зам верный путь the true way;
зөв бичих дүрэм орфография, правописание spelling;
маш зөв, тун зөв совершенно верно quite right;
таны зөв вы правы you are right;
цаг зөв явж байна часы идут правильно the watch is right;
хэлэх нь зөвсөн было бы правильно сказать it would be true to say;
зөв тал правая сторона right side;
зөв гар правая рука right hand;
нар зөв эргэх поворачиваться по часовой стрелке move round clockwise.

ЗӨВДӨХ, ЗӨВТӨХ быть правильным, оказываться верным, оправдываться be correct, come true, justify oneself.

ЗӨВЛӨГЧ советник, консультант, советчик adviser, counsellor, consultant;
техникийн зөвлөгч технический советник technical adviser

ЗӨВЛӨЛ Совет soviet, council;
Сайд нарын Зөвлөл Совет Министров Council of Ministers;
Аюулгүйн Зөвлөл Совет Безопасности Security Council;
Эдийн Засгийн Харилцан Туслалцах Зөвлөл Совет Экономической Взаимопомощи the Council for Mutual Econmic Assistance;
Дээд Зөвлөл Верховный Совет Supreme Soviet;
Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл Центральный Совет Профессиональных Союзов Central Council of Trade Unions.

ЗӨВЛӨЛГӨӨН, ЗӨВЛӨГӨӨ совещание, совет, консультация conference, meeting; advice, consultation;
ажилчдын зөвлөгөөн совещание рабочих worker's meeting;
эмчийн зөвлөгөө врачебная консультация medical advice;
эмэгтэйчүүдэд зөвлөгөө өгөх газар женская консультация maternity consultation;
хуулийн зөвлөгөө өгөх газар юридическая консультация legal consultation office;
зөвлөгөө өгөх давать совет, советовать advise.

ЗӨВЛӨЛДӨХ 1) совещаться, консультироваться deliberate, consult, take counsel.
2) совещательный, консультативный consultative, deliberative;
Зөвлөлдөх хороо Консультативный комитет consultative committee;
зөвлөлдөх уулзалт консультативная встреча consultative meeting;
хоорондоо зөвлөлдөх советоваться между собой консультироваться друг с другом take counsel, consult to each other;
янз бүрийн асуудлаар зөвлөлдөх проконсультироваться по разным вопросам consult together on various question.

ЗӨВЛӨЛТ советский Soviet;
зөвлөлт засаг советская власть soviet power;
зөвлөлт төр советское государство Soviet state.
Зөвлөлт Холбоот Улс Советский Союз the Soviet Union;
Зөвлөлтийн засгийн газар советское правительство Soviet government;
зөвлөлтийн шинжлэх ухаан советская наука the soviet science.

ЗӨВЛӨМЖ рекомендация recommendation.

ЗӨВЛӨХ 1) советовать, рекомендовать, советоваться consult, deliberate, advise, recommend;
2) консультант, советник consultant, adviser, counsellor;
зөвлөх эрх право совещательного голоса deliberative vote;
тэр надад зөндөө зөвлөв он мне дал много советов he gave me many pieces of advice;
элчин сайдын яамны зөвлөх советник посольства councellor of the Embassy;
зөвлөх эмч врач-консультант consulting physician.

ЗӨВТГӨХ делать правильным, исправлять, оправдывать make correct, justify, acquit;
өөрийгөө зөвтгөх оправдывать себя prove its value, demonstrate its value.

ЗӨБХӨН только, лишь only, merely;
би зөвхөн мэдэх гэсэн юм я только хотел узнать I only wanted to know;
зөвхөн ах л мэднэ только брат знает only my brother knows it.

ЗӨВШӨӨРӨЛ разрешение, согласие, санкция permit, permission, sanction
таны зөвшөөрлөөр с вашего разрешения with your permission.
зөвшөөрөл өгөх давать разрешение give permission;
зөвшөөрөл авах взять разрешение take permission
зөвшөөрөл гуйх просить разрешение ask permission;
зөвшөөрөлгүй без разрешения without permission;
зөвшөөрөлтэй с разрешением, with permission.

ЗӨВШӨӨРӨХ разрешать, санкционировать, соглашаться permit, allow, approve, consent, agree;
хүлээн зөвшөөрөх признавать, осознавать recognize, concede;
буруугаа хүлээн зөвшөөрөх признавать вину, признавать себя виновным plead guilty;
засгийн газрыг хүлээн зөвшөөрөх признавать правительство recognize the government,
над зөвшөөрнө үү? разрешите мне allow me;
тамхи татахыг зөвшөөрнө үү? разрешите закурить? do you mind my smoking?

хурал нээхийг зөвшөөрнө үү? разрешите объявить заседание открытым allow me to delibrate the meeting open;
эс зөвшөөрөх/зөвшөөрөхгүй байх не разрешать,не соглашаться do not permit, do not agree.

ЗӨГИЙ пчела bee;
зөгийн үүр пчелиный улей beehive;
зөгийн аж ахуй пчеловодство bee-keeping, apiculture;
зөгийн үржүүлэгч пчеловод bee-master, apiarist;
зөгийн бал мёд honey;
хатан зөгий пчелиная матка queen bee.

ЗӨГНӨХ предчувствовать, предвидеть predict, portent, have apresentiment, have a foreboding, foreknow;
бороо зөгнөх предчувствовать дождь have a presentiment of rain

ЗӨН предчувствие, предвидение, предзнаменование, чутьё presentiment, portent, forsight, omen;
зөн билэг инстинкт, предвидение prescience, wisdom, instinct;
муу зөн дурное предчувствие bad omen, ill omen;
зөн билэгт итгэх верить предчувствиям indulge in premonitions.

ЗӨНДӨӨ очень много, большое количество, уйма great number, many, much, a lot of, plenty of;
зөндөө олон ном; зөндөө их ном очень много книг a great many books, a large number of books;
зөндөө их ажил очень много работы very, much work, a great deal of work;
зөндөө юм мэдэх знать очень многое know a great deal, know a lot;
надад хийх юм зөндөө байна, би зөндөө их юм хийх хэрэгтэй байна мне нужно очень многое сделать I have a number of things to do, I have a lot of things to do

ЗӨӨГ остывший cooled;
зөөг цай остывший чай cooled tea.

ЗӨӨГЧ носильщик, возчик carrier, porter;
ачаа зөөгч грузчик loader;
хоол зөөгч официант, официантка waiter, waitress;
ус зөөгч водовоз water-carrier.

ЗӨӨЛӨН мягкий, нежный, тихий soft, mild, gentle; tender;
зөлдэг зөөлөн харьцаа вежливое отношение kind treatment;
намуун зөөлөн нежный gentle;
зөөлөн дуутай мягкий голос, приятный голос soft-voiced;
зөөлөн зан мягкий характер gentle disposition;
зөөлөн сэтгэл мягкое сердце soft heart;
зөөлөн харц нежный взгляд tender look;
зөөлөн салхи легкий ветерок gentle breeze
зөөлөн уур амьсгал мягкий климат gentle climate;
зөөлөн сандал мягкое кресло easy-chair;
зөөлөн вагон мягкий вагон soft-seated carriage;
зөөлөн гийгүүлэгч мягкий согласный, soft consonant;
зөөлний тэмдэг мягкий знак soft sign;
зөөлөн явах ехать тихо, идти медленно go softly, walk softly.

ЗӨӨЛРӨХ смягчаться, размягчаться, становиться мягким, становиться тихим /слабым become soft, grow softer, soften, grow mild; weak.

ЗӨӨЛРҮҮЛЭХ смягчать, размягчать, ослаблять soften, make soft;
шийтгэлийг зөөлрүүлэх смягчать наказание mitigate a punishment.

ЗӨӨЛХӨН мягкий; мягче, нежный, тихонький soft, rather, soft, tender, light;
зөөлхөн дэр мягкая подушка soft pillow

ЗӨӨХ таскать, возить, транспортировать carry over, convey, take-transport;
машинаар ачаа зөөх перевозить грузы на машине trans port load by lorry;
ус зөөх таскать воду fetch water;
эдгээр номыг тэр хааш нь зөөж байна? куда он тащит эти книги? where is he carrying these books?
◇ *хов зөөх* сплетничать, заниматься сплетнями tell tales, talk scandal.

ЗӨӨХИЙ сметана, сливки sour cream.

ЗӨРЛӨГ перекресток crossing;
замын зөрлөг перекресток дороги cross-road.

ЗӨРӨГ тропа, тропинка path;
зөрөг замаар явах идти тропинкой, идти по тропинке follow the path.

ЗӨРӨЛДӨӨН противоречие, разногласие difference, dispute, disagreement, discord;
үзэл санааны зөрөлдөөн разногласие во взглядах difference of opinion;
тэд хоорондоо зөрөлдөөнтэй между ними разногласие they are in disagreement
зөрөлдөөнийг арилгах устранить разногласие settle the differences, resolve the differences.

ЗӨРӨЛДӨХ 1) перемещаться друг около друга, передвигаться друг мимо друга be changed around, be transposed around
2) противоречить, иметь разногласие dispute, contradict, disagree
үнийн зөрөө разница в цене difference in price;

ЗӨРӨӨ разница, разногласие difference, disparity, discord;
их зөрөө огромная разница great difference;
насны зөрөө разница в годах disparity in age

ЗӨРӨХ 1) разъехаться, разминуться pass each other, miss each other, cross each other;
2) не соответствовать, противоречить, возражать, не подчиняться disagree, contradict, be disobident, refuse;
хоёр машин арай гэж зөрөхүйц тийм нарийн гудамж юм улица так узка, что автомобили с трудом могут разъехаться the street is so narrow, that two cars can hardly pass each other;
түүний ам ажил хоёр зөрж байна его слова противоречат его действиям his actions belie his words;
хажуугаар зөрөх проходить мимо go by, pass
үгнээс зөрөх возражать советам; не послушаться слов disobey an order, refuse to take advice.

ЗӨРҮҮ см. **зөрөө** see **зөрөө**.

ЗӨРҮҮД упрямый obstinate, stubborn,
зөрүүд зан упрямство obstinacy, stubbornness;
зөрүүд хүүхэд упрямый ребёнок obstinate child;
зөрүүд хүн упрямец, упрямица stubborn person

ЗӨРЧИГЧ нарушитель disturber, infringer;
хил зөрчигч нарушитель границ tresspasser,
хууль дүрэм зөрчигч, дэглэм журам зөрчигч нарушитель закона, правонарушитель transgressor, offender, deliquent.

ЗӨРЧИЛ противоречие, конфликт contradiction, opposition, conflict;
эвлэршгүй зөрчил непримиримые противоречия irreconsilable contradictions;
ангийн зөрчил классовые противоречия class contradictions;
капитализмын зөрчил противоречия капитализма contradictions of capitalism;
зөрчилтэй противоречивый contradictory, conflicting;
зөрчилгүй не противоречивый, без противоречия without contradiction

ЗӨРЧИЛДӨХ противоречить друг другу contradict one another;
үнэн байдалд зөрчилдөх, бодит байдалд зөрчилдөх противоречить действительности be at variance with the facts;
бие биедээ зөрчилдөх противоречить друг другу clash with each other.

ЗӨРЧИХ нарушать, не соблюдать, беспокоить disturb, break, violate, disobey;
дүрэм зөрчих нарушать правила disobey the rules;
хууль зөрчих нарушать закон infringe, offend against the law;
тангараг зөрчих нарушать клятву/ присягу break one's oath;
гудамжны хөдөлгөөний дүрэм зөрчих нарушать правило уличного движения infringe the traffic regulations;
амгалан тайван байдлыг зөрчих/эвдэх беспокоить, нарушать покой worry, trouble;
нийгмийн хэв журам зөрчих нарушить общественный порядок break the public peace.

ЗУГАА развлечение, веселье, забава amusement, entertainment, diversion;
зугаа гаргах развлекаться amuse oneself;
зугаатай развлекательный, забавный, веселый amusing, entertaining, pleasant;
зугаатай хүн забавный человек amusing person;
хүүхдийн зугаа детская забава child's play.

ги тропинкой, идти по тропинке follow the

ЗУГААЛАХ гулять, развлекаться, забавляться, веселиться make merry, go for a walk, take a walk, amuse oneself;
тэр цэцэрлэгт зугаалж явна он гуляет в парке he i taking a walk in the park.

ЗУГААЛГА прогулка, гулянье, пикник walking, taking a walk, outing, picnic.

ЗУГТАХ бежать, обращаться в бегство, удирать flee, run away, escape, evade.

ЗУЗААН толстый; толщина thick; thickness;
зузаан ном толстая книга a thick book;
зузаан нь таван сантиметр толщина пять сантиметров it is five centimeteres thick.

ЗУЛГААХ теребить, выдёргивать, рвать, выдирать, полоть pull, pull out pluck;
өвс зулгаах полоть траву pull out grass
үсээ зулгаах теребить волосы tousle the hair.

ЗУЛЗАГА детёныш животных young one, cub.

ЗУН лето summer;
зун цаг летнее время summer time;
зуны амралт летние каникулы summer vacation, summer holiday;
зуны халуун өдөр жаркий летний день hot summer day.

ЗУРААС черта, линия, тире line, stroke, dash;
зураас гаргах проводить черту draw a line.

ЗУРААЧ художник, рисовальщик, чертёжник painter, graphic artist, draughtsman;
уран зураач художник, живописец painter,

ЗУРАГ рисунок, картина, снимок, фотография, портрет, чертёж drawing, painting, picture, map, illustration, photograph sketch;
вураг зурах рисовать, писать картину draw, picture, sketch;
вураг авах снимать, фотографировать photograph, take a photograph;
зураг буулгах копировать copy;
шугам зураг черчение drawing;
шог зураг карикатура, шарж caricature, cartoon,
вургийн дэвтэр тетрадь для рисования drawing book;
зургийн аппарат фотоаппарат camera;
зурагтай сэтгүүл иллюстрированный журнал illustrated magazine.

ЗУРАГЧИН фотограф photographer.

ЗУРАХ рисовать draw, picture, paint;
харандаагаар зурах рисовать карандашом draw with a pencil;
гарын үсэг зурах расписаться, подписать sign, put one's signature.

ЗУРВАС 1) полоса stripe;
2) записка note;
вурвас газар полоса земли zone.

ЗУРГААН шесть six;
вургадугаар шестой sixth;
чи зургаан цагт ирээрэй ты приходи в шесть часов you come at six o'clock.

ЗУСАРДАХ льстить, подхалимствовать, flatter, fawn, decive.

ЗУСАРЧ подхалим, льстец, льстивый flatterer, flattering.

ЗУСАХ проводить лето pass the summer.

ЗУУ, ЗУУН 1) сто hundred;
2) век, столетие century;
вуу мянга сто тысяч hundred thousand;
зуун жил сто лет hundred years;
дундад зуун средний век Middle age;
хорьдугаар зуун двадцатый век twentieth century

ЗУУВАН овальный oval.

ЗУУР 1) дорогой, по пути along the way;
2) во время, когда, между тем как, при while, when, during the time;
гэр зуур байх находиться дома, никуда не идти be at home;
вам зуур в пути, по дороге on the road, on the way;
тур зуур кратковременно, временно temporarily, for a moment;
нүд ирмэх зуур моментально, вмиг in a twinkling;
хоромхон зуур, агшин зуур мгновенно, моментально in a flash, in a moment, in a very, short time
наашаа ирж явах зуураа когда шёл сюда when was going here.

ЗУУРАЛДАХ не отделяться друг от друга hold on each other firmly

ЗУУРАХ I месить, мешать mix, knead, puddle;
гурил зуурах месить тесто knead dough;
шавар зуурах месить глину puddle a clay.

ЗУУРАХ II цепляться; сжимать, зацепившись, держаться, непроизвольно стискивать catch, snatch, jam, be locked, close tightly;
шүд зуурах непроизвольно стискивать зубы have a lockjaw;
гараас зуурах цепляться за руку catch at hand.

ЗУУРД промежуточный, средний, преждевременный intermediate, intervening; premature, intime;
зуурдаар нас барах преждевременно скончаться die prematurely; die before one's time;
вуурдаар преждевременно before the time, untimely.

ЗУУХ I печь, печка stove, oven;
төмөр зуух железная печка iron stove;
гал зуух кухня kitchen.

ЗУУХ II держать в зубах, схватывать зубами catch in mouth, seize with a teeth.

ЗУУХ III *амь зуух* жить, существовать live, exist

ЗУУЧЛАХ посредничать act as a go-between, mediate, come in between.

ЗУУШ закуска snack, refreshments;
хүйтэн зууш холодная закуска cold dish;
хөнгөн зууш лёгкая закуска light repast, snack;
зуушны газар закусочная snack-bar.

ЗҮГ сторона, направление side, direction;
зүг чиг направление direction;
зүг бүрт во всех направлениях in all directions;
зүг бүрээс со всех сторон from all girections;
аль зүгээс салхилж байна? с какой стороны ветер? from what quater is the wind blowing?
салхи зүүн зүгээс үлээж байна ветер дует с восточной стороны the wind blows from the East;
зүг чигээ олох ориентироваться get one's bearings;
зүг чигээ алдах потерять ориентировку lose one's bearings

ЗҮГГҮЙ шаловливый, прока́зливый playful, mischievous;
зүггүй хүүхэд проказливый ребёнок prankish child.

Зүглүүлэх направлять direct toward, direct.

ЗҮГЛЭХ держать направление, направляться direct one's way(towards) make one's way (to), head for;
баруун зүг зүглэн явах идти на запад, держать направление на запад, head for the West.

ЗҮГЭЭР 1) обыкновенный, простой, обычный; сносный ordinary, simple, good;
2) ничего, так себе; просто так does not matter, all right; so-so; to no purpose, for no particular reason;
3) бесплатно, даром, безвозмездно free of charge, gratis;
зүгээр зантай хүн человек со сносным характером good-natured person;
зүгээр залуу хороший парень, простой парень nice fellow, good fellow, ordinary boy;
зүгээр бай! оставь! не балуйся; stop it, don't be naughty!
зүгээр, зүгээр ничего, ничего don't mention it, it is all right
зүгээр, яахав ну, так себе so-so;
зүгээр суух сидеть без дела, сидеть просто так, ничем не занимаясь live in idleness, do nothing;
зүгээр авах брать бесплатно obtain free of charge;
зүгээр өгөх давать даром, дать бесплатно give free of charge;
зүгээр болох стать обычным, становиться нормальным become normal, recover.

ЗҮГЭЭРГҮЙ необыкновенный, необычный unusual, uncommon;
зүгээргүй сайн необыкновенно хороший, довольно хороший unusually fine, rather good.

ЗҮДРЭХ изнуряться, изматываться, изнемогать, утомляться be exhausted, suffer, be tired;
тэр халуунд зүдэрч явна он изнемогает от жары he is exhausted with the heat.

ЗҮДРЭЭХ изнурять, изматывать утомлять cause hardships, exhaust, weat, out, overwork.

ЗҮДҮҮ бедный, нищий poor;
ядуу зүдүү амьдрал бедная жизнь, нищая жизнь poor life; indigent life;
ядуу зүдүү аж төрөх жить в бедности live in poverty.

ЗҮДҮҮР изнурение, изнеможение, усталость exhaustion, hardship, fatigue;
зовлон зүдүүр мучение, мука, страдание suffering, hardship.

ЗҮДЭРГЭЭ утомление, изнеможение weakening, tiredness, fatigue;
зүдэргээтэй ажил утомительная работа, изнурительная работа hard work, exhausting work.

ЗҮЙ сущность; принцип, приличие, пристойность point; principle, propriety, decency;
зүй бус непристойный; незаконный improper; irregular, illegal;
зүй зохис должный порядок proper order;
зүй тогтоол закономерность law, regularity, conformity with a law;
учир зүй суть, сущность, причина point, essence, cause; reason;
хэргийн учир зүй суть дела the essence of matter, the point of matter;
арга зүй методология, метод methodology, method;
хэлзүй грамматика grammar.

ЗҮЙЛ 1) сорт, род, разряд, категория, вид sort, kind, species, category;
2) статья, пункт, параграф; вопрос article, item, point, paragraph; question;
3) вещь, предмет thing;
4) явление, случай occurence;
элдэв зүйлийн бараа всякого рода товары all kinds of goods;
архины зүйл алкогольные напитки alcoholic drinks;
эмийн зүйл медикаменты medicines;
хоол хүнсний зүйл продовольственные товары articles of food;
зүйл бүрийн, янз бүрийн всякого рода, всякие, различные of all kinds;
хэрэгцээний зүйлс предметы потребления objects of consumption;
хуулийн зүйл анги статья закона an article of law;
нэгдүгээр зүйл первый параграф the first paragraph;
хэлэлцэх зүйл повестка дня; вопросы, подлежащие обсуждению agenda;
жижиг зүйл мелочь, мелкие вещи small things;
өөр зүйл другой предмет, что-то другое another thing, something else;
жирийн зүйл обычное явление everyday occurence;
хачин зүйл, жигтэй явдал странное явление strange thing.

ЗҮЙМЭЛ составленный из отдельных кусков, составной pieced together, compound;
зүймэл шал паркет parquet.

ЗҮЙР: *зүйр үг* поговорка proverb.

ЗҮЙРЛЭЛ сравнение comparision.

ЗҮЙРЛЭХ сравнивать, сопоставлять compare;
чамтай зүйрлэхгүй не сравним с тобой, не сравнить с тобой cannot be compared with you.

ЗҮЙРЛЭШГҮЙ, ЗҮЙРГҮЙ несравнимо, несравненно incomparable, far, by far;
зүйрлэшгүй сайн несравненно лучше far better.

ЗҮЙТЭЙ верный, правильный, целесообразный, справедливый right, correct, proper, expedient, true, just;
зүйтэй шийдвэр правильное решение sound decision;
зүйтэй арга хэмжээ справедливые меры presise measures;
энэ туйлын зүйтэй это совершенно справедливо this is especially true;
зүйтэй гэж үзэх считать целесообразным, считать правильным consider as right.

ЗҮЙХ составлять из отдельных частей join together, put together from various pieces.

ЗҮЛГЭХ тереть, обтирать, чистить, полировать rub, brush, scour; polish;
гутал цэвэрлэж зүлгэх, гутал арчиж зүлгэх чистить обувь polish shoes.

ЗҮЛЭГ луг, мурава meadow, grass.

ЗҮРХ 1) сердце heart;
2) храбрость, смелость courage, bravery;
зүрхний цохилт сердцебиение palpitation;

зүрхний гэм порок сердца heart disease;
зүрх дэлбэрэх разрыв сердца heart-failure;
чин зүрхний үгаас от всего сердца from the bottom of one's heart;
чин зүрхний баяр чистосердечный привет cordial thanks, sincere gratitude;
зүрх алдах, зүрх үхэх, зүрх шантрах робеть, трусить, не осмеливаться, бояться be discouraged, lose courage, be afraid, be timid;
зүрх орох набраться храбрости Pluck up one's courage;
зүрх гаргах осмеливаться, отважиться; рисковать dare, risk;
зүрхний амраг любимый человек, возлюбленный beloved person.

ЗҮРХЛЭХ набраться смелости, отважиться; рисковать pluck up one's courage, dare; risk.

ЗҮРХШИХ, ЗҮРХШЭЭХ робеть, не решаться, трусить, бояться be timid, not dare, be afraid.

ЗҮС внешность, внешний вид, цвет кожи, лицо; масть appearance, feature, colour; face; coat;
зүс царай лицо, внешний вид face, appearance;
өнгө зүс цвет и внешность colour and appearance;
зүс үзсэн хүн знакомое лицо familiar face;
зүс бүрүү необычной масти unusual colour;
зүсэн бүрийн всякий, различный; всех мастей various, different, of all kinds; of every stipe.

ЗҮСЭМ кусок, ломоть slice hunk;
зүсэм талх кусок хлеба a hunk of bread;
зүсэм зүсмээр хуваах разбить на куски break to pieces

ЗҮСЭХ резать ломтями, разрезать в длину, нарезать cut, cut into strips, slice, slit;
үртааш нь зүсэх разрезать вдоль slit;
талх зүсэх нарезать хлеб cut a bread.

ЗҮТГЭЛ усилие, усердие, старание, endeavor, effort, zeal;
гавьяа зүтгэл заслуга merit;
хичээл зүтгэл усердие diligence;
зүтгэл гаргах прилагать усилие make efforts;
зүтгэлтэй ажиллах работать с усердием work with zeal.

ЗҮТГЭЛТЭЙ усердный, старательный zealous, diligent.

ЗҮТГЭЛТЭН деятель person who achieve great success in certain field of work;
төрийн зүтгэлтэн государственный деятель statesman;
улс төрийн зүтгэлтэн политический деятель political figure;
шинжлэх ухааны зүтгэлтэн деятель науки scientist, man of science;
урлагийн гавьяат зүтгэлтэн заслуженный деятель искусства honoured art worker;
соёлын зүтгэлтнүүд культурные деятели cultural workers.

ЗҮТГЭХ тянуть, тащить, напрягаться, стараться, усердствовать, стремиться pull, drag; endeavour, persist, exert oneself, strain oneself, strive;
зүтгэх мал тягловый, тягловой скот, рабочий скот draught animal;
чармайн зүтгэх усердствовать exert oneself, make an effort;
хүчин зүтгэх напрягать силы, прилагать усилия exert one's strength-strain every effort, give one's strength to.

ЗҮҮ игла, иголка, стрелка needle; hand;
зүүний сүвэгч ушко иглы, игольное ушко, needle's eye;
нэхмэлийн зүү вязальная игла knitting-needle;
тариани зүү игла для укола hypodermic needle;
сүлбээр зүү булавка английская safety pin;
цагийн зүү стрелка часов hour hand.

ЗҮҮД сон, сновидение dream;
зүүд зүүдлэх видеть во сне have a dream, see in a dream;
энэ түүний зүүдэнд ч орооғүй ажээ ему это и во сне не снилось he never dreamt of it.

ЗҮҮДЛЭХ сниться, видеть сон dream, have a dream.

ЗҮҮН восток, восточный, левый east; eastern; left;
хотын зүүн хэсэг восточная часть города east part of a town;
зүүн хил хязгаар восточная граница eastern frontier;
зүүн зүг восток; восточный east; eastern;
зүүн гар левая рука left hand;
зүүн тал левая стороны left side;
зүүний нугалаа левый уклон leftist deviation

ЗҮҮРМЭГЛЭХ вздремнуть, дремать take a nap, doze off;

ЗҮҮХ привешивать, пристегивать, нацеплять, носить, надевать hang up; put on, wear, carry;
одон зүүх носить орден carry an order;
нүдний шил зүүх, сарвч зүүх надевать очки wear spectacles;
цаг зүүх носить часы carry a watch;
бөгж / бэлзэг зүүх надевать/ носить кольцо wear rings;
буу зэвсэг зүүх носить оружие carry arms.

ЗҮХЭЛ проклятие, брань damnation, curse scolding.

ЗҮХЭХ проклинать, ругать, бранить damn, curse, scold.

ЗЭВ ржавчина rust;
зэвд идэгдсэн изъедённый ржавчиной eaten away with rust;
зэвтэй хадаас ржавая гвоздь rusty nail

ЗЭВРҮҮН прохладный cool, chilly, cold;
өнөөдөр нэлээд зэврүүн байна сегодня довольно холодно it is rather cold today.

ЗЭВРЭХ ржаветь rust.

ЗЭВСЭГ 1) оружие arm, weapon;
2) орудие, инструмент, приспособление, инвентарь instrument, implement, tool;
зэр зэвсэг оружие arm, weapon;
галт зэвсэг огнестрельное оружие firearms;
хүйтэн зэвсэг холодное оружие cold steel, silent weapons;
атомын зэвсэг, атомное оружие atomic weapons;
цөмийн зэвсэг ядерное оружие nuclear weapons;
стратегийн зэвсэг стратегическое оружие strategic arms;
бактериологийн зэвсэг бактериологическое оружие bacteriological weapons;
хүнийг үй олноор устгах зэвсэг оружие массового уничтожения weapons of mass destruction;
зэвсэг барих браться за оружие take up arms;
зэвсгээ хураалгах, зэвсгээ хаях сложить оружие, положить оружие lay down arms;
зэвсгийн агуулах арсенал armoury, arsenal;
хөдөлмөрийн багаж зэвсэг орудие труда implements, tools;
үйлдвэрлэлийн багаж зэвсэг орудие производства instruments of production;
хөдөө аж ахуйн багаж зэвсэг сельскохозяйственные орудия agricultural implements;
хөгжмийн зэвсэг музыкальные инструменты musical instruments;
хүрэл зэвсгийн үе бронзовый век the bronze age;
чулуун зэвсгийн үе каменный век the stone age.

ЗЭВСЭГЛЭЛ вооружение armament;
зэвсэглэлээр хөөцөлдөх гонка вооружений arms race;
зэвсэглэлийг хорогдуулах сокращать вооружение, сокращение вооружения reduce armaments;
зэвсэглэлийг бүх нийтээр бүрэн хураах всеобщее и полное разоружение general and complete disarmaments.

ЗЭВСЭГЛЭХ вооружаться, вооружать, снабжаться вооружением arm, prepare arm; equip;
орчин үеийн техникээр зэвсэглэсэн вооружённый современной техникой armed with modern technical means;
мэдлэгээр зэвсэглэх вооружаться знаниями arm oneself with knowledge;
шүдээ хүртэл зэвсэглэсэн вооружённый до зубов armed to the teeth.

ЗЭВСЭГТ вооружённый armed;
зэвсэгт хүчин вооружённые силы armed forces;
зэвсэгт бослого вооруженное восстание armed revolt;
зэвсэгт мөргөлдөөн вооружённый конфликт, вооружённое столкновение armed conflict.

ЗЭВҮҮ, ЗЭВҮҮЦЭЛ возмущение, негодование, отвращение, омерзение indignation, aversion, repugnance, disgust;
зэвүү хүрэх, зэвүүцэл төрөх испытывать отвращение, прийти в негодование loathe, have an aversion, become indignant, be disgusted;
зэвүү хүргэх, зэвүүцэл төрүүлэх внушать отвращение, вызывать омерзение, привести в негодование fill with disgust, inspire with loathing, make indignant

ЗЭВҮҮН возмутительный, отвратительный, отталкивающий, омерзительный, страшный scandalous, disgraceful, disgusting ,repulsive, loathsome terrible;

зэвүүн үнэр отвратительный запах repulsive smell;
зэвүүн харц возмущённый взгляд indignant glance.

ЗЭВҮҮЦЭХ испытывать отвращение, негодовать be disgusted, be indignant.

ЗЭВХИЙ бледный; бескровный pale, ashy; bloodless.

ЗЭЛЛЭХ привязать к протянутой верёвке tie cattle the tethering place;
зэллэн нисэх лететь, двигаясь вереницей fly in a straight line.

ЗЭЛҮҮД безлюдный uninhabited, disolate;
зэлүүд газар пустырь, безлюдное место waste land, desolate place.

ЗЭМЛЭЛ порицание, наказание, обвинение, замечание blame, reproach, censure; reproof;
зэмлэл хүлээх получать замечание be rebuked, be blamed
зэмлэл хүлээлгэх сделать замечание, порицать rebuke, reprove, blame.

ЗЭМЛЭХ порицать, винить, осуждать, упрекать делать замечание blame, reproach, censure, condemn; rebuke, reprove;
зэмлэн буруушаах осуждать, порицать condemn, blame.

ЗЭРГЭЛДЭЭ соседний; по соседству; параллельный neighbouring, neighbour, in the vicinity, next, near by; parallel;
хөрш зэргэлдээ улс соседняя страна neighbour country;
зэргэлдээ өрөө соседняя комната next room;
айл зэргэлдээ байх / орших быть по соседству, находиться по соседству be in the neighbourhood.

ЗЭРЛЭГ 1) дикий wild;
2) зверский, варварский, жестокий brutal, savage, barbarian;
зэрлэг араатан хищные звери beasts of prey;
зэрлэг амьтан дикое животное wild beast;
зэрлэг гахай кабан wild-boar;
зэрлэг өвс сорняк weed;
зэрлэг сонгино лук алтайский wild altaic onion;
зэрлэгээр бөмбөгдөх варварски бомбить, варварский налёт barbarously bomb, barbarian air raid;
зэрлэг догшин, зэрлэг муухай жестокий, зверский brutal, savage, severe;
зэрлэг сум шальная пуля stray bullet.

ЗЭРЛЭГШИХ дичать, становиться диким grow wild.

ЗЭРЭГ 1) звание, степень, чин, титул rank, class, title, degree;
2) уровень, сорт, степень, категория level, sort, kind, category;
3) как только, одновременно, в тот же момент, сразу; и так далее, и прочие as soon as, simultaneously, together, at that moment; and so on, and others;
зэрэг цол, хэргэм зэрэг звание, титул rank, title;
эрдмийн зэрэг олгох присуждать учёную степень confer a degree, award a degree;
докторын зэрэг докторская степень doctorate, doctor's degree;
зэрэг нэмэх повышение в чине, повышаться в чине promotion, raise in rank;
нэгдүгээр зэрэг первый сорт first degree;
бага зэрэг немного a little, slightly;
хэр зэрэг, аль зэрэг, ямар зэрэг в какой степени, как, какой in what degree, to what degree, how, what kind of
дунд зэрэг мэдэх знать посредственно know satisfactory;
суухтай зэрэг как только сел as soon as sat down;
зэрэг унах падать одновременно fall simultaneously;
гэх зэрэг и так далее, и тому подобное and so on, et cetera (etc).

ЗЭРЭГЛЭЭ мираж mirage.

ЗЭРЭГЦҮҮЛЭХ сравнивать, сопоставлять, ставить рядом compare, place side by side;
зэрэгцүүлэн тавих ставить рядом put side by side.

ЗЭРЭГЦЭХ идти рядом, выстраиваться в ряд, равняться, приравняться go in line, line up, come up to, come alongside, be equal;
хүнтэй зэрэгцэн суух сидеть с кем-либо рядом; сесть рядом с кем-либо sit next to somebody, sit down by somebody;
зэрэгцэн зогсох стоять рядом stand in line;
зэрэгцэн явах идти рядом walk side by side;
мөр зэрэгцэн плечом к плечу shoulder to shoulder, brush against somebody's shoulder;
ан зэрэгцэх равняться, соперничать vie with each other.

ЗЭРЭГЦЭЭ 1) рядом; соседний; параллельный next to, side by side, neighbouring; parallel;
2) одновременно, наряду simultaneously, alongside, side;
үүний зэрэгцээ наряду с этим side by side with this, at the same time;
зэрэгцээ шугам параллельная линия parallel line.

ЗЭС медь copper;
зэсийн хүдэр медная руда copper-ore;
зэсийн үйлдвэр меднорудная промышленность copper industry;
зэс зоос медная монета copper coin.

ЗЭХЭХ приготовить, подготовить prepare.

ЗЭЭЛ I кредит, заём, бес долг credit, loan; debt;
хүүгүй зээл бес процентный заём interest free-loan;
зээл олгох предоставлять кредит give credit;
богино хугацааны зээл краткосрочный заём short credit;
удаан хугацааны зээл долгосрочный кредит long credit;
зээл авах брать в долг take credit, borrow;
зээлээр худалдах торговать кредитом, торговать в кредит sell on credit;
мөнгөний зээлийн систем кредитно-денежная система credit and monatery system.

ЗЭЭЛ II. рынок, базар market, bazaar;
зах зээл рынок market;
нийтийн зах зээл общий рынок common market;
гадаадын зах зээл внешний рынок foreign market;
дотоодын зах зээл внутренний рынок home market.

ЗЭЭЛДЭХ, ЗЭЭЛЭХ брать взаймы, брать в долг, занимать borrow;
мөнгө зээлэх занимать деньги, брать деньги взаймы borrow money;
◆ *нэр зээлдэх* выдавать себя за кого-либо, незаконно использовать чужое имя / в корысных целях) use another's name illegally.

ЗЭЭЛҮҮЛЭХ, ЗЭЭЛДҮҮЛЭХ давать в кредит, давать в долг, ссужать lend, give credit.

ЗЭЭЛЛЭГ заем, ссуда loan, credit.
улсын зээллэг государственный заём state loan;
хонжворт зээллэг выигрышный заём lothery-loan;
хүүтэй зээллэг ссуда с процентами, interest-bearing loan.

ЗЭЭР антилопа antilope.

ЗЭЭРД рыжий red, chestnut.

И

ИВЭХ подкладывать lay:
дугуй дор чулуу ивэх подложить / подставить камень под шину block a wheel with a rock.

ИВЭЭЛ покровительство, эгида, защита, забота, попечение patronage, protection, aegis, care;
ивээлээр под покровительством, под эгидой under the patronage, under the aegis;
нам засгийн ивээлээр благодаря заботе партии и правительства thanks to the care of party and government;
таны ивээлээр под вашим покровительством; благодаря вашей помощи thanks to your protection, thanks to your help.

ИД: *ид дундаа* в разгаре full swing;
ажил ид дундаа явж байна работа идёт в полном разгаре the work is in full swing;
маргааны ид дундуур в разгаре спора at the height of the dispute, in the height of the dispute;
ид зун болж байна лето в разгаре summer is in full swing;
ид насандаа во цвете лет in the prime of life.

ИДЭВХ активность activity;
идэвх санаачилга инициатива initiative;
идэвх чармайлт, идэвх зүтгэл активность, старательность activity;
олон түмний улс төрийн идэвх политическая активность масс political activity of the masses;
ажилд идэвхтэй оролцох активно принимать участие в работе take an active part in the work;

идэвх гаргах проявлять активность, быть активным show energy, be active;
идэвхтэй активный active;
идэвхгүй пассивный passive.

ИДЭВХЖИХ активизироваться, становиться активнее become active, liven up.

ИДЭВХЖҮҮЛЭХ активизировать, стимулировать make more active, stimulate;
олон түмнийг идэвхжүүлэх активировать массы stir to the greater activity;
ажлыг идэвхжүүлэх активизировать работу liven up the work.

ИДЭВХТЭН активист; актив active worker, active member, activist.

ИДЭР молодой, возмужалый young, vigorous;
идэр нас молодость, юность youth.

ИДЭХ 1) есть, кушать, съедать eat, have meals, take meals;
2) разъедать, подтачивать, кариоз carrode, gnaw, rust, caries;
3) присваивать, похищать, растрачивать embezzle, peculate, plunder;
хоол идэх кушать, обедать dine, have a dinner;
мах идэх есть мясо eat a meat;
идэх юм пища, еда; кушанье provisions, foods;
над идэх дур алга я не хочу есть, у меня нет аппетита I have no appetite, I do not want to eat;
, вэв идэх ржаветь, rust;
хорхой идсэн шүд кариозный зуб carious tooth;
улсын мөнгө идэх присваивать государственные деньги take bribes, embezzle public funds.

ИДЭЭ I еда, пища, кушанье food, meat, dish;
цагаан идээ молочный продукт milk products, dairy goods, food made from milk;
идээ амсах отведать/попробовать taste, try.

ИДЭЭ II гной pus, matter
идээт шарх гнойная рана festering wound;
идээ татах вызвать нагноение fester, suppurate.

ИДЭЭЛЭХ нагнаиваться fester, suppurate.

ИДЭЭШИХ приучиться, привыкать, акклиматизироваться become accustomed, become familiar; become acclimatized.

ИЖ: *иж бүрэн* комплект, набор, комплекс, полное собрание complete, a complete set, whole complex;
хөдөө аж ахуйг иж бүрэн механикжуулах комплексная механизация сельского хозяйства complex mechanization of agriculture.

ИЖИЛ одинаковый, равный, подобный, привыкший identical, the same, equal; accustomed;
ив ижил, эгээ ижил совершенно одинаковый, точь в точь, как две капли воды completely alike, exactly the same;
ижил дасал болох привыкать друг к другу, становиться близкими друзьями make friends, become good friends, accustomed to each other.

ИЖИЛГҮЙ бесподобный, беспримерный, несравненный incomparable, unexampled, matchless, peerless;
ижилгүй сайн, ижилгүй дээр несравненно лучше far better.

ИЖИЛДЭХ привыкать друг к другу; стать близкими друзьями get used to, become friends.

ИЖИЛСЭХ быть похожим друг на друга, походить друг на друга be alike.

ИЙМ такой, подобный such, so, like this;
ийм олон так много such a many;
ийм янзаар таким образом, таким путём in such a manner, in this way;
ийм учраас поэтому for this reason, on this account;
иймд, иймийн тул поэтому, ввиду этого therefore, and so.

ИЙМЭРХҮҮ вот такой, такой же, вот так like this, some hing like this, this way.

ИЙНХҮҮ таким образом, вот так in this way, thus.

ИЙШ, ИЙШЭЭ сюда, в эту сторону here, to this side;
ийш тийш туда-сюда in every direction, hi her and thither;
ийшээ суугаарай сядьте сюда sit down here.

ИЛ 1) явный, ясный, открытый, легальный evident, obvious, clear; open, legal;
2) явно, ясно; открыто, легально evidently, obviously; openly, legally;
ил захидал открытка post card;
ил уурхай карьер opencast mine;
ил хэлэх говорить в глаза say to one's face;
ил болох, ил гарах выявляться, быть открытым, стать очевидным come out, become clear;
ил гаргах обнаруживать, сделать ясным make clear.

ИЛБЭ фокус conjuring, trick;
хөзрөөр илбэ үзүүлэх карточный фокус card trick;
илбэ үзүүлэх показывать фокусы juggle, do conjuring tricks.

ИЛБЭЧИН фокусник conjurer, juggler.

ИЛГЭЭЛТ 1) посылка, отправка sending, parcel;
2) послание message;
илгээлт явуулах отправлять посылку post a parcel;
Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэлийн илгээлтээр по путёвкам ревсомола upon the recommendation of the Revolutionary Youth League;
Шинэ жилийн баярын илгээлт Новогоднее приветственное послание New Year's message of greetings.

ИЛГЭЭХ посылать, отправлять, направлять send, dispach;
шуудангаар илгээх посылать по почте send by post;
хүн илгээх отправлять человека dispach a person;
ажилд илгээх направлять/отправлять на работу assign to work;
намайг тань руу илгээлээ меня направили к вам I have been sent to you.

ИЛЖИГ осёл donkey, ass.

ИЛРҮҮЛЭХ разоблачать, обличать, выявлять, обнаруживать expose, reveal, unmask, denounce; make clear;
үгийн утгыг илрүүлэх выявлять значение слова reveal the meaning of the word;
дайн өдөөгчдийг уудлан илрүүлэх разоблачать поджигателей войны unmask the warmongers;
дутагдлыг илрүүлэх выявлять недостатки show up the shortcomings.

ИЛРЭХ выявляться, обнаруживаться, раскрываться; стать очевидным come to light, stand exposed, be revealed, become clear, come into evidence.

ИЛТГЭГЧ докладчик speaker, lecturer, reporter

ИЛТГЭЛ доклад, речь, report, speech, lecture;
тайлан илтгэл отчётный доклад report;
илтгэлийг хэлэлцэх прения по докладам discussion on the report;
илтгэл тавих выступить с докладом, делать доклад make a report, deliver;
илтгэл хийх, илтгэл бэлтгэх подготовить доклад, сделать доклад написать доклад prepare a report.

ИЛТГЭХ докладывать, делать доклад report, lecture, deliver;
илтгэх хуудас докладная записка memorandum, report.

ИЛҮҮ 1) лишний, запасный, излишный, ненужный superfluous, spare, unnecessary, extra;
2) свыше, более, больше more, over, more than;
илүү зардал излишний расход extra expenses;
илүү үг лишние слова unnecessary words;
илүү ажил лишняя работа unnecessary work;
илүү юм ярих/хэлэх говорить лишнее; сказать не то, что надо было talk more than necessary; talk about unnecessary thing;
илүү орон тоо сверхштатный, лишний, дополнительный supernumerary;
илүү тал привилегия, преимущество privilege, advantage;
танд илүү билет байна уу? есть у вас лишний билет? have you spare ticket?
хамаагүй илүү, хавьгүй илүү куда лучше, намного лучше much better, far better;
жил илүү больше (одного) года more than a year;
илүү төлөх переплачивать, заплатить больше денег over-pay;
илүү авах брать больше take more than, take over.

ИЛҮҮДЭХ быть лишним, оказываться излишним; превышать become superfluous, be redundant; exceed;

тогтоосон хэмжээнээс илүүдэх превышать установленную норму exceed the fixed norm;
нэг ном илүүдэж байна имеется лишний экземпляр книги there is a spare book.

ИЛҮҮДЭЛ излишек, остаток surplus; excess, remainder, leftovers.

ИЛЧ теплота, жар heat, warmth;
халуун илч жар heat;
биейн илч температура тела body temperature;
нарны илч солнечная температура heat of the sun.

ИЛЧИТ тепловой thermal, heat;
илчит галт тэрэг тепловоз diesel locomotive.

НӨР *нөр их ажил өрнөв* работа кипит work is in full swing;
нөр их хөдөлмөр, нөр их үйл ажиллагаа кипучая деятельность tireless activity.

НӨХӨД товарищи, друзья friends, comrades;
найз нөхөд друзья friends;
хүндэт нөхөд өө! дорогие товарищи! dear comrades!
зэвсэг нэгт нөхөд товарищи по оружию companion in-arms;
надад олон найз нөхөд бий у меня много друзей I have many friends.

НӨХӨР товарищ, друг; муж comrade, friend; husband;
дотно нөхөр, сайн нөхөр близкий друг, хороший друг intimate friend, close friend, good friend;
итгэлт нөхөр верный друг true friend;
эр нөхөр муж husband;
нөхөр ёсны тусламж дружеская помощь, дружеская услуга friendly help; friendly service.

НӨХӨРЛӨХ дружить, стать друзьями, быть товарищем be friends, make friends.

НӨХӨРСӨГ дружественный, дружеский, товарищеский friendly, comradly
нөхөрсөг уулзалт дружеская встреча; товарищеская встреча friendly meeting, friendly match;
нөхөрсөг харьцаа товарищеские отношения, дружеские отношения comradly relations; friendly relations;
албан ёсны нөхөрсөг айлчлал дружеский официальный визит friendly official visit.

НӨХЦӨЛ I условие, обстоятельство condition, circumstances;
нөхцөл байдал обстоятельство, ситуация circumstances, situation;
амьдралын нөхцөл условия жизни, бытовые условия condition of life, living conditions;
орон сууцны нөхцөл жилищные условия housing conditions;
хөдөлмөрийн нөхцөл, ажлын нөхцөл условия труда conditions of work;
цаг агаарын нөхцөл климатические условия climatic conditions;
байгалийн нөхцөл природные условия natural conditions;
ямар ч нөхцөлд при любых обстоятельствах, ни при каких обстоятельствах under no circumstances;
тухайн нөхцөлд, тийм нөхцөлд при данных обстоятельствах, при таких условиях under the circumstances, in such conditions;
нөхцөлгүй невозможный, невозможно impossible, impossibly.

НӨХЦӨӨХ:
цаг нөхцөөх зря проводить время let the time pass, pass the time.

НӨХЦӨХ, НӨГЧИХ:
нас нөхчих умереть, скончаться pass away.

НУГА луга meadow.

НУГАЛАА сгиб, складка; загиб bend, fold; deviation;
хувцасанд нугалаа гаргах делать складки на платье make pleats in a dress.

НУГАЛАХ сгибать, перегибать; складывать bend, fold; curve;
өвдгөө нугалах сгибать колени bend one's knees;
хоёр нугалах складывать вдвое fold in two;
тохойгоо нугалах согнуть локоть bend one's elbow.

НУГАРАХ сгибаться, перегибаться, bend, stoop, bow.

НУГАС утка duck.

НУДАРГА кулак fist;
нударга вангидах сжимать кулак clench one's fist.

НУДАРАХ тыкать, толкать, ударять strike, elbow, nudge;
тохойгоороо нударах толкать локтем strike with the elbow.

НУЛИМАХ плевать, плюнуть spit

НУЛИМС слеза tear;
нулимс гоожуулах, нулимс асгаруулах проливать слёзы shed tears.

НУНТАГ порошок powder;
нунтаг оо зубной порошок toothpowder.

НУНТАГЛАХ превращать в порошок make powder.

НУРААХ обваливать, обрушивать make fall, crumble.

НУРАХ обваливаться, обрушиваться crumble, fall, slide, cave in.

НУРУУ I спина, спинной хребет, позвоночник back, spinal column;
нурууган үүрэх заложить руки за спину carry one's hands on one's back;
өндөр нурууtай высокого роста tall.

НУРУУ II 1) хребет mountain ridge;
2) общее состояние general state;
уул нурууд горные хребты mountain range;
гол нуруу, дүн нуруу общее состояние general state

НУС сопли snivel;
нус нийх сморкать нос, высморкаться blow one's nose;
нусаа татах шмыгать носом sniff;
нусны алчуур носовой платок handkerchief.

НУТАГ родное место, родина, родное кочевье, родной край native land, homeland, native place;
нутаг дэвсгэр, газар нутаг территория territory;
төрсөн нутаг родина mother country;
хөдөө нутаг сельская местность country, rural region;
орон нутаг, нутаг орон регион, зона, область region, area;
орон нутгийн цаг местное время local time;
нутаг бэлчээр пастбище pasture grounds;
сайхан нутаг живописная местность picturesque surroundings;
нутгийн местный, территориальный local, territorial;
нутгийн хүн местный уроженец native;
нутгийн аялгуу местний говор, диалект local dialect.

НУТАГЛАХ обитать, жить, settle down, live, inhabit.

НУТАГШИХ осваиваться; привыкать к новому местожительству, акклиматизироваться become accustomed to a new place, become acclimatized

НУУГДАХ прятаться, скрываться be hidden, be concealed, conceal oneself;
нуугдаж тоглох играть в прятки play hide-and-seek.

НУУР озеро lake;
давст нуур солёное озеро salt lake;
гүн нуур глубокое озеро deep lake.

НУУХ прятать; скрывать; секретничать hide, conceal; secret;
хүнээс юм нуух скрывать что-либо от кого-либо keep something from somebody;
нэрээ нуух скрывать своё имя conceal one's name;
гэмт хэрэгтнийг нуух скрывать преступника hide a criminal;
уураа нуух, уурласнаа нуух скрывать свой гнев hide one's anger.

НУУЦ 1) тайна, секрет secret, mystery;
2) тайный, секретный, конспиративный, подпольный secret, mysterious, underground;
улсын нууц государственная тайна state secret;
цэргийн нууц военная тайна military secret;
албаны нууц служебная тайна official secrecy
нууц хадгалах сохранять тайну keep a secret;
юмыг нууц болгох держать что-либо в тайне keep something secret;
нууцыг мэдэх узнать тайну learn a secret;
нууцыг задлах /задраах выдать тайну, разболтать секрет betray a secret, let out a secret;
нууц цоож секретный замок combination lock;

нууц байгууллага подпольная организация underground organization
нууц ажил подпольная работа secret work;
нууц хэвлэл подпольная типография underground press;
нууц байр конспиративная квартира secret adress;
нууц яриа секретный разговор secret talk;
нууц санал, нууц сонгууль тайное голосование secret ballot;
нууц нэр псевдоним pseudonym, secret name;
нууц болзоо, нууц уулзалт тайное свидание, тайная встреча secret meeting;
нууц мөрөөдөл тайная мечта secret dream;
нууц хүсэл тайное желание secret wish;
маш нууц совершенно секретно, весьма секретно top secret, strictly confidential;
нууцаар тайком, секретно secretly, in secret;
нууцаар уулзах тайком встречаться meet secretly.

НУУЦЛАХ засекречивать, делать тайным make secret, conseal, hide.

НУХАХ мять, разминать; теребить, размешивать rumple; crumple; kneed rub, mash;
нүдээ нухах протирать глаза rub one's eyes;
гурил нухах вымешивать тесто kneed dough;
гараар нухах мять рукой scrub ond's hand.

НҮБ (*Нэгдсэн Үндэсний Байгууллага*) ООН (Организация Обьединенных Наций (UNO (United Nations Organization).

НҮГЭЛ грех, перегрешение sin;
нүгэл хийх, нүгэл үйлдэх совершить грех sin;
нүглээ наманчлах искупить свой грех confess one's sin;
нүгэлтэй грешный sinful.

НҮД глаз, око eye;
хурц нүд острый глаз keen eye, sharp eye,
нүдний цэцгий зрачок pupil of the eye;
нүдний цэцгий мэт хайрлах беречь как зеницу ока cherish as the apple of one's eye;
нүдний ухархай глазная впадина eye-socket;
нүдний шил очки spectacles, glasses;
нүдний эмч глазной врач, окулист eye-specialist, oculist;
хоёр нүдний дуран бинокль binocular, pair of glasses;
нүдний хараа зрение sight, eyesight;
нүдээ харах, нүдээ нээх открывать глаза open one's eye;
нүдээ аних закрывать глаза close one's eye;
нүдээ онийлгох щурить глаза screw up one's eye;
нүдээ цавчих мигать глазами blink one's eye;
нүдээ ирмэх моргнуть глазами, мигнуть глазом give a wink;
нүдээ бүлтийлгэх, нүдээ том болгох таращить глаза, выпучивать глаза goggle, stare, open one's eyes wide;
нүд сохрох ослепнуть become blind, lose one's sight;
нүд гялбах слепить dazzle;
цас нүд гялбуулж байна снег слепит глаза the snow is dazzling, the snow in blinding;
нүд булаах, нүдэнд тусах бросаться в глаза strike one's eye, ar rest attention;
нүд тайлах видеть много, познавать многое, обогащаться жизненным опытом get to know many things;
нүд хужирлах любоваться чем-либо / кем-либо, наслаждаться каким-либо зрелищем feast one's eye on something / somebody;
нүд хуурах заниматься очковтирательством, очковтирательство; втереть очки throw dust in somebody's eyes; eye-wash;
нүд үзүүрлэх не любить, стеснять, относиться чуждо dislike, hate put restraint, hinder
нүдэнд дулаан миловидный, симпатичный comely, pleasant looking;
нүдэнд хүйтэн отвратительный, несимпатичный repulsive, unattractive, undesirable;
ширээний нүд выдвижной ящик стола drawer of a table.

НҮДЛЭХ запоминать, замечать memorize, keep in mind

НҮДЭХ толочь; избивать, колотить pound, beat;
хаалга нүдэх, хаалга балбах колотить в дверь bang on the door;
водож нүдэх избивать, бить beat, hit;
цай нүдэх толочь чай (кирпичный) pound brick tea.

НҮРГЭЭН рёв; сенсация roar, sensation.

НҮСЭР тяжёлый, громоздкий; гигантский, грандиозный heavy, bulky; gigantic, enormous.

НҮҮДЭЛ 1) кочёвка, перекочёвка nomadizing;
2) ход move;
нүүдлийн кочевой nomad, nomadic;
нүүдлийн аж байдал кочевой образ жизни nomad life;
нүүдлийн мал аж ахуй кочевое скотоводство nomadic livestock farming;
нүүдлийн шувууд перелётные птицы birds of passage;
морины нүүдэл ход конём move of the knight.

НҮҮДЭЛЧИН кочевник nomad;
нүүдэлчин улс кочевой народ nomadic people.

НҮҮЛГЭХ переселять, эвакуировать move, cause to move, evacuate;
шинэ сууцанд нүүлгэн оруулах переселять на новую квартиру move to a new place.

НҮҮР 1) лицо face;
2) лицевая сторона, фасад front, front part; facade;
нүүр царай лицо, физиономия face, physionomy;
нүүрээ угаах умываться wash one s face;
нүүрээ дарах закрывать лицо cover one's face;
нүүр (ээ) бурууллах бояться смотреть в лицо /в глаза, отворачиваться avert one's face;
нүүр учрах, нүүр тулах встречаться лицом к лицу meet face fo face;
ичсэнээс нүүр улайх краснеть от стыда, стыдиться blush with shame;
нүүр өгөх быть любезным, быть дружелюбным give excessive praise, be overly kind;
нүүр нүүрээрээ, улаан нүүрээрээ лицом к лицу face to face;
нүүрэн дээр нь хэлэх сказать в лицо кому-либо say to somebody's face;
нүүрэн дээр нь бичээстэй байна на лице написано you can read in somebody's face;
нүүр хагарах быть непринужденным feel at ease;
нүүр тал харах поступать лицеприятно / по знакомству do something for the sake of friendship, act with bias;
нүүр хийх газаргүй болох от стыда не знать, куда деть лицо become shameless;
үнэн нүүр царайгаа харуулах показать своё настоящее лицо show one's real worth, show one's true colours;
нүүр гарын алчуур полотенце towel;
байшингийн нүүр фасад дома facad of the building;
сонины нүүр страница газеты page of the newspaper.

НҮҮРС уголь coal;
чулуун нүүрс каменный уголь coal;
хүрэн нүүрс бурый уголь brown coal;
модны нүүрс древесный уголь charcoal;
нүүрсний сав газар угольный бассейн coal basin.

НҮҮХ кочевать, перекочевывать; передвигаться, переселяться nomadize, roam from place to place, move;
шинэ байранд нүүж орох переселяться на новую квартиру move to a new place;
дүрвэн нүүх, нүүж зайлах эвакуироваться evacuate.

НҮХ отверстие, дыра; яма hole, pit;
нүх ухах вырыть яму dig a hole;
хамрын нүх ноздря nostril;
муу усны нүх, хог хаях нүх мусорная яма, помойная яма dust-heap, refuse pit
вүүний нүх ушко иглы needle's eye, pin hole.

НҮХЛЭХ делать отверстие make a hole, drill a hole.

НҮЦГЭН голый, нагой, обнаженный, раздетый naked, bare, nude;
нүцгэн бие голое тело naked body;
нүцгэн толгой голая голова, бритая голова bare head;
нүцгэн хөл голые ноги bare feet;
нүцгэн мод голые деревья naked trees;
нүцгэн гараар голыми руками wtih bare hands.

НҮЦГЭЛЭХ снимать всю одежду, обнажать, раздевать догола undress, bare, uncover.

НҮЦГЭРЭХ становиться голым, обнажаться uncover oneself, bare oneself.

НЭВТ сквозь, насквозь through, throughly;
нэвт гарах пройти насквозь go through;
нэвт цохих пробивать break through;

нэвт харах видеть насквозь look through;
нэвт норох промокнуть насквозь get wet through.

НЭВТЛЭХ пронизывать, проходить насквозь; промачивать насквозь pierse, penetrate; pass through.

НЭВТРҮҮЛЭГ переда ча transmission;
радио нэвтрүүлэг радиопередача, трансляция broadcast;
суртал нэвтрүүлэг пропаганда propaganda.

НЭВТРҮҮЛЭГЧ:
радио нэвтрүүлэгч диктор радио announcer,

НЭВТРҮҮЛЭХ внедрять, вводить; пропускать; распространять inculcate, instil, conduct, pass through;
тэргүүн туршлага нэвтрүүлэх внедрять передовой опыт introduct progressive methods, popularize the innovators;
олон түмэнд соёл нэвтрүүлэх / түгээх распространять культуру среди масс spread civilization among the people.

НЭВТРЭХ внедряться, проникать; промокать насквозь, впитываться strike root, pass through; penetrate; get wet, get soaked, be absorbed;
ус нэвтэрдэггүй водонепроницаемый waterproof, watetight;
бороонд нэвтрэх промокать от дождя get wet under the rain.

НЭВТЭРХИЙ в совершенстве, досконально perfectly, thoroughly;
нэвтэрхий знать в совершенстве know thoroughly;
нэвтэрхий толь энциклопедия encyclopedia.

НЭВТРЭЛЦЭХ сообщаться, быть в контакте communicate, make contact;
хэл нэвтрэлцэх понимать друг друга understand each other.

НЭВЧИХ просачиваться leak, ooze, seep out, soak.

НЭГ, НЭГЭН один one;
бид нэг байшинд суудаг мы живём в одном доме we live in the same house;
надад нэг асуулт байна у меня есть один вопрос I have one question;
тэдний нэг нь один из них one of them;
нэг нь энд, нөгөө нь тэнд байна один здесь, а другой там the one is here, the other is there;
аливаа нэг, ямар нэгэн какой-нибудь, любой some, any;
варим нэг этгээд некоторые товарищи certain persons;
бас нэг ещё один, ещё раз one more, another one, once again;
бас дахин, дахиад нэг опять, ещё раз again, once again;
нэг адил одинаково, также, одно и то же the same;
нэг удаа однажды, один раз once, one time!
хүн нэг бүр каждый человек each person, every one;
нэг бүс удаа не один раз, неоднократно not one time, more than once, often;
нэг дор байх быть / жить в одном и том же месте be in the same place, live in the same place;
нэг дор сразу, одновременно at once;
нэг үгээр одним словом in one word;
... нэг талаар нөгөө талаар с одной стороны ...,
... с другой стороны on the one hand ... on the other hand;
нэг амиар сразу, залпом at once, right away;
нэгэн вэрэг одновременно at one time, at the same time, simultaneously;
нэг төрлийн, нэг янзын однородный, одинаковый, однотипный uniform, homogeneous, of the same type;
тэд нэг нэгээр ирэв они приходили по одному they came by ones;
нэг нэгэндээ туслах помогать друг другу help to each other;
нэгэн саналаар ажиллах; бүгд нэг хүн шиг ажиллах работать единодушно; работать как один work unlnamously work one and all;
хаа нэгэн газар дайралдах встречаться где-то meet somewhere;
энэ өрөөнд нэг л харанхуй байх чинь в этой комнате как-то темно it is dark in this room somehow;
таныг нэг хүн сураглаад байна вас спрашивает какой-то человек someone is asking for you;
нэг ангийнхан однокашники, однокурсники school-fellow, class-mates;
нэг дэх өдөр понедельник Monday

НЭГДҮГЭЭР первый firsf;
нэгдүгээр сар январь january;
нэгдүгээр байшин первый дом the jirst house.

НЭГДЭЛ объединение, единство unanimity, unity, solidarity;
эв нэгдэл солидарность solidarity;
олон улсын хөдөлмөрчдийн эв санааны нэгдэл международная со-

дидарность трудящихся international solidarity of the working people;
онол практикийн нэгдэл единство теории и практики unity of theory and practice;
намын нэгдэл единство партии unity of the party;
үзэл санааны нэгдэл единство взглядов unity of opinion, unity of views;
эрх ашгийн нэгдэл единство интересов community of interests;
үйл ажиллагааны нэгдэл единство действий unity of action;
эв нэгдлийг эвдэх/бусниулах подорвать единство disrupt the unity;
хөдөө аж ахуйн нэгдэл сельскохозяйственное объединение agricultural cooperative.

НЭГДЭХ объединяться, соединяться unite join hands.

НЭГЖ единица unit;
мөнгөний нэгж денежная единица monetary unit;
хэмжүүрийн нэгж единица измерения unit of measures.

НЭГЖИХ обыскать, производить обыск search, conduct a search.

НЭГЖЛЭГ, НЭГЖИЛТ обыск search;
нэгжлэг хийх делать обыск search.

НЭГТГЭХ объединять, соединять, сплачивать unite, join, consolidate;
хүчээ нэгтгэх хүч, чармайлтаа нэгтгэх объединять силы объединять усилия unite one's forces, combine efforts;
нэгтгэн дүгнэх подытоживать обобщать summarize.

НЭГЭНТ раз, уже, поскольку, так как once, since, already;
хугацаа нэгэнт дууссэн срок уже истёк the term has already expired
нэгэнт тийм хойно энэ тухай ярих юм алга раз так, не о чем говорить больше in that case there is no more to be said.

НЭЛЭЭД, НЭЛЭЭН значительно; порядочно, довольно considerably, rather, quite, in a great degree;
нэлээд удаан хүлээх ждать довольно долго wate quite a long time;
би түүнийг нэлээн сайн мэднэ я его довольно хорошо знаю I know him rather well;
нэлээд олон довольно много quite a lot, quite a few;
нэлээд хурдан түргэн довольно быстро fairly rapidly.

НЭМНЭЭ попона horse-cloth, warm cloth for the horse animal

НЭМЭГДҮҮЛЭХ прибавлять, дополнять, увеличивать, усиливать add, increase, raise, expand;
цалин нэмэгдүүлэх прибавлять жалованье raise the wages;
жин нэмэгдүүлэх прибавлять в весе gain weight;
үнэ нэмэгдүүлэх повысить цену increase prices;
зардлыг нэмэгдүүлэх увеличить расходы increase expenses
ашиг орлогыг нэмэгдүүлэх увеличивать доходы increase income;
хүч нэмэгдүүлэх подкреплять силу, усиливать increase power;
олон улсын хурцадмал байдлыг нэмэгдүүлэх усиливать международную напряженность intensify international tension.

НЭМЭГДЭЛ добавка, дополнение; добавочный, дополнительный addition, increase, suplement; additional, supplementary;
нэмэгдэл тэжээл подкормка, дополнительный корм supplementary fodder;
нэмэгдэл хүч дополнительная сила supplementary force.

НЭМЭГДЭХ добавляться, прибавляться be added, increase.

НЭМЭР добавка, дополнение: вклад, помощь, содействие addition, contribution;
нэмэр хандив хувь нэмэр вклад contribution;
шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулах сделать/внести ценный вклад в науку make a valuable contribution to science;
нэмэр болох помогать help, contribute;
ажилд нэмэр болох оказывать помощь работе, помогать работе contribute to work.

НЭМЭРЛЭХ добавлять, дополнять; вносить вклад add, increase; contribute.

НЭМЭХ добавлять, прибавлять, дополнять add, supplement, increase;
үнэ нэмэх повысить цену increase the price;
мөнгө нэмж өгөх прибавить деньги add money;
нэмэх тэмдэг знак сложения, плюс plus sign.

НЭН еще более, более всего, весьма, особенно, чрезвычайно still, more, most of all, especially, extremely;
нэн даруй срочно, немедленно, сейчас же immediately, quickly, without delay;
чи нэн даруй яв! ты иди сейчас же you go at once;
нэн их очень много still bigger;

нэн олон особенно много more and more, great many;
нэн ялангуяа особенно particularly;
оройдоо тэр нэн их ажилтай он особенно занят по вечерам he is especially busy in the evenings;
нэн түрүүнд прежде всего first of all, above all.

НЭР имя, название, наименование; честь, репутация, авторитет; известность, престиж name, authority, title; reputation, good name, authority, fame;
овог нэр имя и отчество personal and family name;
хүний нэр собственное имя personal name;
газар үсны нэр географическое название geographical denomination;
хоч нэр кличка nickname;
сайн нэр незапятнанная репутация stainless reputation;
муу нэр плохая репутация bad reputation;
сайн нэртэй байх пользоваться хорошей репутацией have a good reputation;
муу нэртэй байх пользоваться плохой репутацией have a bad reputation;
нэр хүнд, нэр төр, нэр сүр авторитет, престиж, честь authority, prestige;
нэр томьёо терминология term, terminology;
барааны нэр төрөл виды товаров sorts of goods;
нэрийн хуудас визитная карточка visiting card, name card;
нэрийн дор, нэрээр под именем under the name;
нэрийн өмнөөс от имени on behalf;
таны нэр хэн бэ? как вас зовут? what is your name?
миний нэр Дорж меня зовут Дорж my name is Dorj;
нэр өгөх дать имя give a name;
нэр дуудах назвать имя, вызывать имя, вызывать по имени call by name;
нэр солих изменить имя change the name;
нэр заалдах пользоваться чужим именем use another's name illegally;
нэр гутаах компрометировать чью-нибудь репутацию compromize somebody's name;
нэрээ гутаах, нэрээ хугалах запятнать своё имя компрометировать себя, позориться, подрывать свой авторитет stain one's good name, disgrace oneself, compromize oneself;
нэрээ алдах потерять свой авторитет lose one's reputation;
нэрээ цэвэрлэх реабилитироваться prove oneself in the right;
нэрээ бодох, нэрээ хайрлах дорожить своим именем/своей репутацией hold dear one's reputation, value one's reputation;
нэрээ хадгалах сохранить свой престиж, спасти свою репутацию save one's face;
нэрд гарах, нэрээ олох приобретать известность, завоевывать авторитет become famous, gain prestige, win authority;
дэлхийд нэртэй пользующийся мировой известностью world-famed;
нэртэй зураач известный художник well-known painter.

НЭРВЭГДЭХ страдать, терпеть урон, подвергаться suffer, be hit, be damaged;
өвчинд нэрвэгдэх страдать от болезни hit by illness;
түймэрт нэрвэгдэх пострадать от пожара be damagged by fire;
ган гачигт нэрвэгдэх пострадать от засухи suffer from drought;
тэд үерт нэрвэгдэв они пострадали от наводнения they were victims of the flood;
аюулд нэрвэгдэх подвергаться опасности run the danger.

НЭРЛЭГДЭХ называться, именоваться, носить имя be called, be named, bear the name.

НЭРЛЭХ называть, именовать, звать по имени call, name;
хүүхдийг Дорж гэж нэрлэв ребёнка назвали Дорж the child was named Dorj;
сурагч гол гол хотыг нэрлэв ученик назвал главные города the pupil named the chief towns;
нэрлэхийн тийн алгал именительный падеж nominative case.

НЭРМЭЛ дистиллированный distilled;
нэрмэл ус дистиллированная вода distilled water;
нэрмэл архи самогон distilled liquor.

НЭРТ знаменитый, известный, выдающийся famous, well-known, eminent;
нэрт эрдэмтэн известный учёный noted scientist.

НЭРЭЛХЭХ церемониться, стесняться be pretentious, be ambitious, feel shy,
битгий нэрэлх! не стесняйся! do not stand on ceremony!

тэр танд хэлэхээсээ нэрлэхээр/ зовсоо байна он стесняется сказать вам he is ashamed to tell you.

НЭРЭМЖИТ имени named after;
Сүхбаатарын нэрэмжит талбай площадь имени Сухе-Батора the square named after Souche-Bator, the Souche-Bator square;

НЭРЭХ гнать, курить; дистиллировать distill;
тогоо нэрэх курить молочную водку distill milk wine

НЭХИЙ овчина sheepskin;
нэхий дээл овчинный тулуп sheepskin coat;
нэхий, нэхий эдлэлийн үйлдвэр фабрика овчинно-шубных изделий, овчинно шубная фабрика sheepskin coat factory.

НЭХМЭЛ ткань, тканый, сотканный; вязанный cloth, woven material; woven; crocheted;
ноосон нэхмэл шерстяная ткань woolen cloth;
нэхмэлийн үйлдвэр текетильная промышленность textile industry;
нэхмэлийн зүү вязальная игла, спица; вязальный крючок knitting needle: crochet hook;
нэхмэлийн машин ткацкий станок. текстильная машина knitting machine.

НЭХМЭЛЧИН ткач, ткачиха weaver.

НЭХЭМЖЛЭГ запрос; требование; взыскание demand, exaction, claim.

НЭХЭМЖЛЭХ затребовать, взыскивать demand, exact, claim.

НЭХЭХ I ткать, вязать weave, knitte;
оймс нэхэх вязать чулки knitte socks

НЭХЭХ II требовать, взыскивать; преследовать, гнаться demand, exact, claim; pursue;
өр нэхэх взыскивать долги demand payment; recover a debt
нэхэж авах взыскивать exact;
нэхэн санах вспоминать remember, recall;
хойноос нь нэхэн хөөх гнаться за кем-либо, преследовать pursue, run after;
нэхэн шагнах наградить посмертно decorate posthumously.

НЭЭГДЭХ открываться open;
хаалга/үүд нээгдэв дверь открылась the door was opened.

НЭЭЛТ открытие opening
анхны нээлт первое открытие the first opening;
шинэ нээлт новое открытие the new opening;
нээлтийн өдөр день воткрытия opening day, inauguration day.

НЭЭРЭЭ действительно, в самом деле, вправду indeed, really, truly, in fact;
чи нэрээ хэлж байна уу? ты правду говоришь? do you speak truly?
нээрээ, нээрээ правда, конечно, правда certainly, it is true.

НЭЭХ открывать open;
үүд нээх открывать двери open a door;
нүд нээх открыть глаза open one's eye;
шинэ эрин үеийг нээх открыть новую эру open a new era;
хаалт нээх открывать скобки open a brackets;
вам нээх открыть путь clear the way;
хурал нээх открыть заседание open a meeting;
ном нээх открывать книгу open a book;
гал нээх открывать огонь open fire;
ам нээх а) открывать рот open a mouth;
б) молвить слово talk.

НЯБО (НЯГТЛАН БОДОГЧ) бухгалтер book-keeper, accountant;
ерөнхий нябо главный бухгалтер accountant general

НЯГТ 1) плотный, тесный compact, dense, close, thick;
2) аккуратный, тщательный accurate, careful;
нягт шигүү хүн ам плотное население dense population;
хүн амын нягт плотность населения density of population;
нягт холбоотой байх быть в тесном контакте be in a close connection;
нягт нямбай хүн аккуратный человек accurate person;
нарийн нягт ажил тщательная работа careful work.

НЯГТЛАХ уточнять, проверять invenstigate, make more exact, define more presisely.

НЯГТРАХ уплотняться, сплачиваться, становиться прочным become dense; become compact, unite.

НЯГТРУУЛАХ уплотнять, сплачивать condense, thicken, close;
эгнээг нягтруулах сплачивать ряды close ranks.

НЯЛУУН слащавый, приторный sugary, sickly-sweet;
нялуун амт слащавый вкус greasy taste;
нялуунаар инээмсэглэх слащаво улыбаться give a sugary smile.

НЯЛХ новорождённый new-born;
нялх хүүхэд новорождённый ребёнок, младенец baby, infant;
нялх төл молодняк younger animals;
нялх ногоо молодая зелень young grass.

НЯМ воскресенье Sunday.

НЯМБАЙ аккуратный, опрятный, пунктуальный accurate, punchtual;
нямбай хүн аккуратный человек orderly person

НЯРАВ *мөнгөний нярав* кассир treasurer, cashier;
барааны нярав кладовщик store-keeper.

НЯРАЙ новорождённый new-born
нярай хүүхэд новорождённый ребёнок new-born child

НЯРАЙЛАХ рожать give birth;
нярайлах газар родильный дом maternity home

НЯСЛАХ щёлкать, давать щелчок flick, give a fillip;
хуруугаар няслах щёлкать пальцами snap one's fingers;
хамар дээр нь няслах щёлкнуть по носу give fillip on the nose.

НЯЦ; *няц цохих* разбивать вдребезги, раздроблять smash, break into pieces;
няц дарах раздавить press to pieces.

НЯЦААХ отражать, давать отпор, отбивать, опровергать repulse, repel, parry, refute, disprove;
дайралтыг няцаах repulse an attack, feat off an attack;
цохилтыг няцаах отражать удар parry a blow;
харгислалыг няцаах отразить агрессию repel aggression.

НЯЦАХ отступать, отрекаться step back, receed, recoil

НЯЦАШГҮЙ неотразимый irresistible, irrefutable.

НЯЦРАХ раздробляться, измельчаться break to pieces, smash to pieces

О

ОВ хитрость, уловка cunning, craftness, deceit.

ОВЖИН хитрый, хитроумный cunning, sly.

ОВОГ фамилия surname;
түүний овог хэн бэ? как его фамилия? what is his surname?

ОВОО I куча, груда, насыпь heap, pile, mass.

ОВОО II неплохо, довольно quite, rather, fairly;
овоо сайн довольно хорошо quite good;
овоо олон довольно много quite a lot, quite a few;
тэр монгол хэл овоо мэднэ он неплохо знает монгольский язык he knows Mongolian rather well.

ОВООЛОХ нагромождать, сваливать грудой, собирать в кучу heap up, pile up, gather into heap;
шороо овоолох ссыпать землю в кучу heap up an earth;
түлээ овоолох собирать дрова в кучу pile up firewood.

ОВООРОХ собираться толпой, толпиться, скапливаться croud, swarm, gather in a swarm.

ОВОР облик, внешность, вид look, appearance;
овор багатай; а) моложавый, моложе своих лет young looking, young for one's age;
б) малогабаритный compact, small

ОГОТНО мышь mouse.

ОГОТОР короткий short-tailed, short.

ОГТ, ОГТХОН ч совсем, совершенно, отнюдь, вовсе absolutely, completely, at all, entirely;
огт танихгүй хүн совершенно незнакомый человек total stranger, perfect stranger;
би түүнийг огт танихгүй я его совсем не знаю I do not know him at all;
огт үгүй совсем нет not at all;
иймэ юм болно гэж тэр огт санасангүй он этого совсем не ожидал he never expected that;
энэ надад огт таалагдахгүй байна, би үүнийг огт таашаахгүй байна мне это совсем не нравится I do not like it a bit;
огтхон ч болохгүй совершенно невомозможно, вовсе нельзя absolutely impossible.

ОГТЛОХ 1) резать, рубить cut, fell, chop;
2) пересекать, переходить cross, cut across, intersect;
мах огтлох резать мясо chop off a meat;
мод огтлох рубить лес feel trees, cut timber;
би гараа огтлов, би хуруугаа огтлов /эсгэв я порезал себе палец I cut my finger;
вам огтлох переходить дорогу cut across a road;
гудамж огтлох пересекать улицу cross the street.

ОГТЛОЛЦОХ пересекаться cross, intersect;
огтлолцсон шулуун пересекающиеся линии crossing lines

ОГТОРГУЙ небо, небосвод sky; heaven, atmosphere;
огторгуйн уудам небесное пространство heavenly space.

ОГЦОМ крутой, резкий steep, sharp, harsh,
огцом зан резкий характер sharp temper, short temper;
огцом зантай хүн резкий человек harsh person;
огцом дуу резкий голос shrill voice;
огцом хариулт резкий ответ sharp answer;
огцом эрэг крутой берег steep bank;
огцом эргэх круто повернуть turn round sharply.

ОГЦРОХ увольняться, освободиться, уходить в отставку leave, resign retire;
тушаалаасаа огцрох уходить с поста leave one's post, resign one's position.

ОГЦРУУЛАХ увольнять, смещать, освободить discharge, dismiss; spare;
ажлаас огцруулах увольнять с работы discharge from office;
орон тооны цомхотголоор огцрох/ халагдах увольнять по сокращению штатов discharge on grounds of redundancy

ОД звезда star;
од гарах, од түгэх появление звёзд the appearance of stars;
од харвах падение метеоритов the falling of meteorite;
одон орны судлал астрономия astronomy;
одтой шөнө звёздное небо starry sky;
оддын ахан дүүс звёздные братья star brothers;
оддын хотхон звёздный городок stellar township;
одтой хүн счастливец, везучий человек lucky man.

ОДОН орден order, decoration;
Сүхбаатарын одон орден Сухэ-Батора Order of Soukhe-Bator;
Алтан гадас одон орден Полярной звезды Order of the Polar Star;
одонгийн туузе орденская лента ribbon;
одонгоор шагнуулах. одон авах награждаться орденом, получить орден be decorated with an order.

ОДОО сейчас, теперь, ныне, настоящее время now, at present;
одоо болтол одоо хүртэл до сих пор, до настоящего времени still, up to now;
тэр одоо болтол бичсээр байна он до сих пор пишет, он все ещё пишет he is still writing;
одоо цагт в теперешнее время at the present time;
одоогийн хүмүүс теперешние люди, нынешние люди, современные люди present-day people;
шалгалтад одооноос бэлтгэх готовиться к экзаменам с настоящего времени get up the examination from now on, prepare for the examination from now on.

ОДООХОН сейчас, сию минуту; только что; скоро now, just now, very soon presently;
үүнийг одоохон хий сделай это сейчас же do it immediately;
тэр одоохон ирнэ он сейчас придёт he will be here presently
одоохон! сейчас! in a minute! just a moment!

ОДОХ идти, отправляться, уходить, уезжать go, move, go away, depart.

ОЁДОЛ шов; шитьё seam, sewing;
оёдлоор нь ханзлах распарывать по швам rip up a seam;
оёдолгүй без шва seamless;
оёдлын машин швейная машина sewing machine;
оёдлын газар швейная мастерская sewing workshop.

ОЁДОЛЧИН портной, швея tailor, seamstress.

ОЁХ шить sew;
машинаар оёх шить на машине sew on a machine.

ОЙ I годовщина; юбилей anniversary; jubilee;
хорин жилийн ой двадцатилетний юбилей twentieth anniversary;
вуун жилийн ой столетний юбилей centennial;
ой тэмдэглэх праздновать юбилей, справлять годовщину celebrate an anniversary;
ойн баяр юбилейные торжества anniversary celebrations;
ойд хүрсэн хүүхэд годовалый ребёнок a year-old baby.

ОЙ II лес woods, forest;
шилмүүст ой хвойный лес coniferous forest;
холимог ой смешанный лес mixed forest;
өтгөн ой, битүү ой густой лес dense porest;
ойн аж ахуй лесное хозяйство forestry
ойн баялаг лесные богатства timber resources;
ой хамгаалах зурвас лесозащитные полосы protective forest-belts;
ой хамгаалагч, ойн цагдаа лесник forest-guard, woodman;
ойт хээрийн бүс лесостепной район forest-steppe region;
ойн сургууль лесная школа forest school.

ОЙ III память, разум, ум memory, mind, intellect;
тэр ой сайтай у него хорошая память he has a retentive memory;
ой муутай слабоумный, забывчивый, имеющий плохую память weak-minded, forgetful, having poor memory.

ОЙЛГОЛТ понятие, понимание understanding, comprehension, notion, idea;
миний ойлголтоор, миний ойлгож байгаагаар бол в моём понимании, как я понимаю as I see it;
ямар нэгэн юмны тухай өчүүхэн ч ойлголтгүй байх не иметь ни малейшего понятия о чём-либо have no idea of something, have not the slightest notion of something
буруу ойлголт неправильное понятие/ понимание misunderstanding, misconception.

ОЙЛГОМЖ понятие; понятливость, понятность, ясность notion, comprehension; clearness, intelligibility, perspicuity;
ойлгомжтой понятный, ясный intelligible, clear;
энэ ойлгомжтой это понятно/ ясно it is clear;
ойлгомжгүй непонятный unintelligible;
ойлгомжгүй ярих говорить непонятно speak unintelligibly.

ОЙЛГОЛЦОХ понимать друг друга understand each other.

ОЙЛГОХ понимать, разуметь, разбираться; осознать understand, comprehend; realize;
би таныг ойлгож байна я вас понимаю I understand you, I see your point;
хялбархан ойлгох, ойлгоход хялбар легко понять it will be easily understood;
буруу ойлгох неправильно понимать misunderstand, mistake;
үгийн утгыг ойлгох понимать значение слова understand a meaning of the word

ОЙЛГУУЛАХ давать понять, делать понятным make clear, give to understand.

ОЙМС чулки, носки stocking, sock;
богино оймс носки socks;
ноосон оймс шерстяные чулки woolen stockings;
торгон оймс шёлковые чулки silk stockings;
торон оймс ажурные чулки open-work stockings.

ОЙР близкий, ближний; ближайший; близко, поблизости near, close, around; nearest; close by;
ойр дотнын нөхөр близкий друг close friend;
ойрын зорилго/ зорилт ближайшая задача immediate task;
ойрын хэдэн өдөр ближайших несколько дней past few days, next few days;
ойрын ирээдүйд в ближайшем будущем in the next future;
ойрын өдрүүдэд в ближайщие дни in these days;

өдрын үед на днях one of these days;
ойр дотно танилцах близко познакомиться become closely acquainted;
хотод ойр суух/ аж төрөх жить близко к городу live near to city;
хүнтэй ойр дотно байх быть близким с кем-либо be intimate with somebody.

ОЙРОЛЦОО близкий, соседний; сходный; поблизости, по соседству near, neighbouring; similar, like; near by, here about;
ойролцоогоор приблизительно nearly, approximately;
хотын ойролцоо поблизости от города near to the city

ОЙРТОХ близиться, приближаться, подходить поближе draw near, come nearer, approach;
ойртож очих подходить близко come nearer;
түүнтэй битгий ойрт не связывайся с ним! держись подальше от него! don't get him! keep away from him!
өвөл ойртож байна зима приближается the winter is approaching.

ОЙРТУУЛАХ приближать, подпускать; сближать draw nearer, bring nearer, approach.

ОЙЧИХ падать fall, drop.

ОЙШООХ обращать внимание, принимать во внимание, относиться положительно pay attention, take into consideration.

ОЛГОХ выдавать, отпускать; предоставлять grant, let, give, pay, supply;
цалин олгох выдавать зарплату pay wages, pay a salary;
мөнгө олгох выдавать деньги pay out money;
үнэмлэх олгох выдавать удостоверение give a sertificate;
зээлээр олгох отпускать в кредит sell on credit;
боломж/ бололцоо олгох предоставлять возможность give an opportunity, give a chance;
эрх олгох предоставлять право grant a right;
амралт олгох предоставлять отпуск grant leave;
вөвшөөрөл олгох давать разрешение grant permission;
шагнал олгох награждать give a reward;
нөхөн олгох возмещать, компенсировать compensate

ОЛДОХ находиться, обнаруживаться, быть найденным be found, turn up;
гээгдсэн ном олдлоо потерянная книга нашлась the lost book is found.
танд энэ ном олдохгүй юу? вы не можете найти эту книгу не найдётся у вас эта книга? can you not find this book?
надад зав олдохгүй юм у меня нет свободного времени, я не могу найти свободное время I can't find a free time.

ОЛЗ находка find, finding;
олз ашиг, олз омог доход, прибыль profit, gain;
олз хайх, олз эрэх искать выгоду seek profit.

ОЛЗЛОГДОХ попадать в плен be taken prisoner

ОЛЗЛОХ брать в плен; захватывать take prisoner; seize capture.

ОЛОЛТ достижение, успех, прогресс achievement, gain, success, progress
шинжлэх ухаан техникийн ололт достижения науки и техники achievements of science and engineering, scientific and technological achievements.

ОЛОН много, множество much, many, a lot of, plenty of, numerous;
надад олон ном бий у меня есть много книг I have a plenty of books;
олон хүн много народу, много людей a lot of people;
олон цөөн количество quantity, number;
олон хүнтэй хот многолюдный город populous town;
олон хүүхэдтэй айл многодетная семья large family;
олон хүүхэдтэйн тэтгэвэр пособие по многодетности State grants of many children;
олон үндэстний улс многонациональное государство a State of many nationalities, multinational State'
олон үгтэй многословный, многоречивый, болтливый loquacious, talkative, garrulous;
олон давхар многоэтажный многослойный many-storeyed, many-layered;
олон нийт общественность community, public, mass;
олон нийтийн байгууллагууд общественные организации public organizations,
манай хамт олон наш коллектив our collective;

олон улсын байдал международное положение, международная обстановка international situation;
олон улсын эрх международное право international law;
олон талын многосторонний multilateral, many sided;
олон арван десятки dozens, scores;
олон арван уншигч десятки читателей scores of readers;
олон тооны многочисленный numerous;
олон жилийн многолетний of many years;
олон удаа олон дахин много раз many times, frequently;
маш олон очень много too many;
олноороо хэлэлцэх обсуждать всем коллективом discuss collectively take the council.

ОЛОНХИ большинство, большая часть majority, the major part;
олонхийн саналаар шийдвэрлэх решить большинством голосов decide by a majority of votes;
дийлэнх олонх подавляющее большинство overwhelming majority.

ОЛОХ находить, обнаруживать, доставать, добывать, получать, приобретать find, discover; get, obtain, acquire, gain;
амжилт олох достигать успеха achieve a success;
дэмжлэг олох находить поддержку find support;
эрх чөлөө олох завоевать свободу win feedom;
муу нэр олох приобрести плохую репутацию acquire a bad reputation;
мэдлэг олж авах приобретать знания, получать знания acquire knowledge;
их туршлага олж авах приобрести большой опыт gain wide experience;
итгэл олох найти доверие, войти в доверие win confidence;
учрыг олох, шалтгааныг олох находить причину discover the cause bring to light;
үнэн зөвийг олох находить правду find the truth;
◊ *хүүхэд олох* забеременеть become pregnant.

ОЛШРОХ увеличиваться, умножаться, возрастать increase, grow in number, multiply, rise.

ОЛШРУУЛАХ увеличивать, умножать increase multiply duplicate.

ОН год calendar year;
он сар дата date;
он дарааллын бичиг летопись chronicle annals;
онд орох перезимовать, переносить зиму pass the winter, survive the weather.

ОНГИРОО хвастливый, зазнайка, зазнающийся boastful, self-important.

ОНГИРОХ хвастаться, зазнаваться boast, brag, give oneself airs.

ОНГОЙЛГОХ открывать, раскрывать open leave open;
үүд онгойлгох открывать дверь open a door;
цонхоо онгойлго! открой окно open the window!

ОНГОЙХ 1) открываться, раскрываться, отворяться open up, become wide open;
2) проясняться clear up, calm down
тэнгэр онгойлоо небо прояснилось the weather is cleared up.

ОНГОРХОЙ 1) открытый, распахнутый open unclosed, uncovered;
2) щель, дыра, отверстие opening, gap, hole;
онгорхой хаалга открытая дверь open door.

ОНГОЦ *бие угаах онгоц* ванна bath tub;
мал услах онгоц водопойная колода trough receptacle for water;
тэжээлийн онгоц корыто trough;
нисэх онгоц самолёт aeroplane, aircraft,
усан онгоц судно, корабль, пароход vessel, ship;
усан доогуур явдаг онгоц, шумбагч онгоц подводная лодка submarine ;
сөнөөгч онгоц (нисэх) истребитель fighter, pursuit plane;
бөмбөгдөгч онгоц бомбардировщик, бомбардировочный самолёт bomber, bombing aircraft;
дуунаас хурдан онгоц сверхзвуковой самолёт supersonic jet;
тийрэлтэт онгоц реактивный самолёт jet;
нисэх онгоцны буудал аэродром, аэропорт airport, aerodrome;
усан онгоцны буудал/ зогсоол гавань, порт harbour, port;
нисэх онгоц буух талбай посадочная площадка landing field.

ОНДОО другой, иной, отличный, разный another, other, different;
ондоо тийшээ явах идти в другую сторону go to the other side;

өндөө үгээр хэлбэл, өндөөгөөр хэлбэл другими словами in other words;
надад өндөө ном өгөөч дайте мне другую книгу give me another book;
өндөө өндөө газар суух жить в разных местах live in different places;
огт өндөө юм, шал өндөө юм совсем другая вещь quite another thing;
энэ өндөө хэрэг это другое дело that is another matter, that is quite different;
өндөө өндөө шалтгаанаар под разными предлогами under different pretexts

ОНИГОР: *онигор нүд* узкоглазый, с узкими глазами narrow eyed.

ОНОВЧТОЙ конкретный опеределённый; точный, правильный, удачный; рациональный concrete, definite; correct, exact, apt, felicious; rational;
оновчтой арга хэмжээ конкретные меры expedient action, concrete measures;
оновчтой хариулт өгөх дать точный ответ give definite answer;
оновчтой санал конкретное предложение concrete proposal;
оновчтой санаачилга рационализаторское предложение rationalization proposal;
илүү оновчтой ашиглах наиболее рационально использовать make the most efficient use;
оновчтой орчуулга удачный перевод felicitous translation;
оновчтой хэллэг удачное выражение apt expression;
оновчтой / зөв сонголт удачный выбор happy choice.

ОНОГДОХ попадаться; доставаться be hit, be imposed, be alloted; fall to one's share.

ОНОЛ теория theory;
маркист-ленинист онол марксистско-ленинская теория Marxist-Leninist theory;
социалист хувьсгалын онол теория социалистической революции theory of socialist revolution;
онол практик хоёр теория и практика theory and practice;
танин мэдэхүйн онол теория познания theory of knowledge;
харьцангуйн онол теория относительности theory of relativity;
магадлалын онол теория вероятности theory of chances;
мэдээллийн онол теория информации information theory;
онолын мэдлэг теоретическое знание theoretical knowledge;
онолын үндэс теоретическая основа theoretical base, theoretical foundation;
онолын бага хурал теоретическая конференция theoretical conference;
онолын дүгнэлт теоретический вывод theoretical conclusion.

ОНОЛЧ теоретик theorist.

ОНОХ попадать в цель; разгадывать, угадывать, предвидеть hit a target; hit; guess, find the answer, be right.

ОНОШ диагноз diagnosis;
онош тогтоох ставить диагноз diagnose.

ОНХОЛДОХ перевёртываться, опрокидываться turn over, upset.

ОНЦ особый, особенный; отличный, лучший; чрезвычайный, исключительный particular, specific, peculiar; excellent; special, exclusive, extraordinary;
сургуулиа онц төгсөх окончить школу на отлично, окончить школу с отличием finish school with excellent marks, graduate with honours;
онц сурлагатан сурагч отличник excellent pupil;
онц сурлагатан оюутан студент-отличник honours student, distinguished student;
онц төгссөний диплом диплом с отличием honours diploma;
онц сонин юмгүй, онц гойд юмгүй ничего особенного nothing in particular, nothing much;
онц эрх полномочие; монополия; чрезвычайные права authority; monopoly, exclusive rights;
онц бүрэн эрхт элчин сайд чрезвычайный и полномочный посол ambassader extraordinary and plenipotentiary;
онц ялгаа алга, онцын ялгаагүй юм байна нет ничего специфичного there is nothing in specific.

ОНЦГОЙ особенный, специфический; исключительный, чрезвычайный peculiar, especial, specific; unusual, exceptional;
онцгой чухал хэрэг дело исключительной важности a case of exceptional importance;
онцгой хууль исключительный закон exceptional law;
онцгой эрх исключительное право exclusive right;
онцгой анхаарал тавих уделять особое внимание pay particular attention;
бусдаас онцгой хүн своеобразный человек, оригинальный человек person different from others, original person.

ОНЦЛОГ особенность, специфика peculiarity, specificity, feature;
үндэсний онцлог национальная особенность national peculiarity;
орон нутгийн онцлог местная особенность local feature;
өвөрмөц онцлог специфическая особенность specific character.

ОНЦЛОХ обособлять, выделять, подчёркивать underline, emphasize, single out, stress.

ОНЬСОГО загадка riddle; enigma; mystery;
оньсого хэлэх говорить загадками speak in riddles;
оньсого таалгах загадывать загадку ask riddles;
оньсого тайх, оньсого тайлах отгадывать загадку solve a riddle, guess a riddle.

ОО прошок; пудра powder;
шүдний нунтаг оо зубной порошок tooth-powder;
шүдний нойтон оо зубная паста tooth-paste.

ООСОР шнур, верёвка, тесьма cord, string, rope;
цагны оосор цепочка для часов watch-chain.

ООСОРЛОХ подвязывать; привязывать шпагатом fasten with a string, tie.

ООЧИР очередь queue, line;
оочирт зогсох стоять в очереди stand in a queue, stand in line;
талхны оочир очередь за хлебом bread-line

ООЧИРЛОХ стоять в очереди stand in a queue, stand in line

ОР I кровать, койка, постель bed;
ор дэр, ор дэвсгэр постель bedding;
орны хэрэглэл постельные принадлежности bedding;
орны даавуу простыня bed-sheet;
орны бүтээлэг покрывало для постели bed-spread;
хүүхдийн ор детская кровать cot, crib;
хоёр хүний ор двуспальная кровать double bed;
эвхдэг ор складная кровать folding bed;
аяны ор походная кровать camp-bed;
зуун ортой больниц / эмнэлэг больница на сто коек hospital with hundred beds;
ор засах стлать/стелить постель make the bed;
ор хураах убирать постель make the bed.

ОР II след, отпечаток trace; place, basis;
хурууны ор, хурууны мөр отпечаток пальца finger-print;
ор сураггүй алга болох исчезать бесследно, пропадать без вести disappear without a trace;
оргүй цуурхал ложная молва, необоснованный слух unfounded rumour, wild rumour;
ортой юм ярих говорить что-то правдоподобное speak something probabze.

ОРГИЛ вершина, пик top, summit, peak;
уулын оргил вершина горы summit of a mountain.

ОРГОХ сбежать, убежать, удрать; дезертировать run away, escape, take refuge; desert;
оргон зугатах, оргон зайлах убежать, избавиться escape;
шоронгоос оргох бежать из тюрьмы escape from prison;
цэргээс оргох дезертировать из армии desert the army.

ОРД месторождение layer, deposit;
ашигт малтмалын орд месторождение полезных ископаемых the mineral reserves.

ОРДОН дворец palace;
засгийн газрын ордон дом правительства government house;
соёлын ордон дворец культуры Palace of culture;
пионерийн ордон дворец пионеров young pioneer palace

ОРИЛОХ кричать, орать; плакать, реветь cry, shout, scream, yell;
битгий орилоод бай! орилохоо больё! не кричи! перестань (те) кричать! do nod cry!

байдгаараа орилох орать во все горло shout at the top of one's voice.

ОРЛОГО доход, приход, прибыль income, receipts, profit;
цэвэр орлого чистый доход net profit;
дундаж орлого средняя прибыль average profit;
нийт/бүх орлого валовая прибыль, валовой доход gross profit, gross receipts;
жилийн орлого годовой доход annual income;
үндэсний орлого национальный доход national income;
мөнгөн орлого денежный доход monatery income;
бодит орлого реальный доход real income;
орлого зарлага приход и расход income and expenditure, income and expenses;
ашиг орлогын татвар подоходный налог income tax;
хөдөлмөрийн бус орлого нетрудовой доход unearned income;
орлого зарлагын төсөв бюджет budget;
орлого олох получать прибыль get a profit, receive a profit;
орлого орох давать доход; приносить прибыль be profitable, bring in an income;
орлогогүй бездоходный, бесприбыльный unprofitable, profitless.

ОРЛОГЧ заместитель deputy, assistant, vice;
орлогч сайд заместитель министра deputy minister;
орлогч дарга заместитель председателя deputy chief, vice-chairman;
орлогч гишүүн кандидат в члены alternate member.

ОРЛОХ замещать replace, take the place, deputize, substitute;
даргыг орлох замещать начальника substitute for the chief; deputize for the chief.

ОРОЙ I вечер, вечером; поздно evening; in the evening; late;
өнөө орой сегодня вечером this evening, tonight;
өчигдөр орой вчера вечером last evening, yesterday evening;
оройн курс вечерние курсы evening classes;
оройн ээлж вечерняя смена night shift;
оройн сонин вечерняя газета evening paper;
оройн хоол ужин supper, dinner;
шөнө орой поздно вечером, поздно ночью late in the evening;
орой болж байна вечереет the day draws to a close, night is falling;
орой ирэх приходить вечером; приходить поздно come in the evening come late.

ОРОЙ II вершина, верхушка, верх summit, peak, top;
байшингийн орой крыша дома roof of a house;
уулын орой вершина горы summit of mountain.

ОРОЙТОХ запаздывать, опаздывать be late, be behind schedule;
одоо бид яваагүй бол оройтно если сейчас мы не пойдём, то будет поздно if we do not go now, we will be late.

ОРОЙТУУЛАХ затягивать, задерживать delay, drag out.

ОРОЛДЛОГО старание, стремление, усилие, попытка effort, zeal, diligence, endeavour; attempt;
идэвх оролдлого активность, старательность active, industry;
бүтэмжгүй оролдлого неудачная попытка unsuccessful attempt;
оролдлого хийх предпринимать попытку make an attempt;
оролдлоготой оюутан старательный / прилежный студент industrious student, diligent student;
оролдлогогүй нестарательный, неусердный, неприлежный zealless, idle.

ОРОЛДОХ 1) стараться, стремиться; пытаться, пробовать endeavour, try, attempt;
2) трогать touch, handle;
цаг хожихыг оролдох стараться выиграть время try to gain time;
улаан нүцгэн совсем голый stark-naked;

улаан нүүрээр лично, лицом к лицу personally, face to face;
улаан гараараа голыми руками with bare hands;
улаан нялзрай новорождённый new-born child;
улаан мөнгөгүй ни гроша за душой penniless;
улаан болох становиться красным become red;
улаан зээрд болох опьянеть intoxicate.

УЛАВЧ стелька, подстилка inner sole, insole.

УЛАЙЛГАХ делать красным make red;
нүүрээ улайлган покраснев, с покрасневшим лицом turn red in the face, with a red face, being blashed with.

УЛАЙРАХ стараться, стремиться endeavour, try, strive, make an efforts;
ажлаа дуусгах гэж улайрах стараться закончить работу strive to finish the work.

УЛАЙХ краснеть, становиться красным redden, grow red, become red, get red-hot;
нүүр улайх покраснеть turn red in the face;
нүд улайх становиться красным (о глазах) become bloodshot(of eyes)
ичсэндээ улайх краснеть от стыда blush with shame;
хуйхаа хүртэл улайх покраснеть до корней волос flush to the roots of one's hair.

УЛАМ ещё (более), всё больше, ещё, всё stil more, some, more, gradually;
улам бүр всё больше,ещё больше still more, more and more;
улам их ещё больше still bigger;
улам сайн ещё лучше still better;
улам сайжрах становиться ещё лучше become still better;
улам муудах становиться ещё хуже become still worse.

УЛАМЖЛАЛ традиция tradition;
соёлын өв уламжлал культурное наследие cultural heritage

УЛАМЖЛАЛТ традиционный traditional;
уламжлалт ёс заншил традиционный обычай, традиционный обряд traditional custom, traditional ceremony;
уламжлалт баяр традиционный праздник traditional holiday.

УЛАМЖЛАХ продолжать; унаследовать continue, inherit.

УЛАНГАСАХ становиться свирепым, звереть become furious, become brutalized.

УЛБАГАР слабый, вялый weak, flabby.

УЛИГ назойливость; домогательство importunity, nuisance;
улиг домог болох надоедать, быть назойливым importune.

УЛИРАЛ 1) период, сезон season;
2) квартал, семестр quarter semester;
жилийн дөрвөн улирал четыре времени года four seasons of the year;
дулаан улирал тёплый сезон a warm season;
улирлын ажилчин сезонный рабочий season worker;
улирлын төлөвлөгөө квартальный план quarterly plan;
улирлын шалгалт семестровый экзамен semester examination;
улирлын тайлан квартальный отчёт quarterly account.

УЛИРАХ отсрочиваться, отлагаться; проходить, изменяться change, pass; be delayed;
улиран сонгогдох быть переизбранным be re-elected;
анги улирах оставаться на второй год в одном и том же классе remain for the second year in the same class.

УЛС государство, страна, народ, люди state, country; people!
бүгд найрамдах улс республика republic;
социалист улс социалистическое государство socialist state;
найрамдалт улс дружественная страна friendly nation;
улс төр политика politics;
улс амьтан люди people;
улс төрийн товчоо политбюро political bureau;
улс ардын аж ахуй народное хозяйство national economy;
улс олон нийтийн байгууллага государственная и общественная организация state and public organization;
улсын банк государственный банк state bank;
улсын өмч государственная собственность state property;
улсын төсөв государственный бюджет state budget;
улсын төлөвлөгөө государственный план state plan;
улсын хил государственная граница frontier;
улсын нууц государственная тайна state secret;
улсын баяр национальный праздник national holiday;

олон улсын байдал международное положение international situation.

УМАР север north;
умар вүг явах ехать/ идти на север go north.

УМАРД северный north , northern
умард туйл северный полюс north pole;
умард мөсөн далай северный ледовитый океан Arctic Ocean;
Умард атлантын гэрээний байгууллага НАТО североатлантический союз North Atlantic Treaty Organization.

УНАА 1) верховое животное,верховая лошадь saddle-animal,saddle-horse.
2) средства передвижения means of conveyance.

УНАГА жеребёнок foal.

УНАГААХ, УНАГАХ 1) сваливать, сбрасывать, свергать knock down, throw down. overthrow
2) ронять drop, let fall;
мод унагаах сваливать дерево fell a tree, heap the firewood;
хаант засгийг түлхэн унагах свергнуть самодержавие overthrow the tsarist government;
нулимс унагах ронять слёзы drop tears.

УНАХ I падать, сваливаться fall, fall down, drop;
үс унах выпадение волос fall out hairs;
эвдэрч унах разрушаться go to ruin;
сэтгэлээр унах падать духом lose heart;
муужирч унах падать в обморок faint away.

УНАХ II садиться верхом, ездить верхом ride, mount;
морь унах ездить верхом на лошади ride on horseback;
машин унах ездить на автомобиле go by car;
унадаг дугуй велосипед bicycle.

УНГАС шерсть wool.

УНД, УНДАА напиток, питьё drink, beverage;
хоол унд пища food;
сэрүүн ундаа прохладительный напиток cold drink, soft drink;
согтуурууллагч ундаа спиртные напитки alcoholic drinks.

УНДРАХ бить ключом spout;
ус ундарч байна вода бьёт ключом water spout out;
амьдрал ундарч байна жизнь бьёт ключом life is in full swing.

УНЖИХ свисать, отвисать, болтаться, висеть hang down, let down.

УНЖРАХ долго длиться, затягиваться, задерживаться last a long time, be delayed, be dragged out;
хурал 12 цаг хүртэл сунжрав собрание затянулось до двенадцати часов the meeting lasted till twelve o'clock

УНИАР дымка, мгла haze;
униар татах покрываться дымкой be covered with haze.

УНИАРТАХ покрываться дымкой be covered with haze.

УНТАХ спать sleep;
унтахаар хэвтэх ложиться спать go to bed;
бөх унтах крепко спать sleep soundly;
унтаж хоцрох проспать oversleep;
бүхлээрээ унтах спать не раздеваясь sleep with one's clothes on.

УНТЛАГА *унтлагын өрөө* спальная комната, спальня bed-room.

УНТРААЛГА электрический выключитель electric switch.

УНТРААХ тушить, гасить turn off, put out, switch off, extinguish;
лаа унтраах тушить свечу blow out a candle;
гэрэл унтраах выключить свет, гасить свет put out the light;
түймэр унтраах тушить пожар extinguish a fire.

УНТРАХ гаснуть, потухать, become dim, die out;
гал унтрав огонь погас the fire has died out.

УНТУУЛАХ укладывать спать put to bed;
хүүхэд унтуулах укладывать спать ребёнка put the children to bed;
унтуулах эм снотворное средство soporific.

УНШИГЧ читатель reader;
уншигчдын бага хурал читательская конференция reader's conference.

УНШИХ читать, read;
ном унших читать книгу read a book;
лекц унших читать лекции give lectures;
шүлэг унших читать стихи recite poetry;
чанга унших читать вслух read aloud;

өөрөөр унших читать про себя read silently, read to oneself;
уншин сонгох оглашать proclaim, announce;
унших бичиг книга для чтения, хрестоматия text-book.

УНШЛАГА чтение reading;
уншлагын танхим читальный зал, читальня reading room, reading hall;
ангййн гадуурх уншлага внеаудиторное чтение outside reading;
гэрийн уншлага домашнее чтение home-reading.

УР мастерство; художество, умение, изящество skill, mastership, mastery, craftsmanship, refinement;
ур сайтай эд изящное изделие, изделие тонкой работы refine article, artistic goods;
гарын уртай, гартаа уртай искусный, умелый skilful;
ур гаргах проявлять мастерство show mastery, show skill.

УРАГ родственник, родня relations, relatives

УРАГДАХ рваться, разрываться tear, break.

УРАГШ 1) вперед; на юг forward, ahead; south;
2) успех, удача, продвижение success, progress
урагштай успешно, удачно successfully;
урагшгүй неудачный, безуспешный unsuccessful, without progress.

УРАГШАА вперед forward;
урагшаа явах идти вперед advance;
урагшаа ч үгүй хойшоо ч үгүй ни взад ни вперед neither backwards nor forwards;
урагшаа давших наступать вперед, продвигаться вперед move forward.

УРАЛДААН соревнование, состязание competition, emulation; contest;
социалист уралдаан социалистическое соревнование socialist emulation;
морин уралдаан конные скачки horse-race;
уралдаанд дуудах вызывать на соревнование challenge to competition;
уралдаанд түрүүлэх лидировать в соревновании, занять первое место be in the lead, gain first place.

УРАЛДАХ соревноваться, состязаться emulate, compete, contend.

УРАМ вдохновение, ободрение, воодушевление inspiration, spiritual uplift enthusiasm;
урам орох ободряться, воодушевляться be inspired, feel stimulated;
урам хугарах разочаровываться be disappointed.

УРАМШУУЛАХ поощрять, стимулировать encourage, stimulate.

УРАМШУУЛАЛТ стимулирование stimulation, incentive;
эдийн засгийн урамшуулалт экономическое стимулирование economic incentive;
урамшуулалтын систем, система стимулирования the system of stimulation.

УРАН 1) искусный, мастерский, изящный skilful, refined, masterly;
2) художественный artistic;
3) хитрый cunning;
уран барилга архитектура architecture;
уран баримал скульптура sculpture;
уран барималч скульптор sculptor;
уран зураг живопись painting;
уран зураач живописец, художник painter;
уран зохиол художественное произведение, художественная литература belles-lettres;
уран бүтээл художественное произведение work of art;
уран сайхны кино художественный фильм feature film;
уран хатгамал художественная вышивка fancy needle-work;
сайн дурын уран сайхан художественная самодеятельность amateur art activities;
уран үг красноречие, хитроумное слово cunning word, eloquence;
уран арга хитроумный способ crafty maneuver, clever idea.

УРАНХАЙ разорванный, порванный torn, rags, tatters, threadbare;
уранхай хувцас порванная одежда tatters, rags.

УРАХ разорвать, порвать; царапать tear, break off; scratch;
хувцсаа урах порвать одежду tear one's dress;
гараа урах царапать руку scratch one's hand.

УРВАГЧ изменник, предатель traitor, betrayer.

УРВАХ 1) поворачиваться, оборачиваться turn around, turn back;
2) изменять, предавать betray, be false.

УРГАМАЛ растение, растительность plant, vegetation;
нэг наст ургамал однолетнее растение annual;
олон наст ургамал многолетнее растение perennial;
тэжээлийн ургамал кормовое растение fodder crops;
эмийн ургамал лекарственное растение medicinal plant/herbs;
хогийн ургамал сорняк, сорное растение weed;
ургамлын аймаг растительный мир, флора the vegetable kingdom, flora;
ургамлын тос растительное масло vegetable oil.

УРГАХ расти, всходить, давать ростки grow, sprout.

УРГАЦ урожай; урожайность harvest, yield, crop; crop capacity;
арвин ургац, өндөр ургац богатый урожай rich harvest, rich bumphy, heavy crop;
ургац хураах собирать урожай gather in the harvest.

УРГУУЛАХ 1) выращивать; растить grow, raise, plant;
2) быть причиной, причинять cause;
мод ургуулах выращивать деревья grow a tree;
сахал ургуулах растить бороду grow a beard;
явдал ургуулах, төвөг ургуулах причинять хлопоты cause trouble.

УРД южный; передний, лицевой southern, front;
урд тал передняя часть front side;
урд зүг юг south
урд хөл передняя нога front leg.

УРДААС с южной стороны, с юга; спереди; навстречу from the south, from the front, beforehand;
урдаас нь харах смотреть спереди look at the front;
машин урдаас ирж явлаа машина ехала навстречу a car was coming.

УРДУУР южной стороной; по передней стороне along the southern side; in front;
урдуур гарах, урдуур өнгөрөх проходить мимо по передней стороне pass in front.

УРЖИГДАР, УРЖДАР позавчера the day before yesterday.

УРЖНАН позапрошлый год the year before last.

УРИА призыв call, appeal, slogan;
майн нэгний уриа первомайские призывы may-day slogans.

УРИАЛАГХАН отзывчивый, любезный kind, responsive, sympathic.

УРИАЛГА обращение, воззвание appeal;
атомын зэвсгийг хориглох тухай уриалга воззвание о запрещении атомного оружия the appeal to ban atomic weapons;
дэлхий дахины Энх тайвны Зөвлөлийн уриалга обращение всемирного Совета Мира world peace Council's appeal

УРИЛГА приглашение invitation;
урилгаар по приглашению on invitation;
урилга тараах разослать приглашения send out invitations;
урилгын хуудас пригласительный билет invitation card

УРИХ приглашать invite, ask;
вочдыг урих приглашать гостей invite guests;
хоолонд урих приглашать на обед invite to dinner;
бүжигт урих приглашать на танцы ask to a dance.

УРЛАГ искусство art;
соёл урлаг культура и искусство culture and art;
дүрслэх урлаг изобразительное искусство fine arts;
ардын урлаг народное искусство folk arts;
урлаг судлал искусствоведение study of art;
урлагийн түүх история искусства history of art;
урлагийн бүтээл произведение искусства work of art;
урлагийн авьяас артистический талант artistic talent;
урлагийн ажилтан работник искусства workers in the field of art;
урлагийн гавьяат зүтгэлтэн заслуженный деятель искусства Honoured art worker;
маш их урлагтайгаар с большим искусством very skilfully.

УРЛАХ мастерить, искусно делать make skilfully.

УРСАХ течь, протекать flow, run;
гол урсаж байна река течёт river flows.

УРСГАЛ 1) течение, поток current, stream, flow;
2) течение, направление trend, tendency;
усны урсгал течение воды current of water;
агаарын урсгал воздушное течение air current;
ширүүн урсгал сильное течение, быстрое течение strong current, rapid current;
вөөлөн урсгал медленное течение slow current;
урсгал дагах идти по течению go with the stream;
урсгал сөрөх идти против течения go against the stream;
урсгалаар тавих пустить на самотёк neglect, let take its course.

УРСГАХ лить, проливать pour, spill;
цусаа урсгах проливать свою кровь shed one's blood;
нулимс урсгах проливать слёзы shed tears.

УРТ длинный; долгий long;
урт хугацаа долгое время long time, long term;
урт нас долголетие long life;
урт зам долгий путь, длинный путь long way;
урт долгион длинная волна wave-length;
урт эгшиг долгий гласный long vowel;
уртын хэмжээ меры длины measures of length;
уртын харайлт прыжок в длину long jump;
уртын дуу протяжная песня long-drawn song.

УРТААШ, УРТААШАА по длине, в длину lengthwise, at full length.

УРТАСГАХ удлинять lengthen, become longer.

УРТДАХ быть слишком длинным, оказываться длиннее be too long.

УРУУ вниз, книзу down, downwards;
уруу газар спуск slope;
уруу царай унылый вид downcast appearance, sad face;
урууга харах смотреть вниз; опрокидываться вверх дном look downwards; turn upside down, capsize;
урууга явах спускаться вниз go down;
уулын уруу вниз с горы down the mountain;
салхины уруу по ветру down the wind;
уруу татах оказывать дурное влияние, испортить кого-нибудь corrupt someone, spoil someone.

УРУУДАХ спускаться go down, come down;
*шатаар урууда*х спуститься по лестнице go downstairs.

УРУУЛ губа, губы lip;
дээд уруул верхняя губа upper lip;
доод уруул нижняя губа lower lip;
сэтэрхий уруул заячья губа harelip;
урууламаа хазах кусать губы bite one's lips.

УРШИГ плохие последствия; беспокойство bad consequence; trouble, nuisance.

УРЬ оттепель thaw;
урь орлоо, урь уналаа наступила оттепель a thaw was set in;
хаврын урь весенняя оттепель spring-thaw;
урин цаг тёплое время года warm time of the year.

УРЬД раньше, прежде; заранее, в прошлом before, formerly, previously, in the past;
урьд өмнө раньше before;
юуны урьд прежде всего first of all, before all, above all;
үүний урьд до этого before this;
хэд хоногийн урьд несколько дней назад several days ago;
урьд үзэгдээгүй непредвиденный, неожиданный unprecedented, unexpected;
урьдын адил как и раньше, как обычно as before, as usual;
урьдаас мэдэх предвидеть, предсказывать foresee, foreknow;
урьдаас болгоомжлох, урьдаас сэрэмжлэх предостерегать, принимать предварительные меры caution, take preventive measures;
урьдаас тогтоох предопределять, заранее устанавливать predetermine, predestine;
урьдаас шийдвэрлэх предрешать, заранее решать decide, predetermine, decide before;
энд урьд сургууль байрлаж байв раньше здесь помещалась школа there was a school here formerly;
урьдаар сперва сначала first, firstly;
урьдаар асуух спросить первым ask first;
урьдаар ирэх прийти первым come first.

УРЬДЧИЛАХ делать заранее; делать вперёд do in advance, give priority;
урьдчилан сануулах предупреждать, делать предупреждение warn, tell forehand, give advance notice;
урьдчилсан предварительный preliminary;
урьдчилан сэргийлэх арга хэмжээ предупредительные меры preventive measures;
урьдчилсан нөхцөл предварительное условие preliminary condition;
урьдчилсан арга хэмжээ предварительные меры preliminary measures;
урьдчилсан шалгалт предварительный экзамен preliminary examination;
цаг уурын урьдчилсан мэдээ прогноз погоды weather forecast

УРЬДЧИЛГАА аванс advance, payment on account;
урьдчилгаа авах брать аванс take advance;
урьдчилгаа өгөх давать аванс give advance.

УС, УСАН вода; водный, водяной water;
бороо ны ус дождевая вода rain-water;
далайн ус морская вода sea-water;
цэвэр ус пресная вода fresh water;
рашаан ус минеральная вода mineral water;
ус цаг уурын алба гидро-метеорологическая служба hydro-meteorological service;
усны нөөц водные ресурсы hydro-resources;
усны түвшин уровень воды water-level;
уух ус, ундны ус питьевая вода drinking water;
усны эргүүлэг водоворот whirlpool;
усны гарам, усны олом брод ford;
усны замаг тина slime, ooze;
усны далан дамба dam;
усны аюул бедствие, вызванное наводнением calamity caused by flood;
усны шувуу водоплавающие птицы waterfowl;
усан зам водные пути water-ways;
усан онгоц пароход ship, vessel;
усан тээвэр водный транспорт water transport;
усан цэрэг матрос sailor, seaman;
усан хангамж водоснабжение water-supply;
усан сан водохранилище reservoir, storage lake;
усан оргилуур фонтан fountain;
усан спорт водный спорт acquatic sport;
усан тээрэм водяная мельница water-mill;
усан цахилгаан станц гидроэлектростанция water-power plant, hydro-electric power station;
усан будаг акварель water-colour;
усан эм микстура mixture, liquid medicine;
усан үзэм виноград grapes;
усанд орох купаться bathe;
усанд сэлэх плавать (в воде) swim (in water);
ус гарах, ус гатлах переправляться через реку cross the water;
ус уух пить воду drink the water;
ус нэвтрэх водопроницаемый permeable to water;
ус үл нэвтрэх водонепроницаемый water-tight, waterproof
усан тэнэг абсолютный глупец complete fool.

УСЖУУЛАГЧ мелиоратор, ирригатор specialist in land-reclamation, irrigator.

УСЖУУЛАЛТ ирригация irrigation.

УСЖУУЛАХ обводнять irrigate, supply with water;
усжуулах систем ирригационная система irrigational system.

УСЛАХ 1) орошать, поливать водой irrigate, water;
2) поить водой water;
тариан талбай услах орошать поля irrigate a field;
мал услах поить скот водой water animals;
цэцэг услах поливать цветы water flowers.

УСТАХ уничтожаться, ликвидироваться be annihilated, be liquidated, perish.

УСТГАХ уничтожать, ликвидировать, упразднять destroy, annihilate, liquidate, abolish, do away;
дайсныг устгах уничтожать врага, уничтожать противника annihilate the enemy;
боолчлолыг устгах ликвидировать рабство abolish slavery;
бичиг үсэг үл мэдэх явдлыг устгах ликвидировать безграмотность wipe out of illiteracy;

хүнийг үй олноор устгах зэвсэг оружие массового уничтожения weapons of mass of destruction.

УСЧИН 1) водовоз, водонос water-carrier;
2) пловец swimmer.

УТАА дым smoke;
утаа гарах дымить smoke, fill with smoke;
утаа баагих, утаа уугих валить клубами, дымиться clouds of smoke are pouring out;
утаа суунаглах подниматься вверх столбом (о дыме) rise in a smoke of column (of smoke);
утаа гаргах; а) пускать дым puff smoke б)топить fire;
утаа тавих пускать дым puff smoke;
утааны яндан дымовая труба chimney;
утаан хөшиг дымовая завеса smoke-screen.

УТАС 1) нитка thread;
2) проволока, провод кабель wire, cable
3) телефон telephone;
4) телеграмма telegram;
5) струна string;
бүүнд утас сувлэх вдевать нитку в иголку thread a needle;
утас нийтгэх сучить нитки spin thread, twist thread;
төмөр утас металлическая проволока metal wire;
цахилгаан утас, чийдэнгийн утас электрический провод electric wire;
утас татах натягивать провода stretch a rope;
автомат утас телефон-автомат automatic telephone;
утсаар ярих разговаривать по телефону speak on the telephone;
утсаар дуудах, утсан дээр дуудах вызвать к телефону call to the telephone;
утас тавих проводить телефонную линию install a telephone;
утасны дэвтэр телефонная книжка telephone directory;
утсаар мэдэгдэх сообщить по телефону telephone something;
танайх гэртээ утастай юу? у вас есть домашний телефон? have you a telephone at home?
цахилгаан утас телеграмма telegram;
баярын утас приветственная телеграмма telegram of congratulation;
утас явуулах послать / отправлять телеграмму send a telegram;
утсан хөгжим струнные инструменты stringed musical instruments.

УТАСДАХ звонить, разговаривать по телефону telephone, speak by telephone;
та буруу газар руу / өөр газар руу утасджээ вы не туда звоните you have got the wrong number.

УТАХ дымить, окуривать; коптить fumigate, smoke;
тарвага утах выкуривать тарбагана из норы smoke out tarbagan from its hole;
утсан хиам копчёная колбаса smoked sausage;
утсан загас копчёная рыба smoked fish.

УТГА смысл, значение, содержание meaning, sense, content;
гол утга главный смысл, основное значение main idea, basic meaning;
шууд утга прямое значение direct sense, direct meaning;
шилжүүлсэн утга, дам утга переносное значение figurative meaning; figurative sense
давхар утга двойственный смысл double meaning;
утга зохиол литература literature;
хүүхдийн утга зохиол детская литература juvenile literature;
гүн утгатай имеющий глубокий смысл profound meaning
утгагүй бессмысленный senseless, meaningless;
муу утгаар ойлгох понимать в дурном смысле take in the wrong spirit.

УУГАН старший, старейший; первый oldest, elder; first;
ууган хүү старший сын the eldest son;
ууган сургууль первая школа the oldest school.

УУДАМ обширный, необъятный vast, wide.

УУДЛАХ рыться, копаться; искать, раскрывать rummage, ransack, delve search, reveal, uncover;
авдар уудлах рыться в сундуке rummage in a chest;
өвөө уудлах искать за пазухой, рыться в кармане search in the breast pocket

УУЖИМ широкий, просторный spacious, wide.

УУЖРАХ успокаиваться calm down, be relieved.

УУЖУУ, УУЖУУХАН 1) просторный свободный spacious, roomy;
2) спокойно calmly, quietly.

УУЛ I гора mountain;
уул нуруу горная цепь, хребет mountain range;
уул уурхай рудник mining;
уулын орой, уулын оргил вершина горы summit of mountain, peak;
уулын хормой, уулын бэл подножие горы foot of mountain;
уулын ар северная часть горы back side of a mountain;
уулын өвөр южная часть горы the sunny side of a mountain;
цагаан уул цэцэг эдельвейс edelweis.

УУЛ II основной, коренной, исконный, данный, тот самый original, basic; aformentioned, that very same;
уул нутаг основное местожительство, родное место place of origin, native place;
уул нь вообще in general, commonly;
уулаас вообще, сначала originally, from the beginning.

УУЛАРХАГ горный, гористый mountainous;
уулархаг орон горная страна mountainous country.

УУЛЗАЛТ встреча, свидание meeting, encounter;
нөхөрсөг уулзалт дружественная встреча welcome, friendly meeting;
зөвлөлдөх уулзалт консультативная встреча consultative meeting;
сонгогчидтойгоо хийх уулзалт встреча с избирателями meeting with one's constituents;
уулзалт хийх устроить встречу have a meeting.

УУЛЗВАР стык, перекрёсток joint, junction, crossing;
вамын уулзвар перекрёсток дорог road junction, crossroads.

УУЛЗАХ встречаться, видеться meet, come across, see;
хааяа уулзах редко встречаться с кем-либо see little of somebody;
дахин уулзъя увидемся ещё раз see you again.

УУР I пар, испарение steam, vapour;
уур амьсгал климат climate;
уурын халаагуур, уурын халаалга паровое отопление steam-heating;
цаг уур погода, метеорология weather, meteorology;
уур болох превращаться в пар evaporate.

УУР II гнев, ярость anger, fury, wrath;
уур хүр эх гневаться, сердиться be angry;
ууртай сердитый angry, furious

УУРАГ 1) молозиво colostrum, beestings;
2) белок egg-white;
уураг тархи головной мозг brain.

УУРЛАХ сердиться, гневаться be angry;
надад бүү уурлаl не сердитесь на меня! don't be angry with me!

УУРЛУУЛАХ сердить, гневать, злить make angry, anger.

УУРХАЙ 1) рудник, шахта mine, pit;
2) источник, кузница source; smithy;
чулуун нүүрсний уурхай каменноугольная шахта coal pit;
ил уурхай разрез, карьера open pit;
эх уурхай источник, кузница source, forge

УУРХАЙЧИН шахтёр miner;
уурхайчны өдөр день шахтёра miner's day.

УУСАХ растворяться dissolve;
усанд уусах растворяться в воде dissolve in water.

УУСМАЛ раствор solution.

УУТ мешок bag, sack;
дэрний уут наволочка pillow-case.

УУХ пить drink;
цай уух пить чай drink tea, have tea;
эм уух принимать лекарство take a medicine;
уух ус питьевая вода drinking water

УУХИЛАХ пыхтеть, задыхаться puff, pant, choke, suffocate;
уурлан уухилах задыхаться от гнева choke with anger;
халууцсанаас уухилах задыхаться от жары suffocate with the heat.

УУЧЛАЛ прощение, извинение forgiveness, pardon;
уучлал гуйх просить прощения у кого-либо ask somebody's pardon.

УУЧЛАМААР простительный, извинительный pardonable, excusable.

УУЧЛАХ прощать, извинять forgive, pardon, excuse;
намайг уучлаарай! простите меня! excuse me! pardon me!

УУЧЛАШГҮЙ непростительный unpardonable, inexcusable.

УУШ: *идэш ууш* продукты питания food products;
идэш уушны дэлгүүр продуктовый магазин grocery store.

УУШИГ лёгкие, легкое lung;
уушигны үрэвсэл воспаление лёгких, пневмония pneumonia.

УХААЛАГ умный, разумный clever, wise;
ухаалаг хүн умный человек clever man

УХААН 1) ум, разум, рассудок mind, sense, reason, intellect;
2) сознание consciousness;
3) наука, учение branch of science;
эрүүл ухаан здравый смысл common sense;
саруул ухаан светлый ум clear brain;
нарийн ухаан тонкий ум subtle intellect;
хар ухаан простой ум, обычная практика one's experience, one's practice;
ухаан гаргах, ухаан зарах придумать способ, находить выход think over, think up a way, find ways;
ухаан алдах потерять сознание lose consciousness;
ухаангүй байх быть без сознания be unconscious;
ухаан орох прийти в сознание recover consciousness, come to one's mind;
шинжлэх ухаан наука science;
сурган хүмүүжүүлэх ухаан педагогика pedagogics;
ухаан нь, ухаандаа по сути дела, в действительности, на самом деле in fact, indeed.

УХААРАХ понимать, постигать, осознавать comprehend, realize, conceive;
буруугаа ухаарах сознавать/понимать свою вину acknowledge one's guilt;
үүргээ ухаарах сознавать свой долг recognize one's duty.

УХАГДАХУУН понятие concept, idea, notion.

УХАМСАР сознание consciousness;
ангийн ухамсар классовое сознание class consciousness;
улс төрийн ухамсар политическое сознание political consciousness
ухамсартай хүн сознательный человек conscious person.

УХАМСАРЛАХ понимать, сознавать be conscious, comprehend, understand.

УХАСХИЙХ вскакивать с места, рвануться jump up from one's place, dash forward.

УХАХ копать, рыть dig, mine, burrow;
газар ухах рыть землю dig the ground, dig up land;
нүх ухах рыть яму dig a hole.

УХВАР понимание, рассудительность, сознательность understanding, comprehention;
ухвар мөчид недостаточно сознательный unreasonable.

УХУУЛАГЧ агитатор agitator;
ухуулагчийн өврийн дэвтэр блокнот агитатора agitator's notebook.

УХУУЛАХ агитировать, пропагандировать; разъяснять, объяснять agitate, propagandize,; explain;
сонгуулийн өмнөх ухуулга предвыборная агитация election campaign;
ухуулгын хэрэгсэл средства пропаганды publicity media;
ухуулах хуудас агитационная листовка agitational leaflet.

УХУУЛГА агитация, пропаганда agitation, propaganda;
сурталчилгаа ухуулгын ажил агитационная работа, пропагандистская работа agitational work, propagandistic work.

УЦААР раздражение irritation.

УЦААРЛАХ раздражаться get irritated, chafe;
ул ялих юманд уцаарлах раздражаться из-за пустяков, раздражаться по пустякам get irritated at a mere nothing.

УЧИР I причина, основание; случай, обстоятельство cause, reason, motive; occasion, circumstance;
учир шалтгаан причина, аргумент reason, argument
учир байдал обстоятельство, положение circumstance; position;
учир утга смысл, значение, суть meaning, significance;
учрыг олох найти причину; выяснить realize, understand, find out;
асуудлын учрыг олох выяснить вопрос elucidate a question;

учрыг мэдэх знать обстоятельство know the reason;
учир мэдэх, учраа мэдэх понимать, быть сознательным understand, comprehend;
учраа хэлэх, учрыг тоочих говорить всю причину tell all the reason.

УЧИР II так как, потому что; ввиду того, что because, on account, in consequence, for the reason
тэр мэдэхгүй учраас үүнийг хийсэн он сделал это, потому что не знал he did it because he did not know;
учраас, учир нь, учир юу гэвэл потому что for this reason, because;
ямар учраас? из-за чего? почему? for what reason? on what ground?
ийм учраас, учир иймээс поэтому therefore, owing to this, for this reason
учир утгагүй юм ярих говорить бессмыслицу speak nonsense;
учиргүй весьма, очень, чересчур, ужасно very, extremely, exceedingly, terribly;
учиргүй хүйтэн ужасно холодный terribly cold;
учиргүй үнэтэй чрезвычайно дорогой very expensive;
учиргүй уурлах быть чересчур сердитым; сердиться без всякой причины be very angry; be angry without reason.

УЧРАЛ встреча, случай meeting; occasion.

УЧРАЛТ: *учралт хань, учралт нөхөр* спутник жизни, друг судьбы friend of life, friend of fate.

УЧРАХ 1) встречаться; встречать meet, come across;
2) случаться, приключаться occur, happen;
бэрхшээлтэй учрах встречаться с затруднениями meet with difficulties, encounter diffculties;
нүүр учрах встретиться лично meet personally;
халз учрах встретиться лицом к лицу meet face to face

УЧРУУЛАХ причинять, наносить, подвергать cause to meet, put in the way;
саад учруулах чинить препятствие put obstacles;
хохирол учруулах причинять ущерб cause to damage;
аюул учруулах подвергать опасности expose to danger, endanger.

УЯА завязка: верёвка; привязь string, lace, tie, rope; tether;
морины уяа коновязь tethering post;
уяатай морь привязанный конь tethered horse;
уяатай нохой привязанная собака, собака на цепи dog on a leash.

УЯЛДАХ связываться, увязываться, согласовываться be connected, be coordinated, correspond mutually.

УЯЛДУУЛАХ согласовывать, координировать, увязывать coordinate, link.

УЯН гибкий, эластичный, упругий, мягкий flexible, elastic, resilient, soft;
уян хатан бодлого гибкая политика flexible policy;
уян сэтгэлтэй мягкосердечный, сердобольный soft-hearted, tender-hearted.

УЯНГА лиричность, мелодичность lyricism, melody, tunefulness;
уянгын шүлэг лирическое стихотворение lyric;

УЯНГАЛАХ звучать мелодично be melodious.

УЯРАХ растрогаться, умиляться: делаться мягким be deeply moved, be touched; become soft;
сэтгэл уярах растрогаться be touched at heart.

УЯРААХ, УЯРУУЛАХ трогать, умилять; делать мягким touch, move, affect, soften;
сэтгэл уяраах трогать сердце touch one's heart;
уйлтал нь/нулимс унагатал нь уяраах трогать до слёз move to tears

УЯХ 1) привязывать, завязывать tie, bind, tether;
2) задерживать delay, hinder;
ажил уях задерживать работу hinder somebody's work

Ү

ҮГ слово, речь word, speech;
зүйр үг пословица поговорка proverb;
мэргэн үг, цэцэн үг афоризм, крылатые слова aphorism;
үнэн үг честное слово word of honour;
сайхан үг, манж үг красивые слова, лестные слова cunning words;

хатуу үг, тарүүн үг грубое слово, неучтивое слово coarse words, rude words;
доромжилсон үг оскорбительное слово insulting word
хоосон үг пустые слова empty words;
бүдүүлэг үг вульгарные слова, вульгаризм vulgarism;
өмнөх үг предисловие preface, foreword
төгсгөлийн үг заключительное слово, эпилог, послесловие concluding words, epilogue, afterword;
сүүлчийн үг последнее слово last word;
гашуудлын үг надгробное слово, слово соболезнования funeral oration;
хэлсэн үг речь, выступление speech;
үгийн утга лексическое значение, значение слова lexical meaning;
үгийн бүтэц структура слова word structure;
үгийн гарал этимология etymology;
үгийн сүлжээ кроссворд cross-word;
үг хэлэх говорить, иметь слово, произносить речь, выступать с речью speak, make a speech, deliver a speech, have a word;
үг дуулах, үг сонсох, үг авах, үгэнд орох слушаться, подчиняться чьему-либо слову listen, follow somebody's advice;
үг алдах проговориться, обмолвиться make a slip in speaking, let out a secret;
үг булаалдах, үг зөрөх спорить argue;
үгэндээ хүрэх сдержать своё слово keep one's word;
үгэнд итгэх верить на слово take somebody's word;
үгээ буцаах брать свои слова назад take back one's words;
үг дуугүй безоговорочно, беспрекословно without a word, unconditionally;
үгэн дээрээ на словах in words, by words of mouth;
үг үсэгчилэн слово в слово, буквально, дословно word for word, litterally;
нэг үгээр одним словом in a word, in short;
түүний үгээр бол по его словам according to him.

ҮГДРЭХ осложняться be complicated.

ҮГЛЭХ ворчать grumble;
аман дотроо үглэх бормотать mumble, mutter.

ҮГҮЙ, ГҮЙ не, нет; отсутствие, неимение no, not; absence;
үгүй байх отсутствовать be absent;
үгүй болох исчезать, теряться disappear, pass out of sight;
үгүй хайх ,үгүй болгох уничтожать, ликвидировать annihilate, destroy, liquidate;
чи түүнийг үзэв үү? Үгүй, би түүнийг хараагүй. Ты его видел? Нет, я его не видел Did you see him? No, I did not;
огтхон ч үгүй вовсе нет not at all;
яагаад үгүй гэж? почему нет why not?

ҮГҮЙСГЭХ отрицать deny.

ҮГЭЭГҮЙ бедный, нищий, неимущий poor, indigent, impoverished.

ҮД полдень noon, midday;
үдээс өмнө до полудня forenoon;
үдээс хойш после полудня afternoon;
үдийн алдад, үдийн хирд к полудню around noon;
үдэд в полдень at noon;
үдийн хоол обед lunch;
үдийн завсарлага обеденный перерыв lunch break.

ҮДЛЭХ делать полуденный отдых have a noon rest.

ҮДЭЛТ проводы, провожание seeing off.

ҮДЭХ I провожать see off.

ҮДЭХ II простёгивать, шнуровать fasten with cord, passed through a hole.

ҮДЭШ вечер; вечером evening; in the evening;
үдэш болов наступил вечер it has become evening;
үдэш болгох дождаться до вечера wait for the evening;
үдшийн гэгээ вечерняя заря evening glow;
үдшийн бүрий, үдшийн бүрэнхий вечерные сумерки gloaming, twilight.

ҮДЭШЛЭГ вечер, вечеринка evening-party, evening;
оюутны үдэшлэг студенческий вечер student's party;
хөгжмийн үдэшлэг музыкальный вечер musical evening

ҮДЭЭС: *гутлын үдээс* шнурки для ботинки shoe-laces.

ҮЕ I сустав joint, articulation;
хуруугийн үе сустав пальца joints of finger, knuckle;
үе мөчний өвчин суставной ревматизм rheumatism;
үе булгарах, үе мултрах вывихнуться put out of joints, dislocate.

ҮЕ II 1) период, эпоха, момент period, epoch, moment, time;
2) поколение generation;
3) слог syllable;
цаг үе, үйл явдал время и событие time and events;
орчин үе современность, наше время our time, modern time, the present;
шилжилтийн үе переходный период transitional period;
сүүлийн үед в последнее время in these latter days, lately;
ойрын үед на днях the other day; one of these days;
ямар ч үед в любое время at any time;
тэр үед в то время by that time;
тэр үеэс с тех пор since then;
үе үе время от времени from time to time;
валуу үе молодое поколение the young generation;
валгамж үе, хойч үе будущее поколение future generation, coming generation;
ахмад үе старшее поколение the old generation;
үе тэнгийнхэн, нэг үеийнхэн ровесники, сверстники person of the same age;
үеийн өргөлт слоговое ударение syllabic stress.

ҮЕЛЭХ делить на периоды divide into periods.

ҮЕР наводнение flood, inundation;
үер болох наводняться, затоплять overflow, be flooded.

ҮЕРЛЭХ разливаться, наводнять, затоплять inundate, overflow.

ҮЕРХЭХ дружить, сдружиться be friends, become friends.

ҮЕЧЛЭЛ периодизация division into periods.

ҮЗВЭР зрелище, представление sight, show, perfomance;
үзвэрийн газар учреждение культурных мероприятий place of entertainments.

ҮЗЛЭГ смотр, осмотр, проверка inspection, survey, examination, review;
эмнэлгийн үзлэг медицинский осмотр medical inspection, medical examination;
гаалийн үзлэг таможенный осмотр customs examination;
үзлэг явуулах, үзлэг хийх провести осмотр, организовать осмотр hold a review.

ҮЗМЭР экспонат exhibit.

ҮЗҮҮЛЭЛТ показатель indices, showing;
үндсэн үзүүлэлт основной показатель basic indicator;
тоо, чанарын үзүүлэлт количественные и качественные показатели quantitative and qualitative indices;
өнгөрсөн оны үзүүлэлтээс давах превысить показатели прошлого года exceed last year's showing;
эдийн засгийн үзүүлэлт экономический показатель indices of economy.

ҮЗҮҮЛЭН: *үзүүлэн танилуулах* наглядные пособия visual aids.

ҮЗҮҮЛЭХ 1) показывать, демонстрировать show, demonstrate, display;
2) оказывать render;
хот үзүүлэх показывать город show somebody round the town;
үзэсгэлэн үзүүлэх показывать выставку show somebody exhibition;
үнэмлэхээ үзүүлэх показать свой документ, предъявлять свой документ show one's document;
үлгэр жишээ үзүүлэх показать пример set an example;
эр чадлаа үзүүлэх проявлять свое' мужество display one's strength;
эмчид биеэ үзүүлэх показаться врачу see a doctor;
туслалцаа үзүүлэх оказывать помощь give help;
туслалцаа үзүүлэх оказывать содействие render service, render assistance;
дэмжлэг үзүүлэх оказывать поддержку render support, lend support;
анхны тусламж үзүүлэх оказывать первую помощь give first aid.

ҮЗҮҮР остриё, конец, кончик point; end, tip, edge;
хурц үзүүр острый конец pointed end, sharp tip;
зүүний үзүүр остриё иголки needle point;
хэлний үзүүр кончик языка tip of tongue;
хуруугийн үзүүр кончик пальца finger-tip, finger's end;
дээсний үзүүр конец волосяной верёвки the end of a rope;
нүдний үзүүр поле зрения field of virsion;

үзүүртэй остроконечный, имеющий острие pointed, having a point;
үзүүргүй не имеющий острия, тупоконечный having no point, obtuse.

ҮЗҮҮРЛЭХ заострять, оттачивать sharpen, whet;
харандаа үзүүрлэх заострить карандаш, чинить карандаш sharpen a pencil.

ҮЗЭГ перо, ручка pen;
энгэрийн үзэг, сордог үзэг авторучка fountain pen;
тосон балтай үзэг шариковая ручка ball pen;
үзэгний зүүлт наконечник point-protector.

ҮЗЭГДЭЛ явление appearance,, phenomenon, occurence;
байгалийн үзэгдэл явление природы natural phenomenon;
нийгмийн үзэгдэл общественное явление social phenomenon;
ерийн үзэгдэл обычное явление everyday occurence;
ер бусын үзэгдэл, хачин үзэгдэл странное явление strange thing;
хий үзэгдэл призрак, иллюзия phantom, illusion

ҮЗЭГДЭХ быть видимым, виднеться, наблюдаться; показываться be visible, appear, become apparent; be observed; come in sight.

ҮЗЭГЧ зритель spectator; onlooker, audience.

ҮЗЭЛ взгляд, точка зрения, воззрение, мировоззрение view, idea, opinion, attitude;
үзэл суртал идеология ideology;
үзэл суртлын фронт идеологический фронт ideological front;
эх оронч үзэл патриотизм patriotism;
ертөнцийг үзэх үзэл мировоззрение world outlook, world view.

ҮЗЭМ виноград, изюм raisins, sultana.

ҮЗЭМЖ 1) вид, наружность appearance, look;
2) усмотрение discretion;
үзэмж сайтай приятный на вид, привлекательный nice-looking; pleasant to look at;
хувийн үзэмжээр по собственному усмотрению at one's own discretion.

ҮЗЭСГЭЛЭН 1) красота, прелесть beauty, charm;
2) выставка exhibition;
гоо үзэсгэлэн красота beauty;
зургийн үзэсгэлэн выставка картин art exhibition;
үзэсгэлэнт, үзэсгэлэнтэй красивый, прекрасный, прелестный beautiful, lovely, handsome.

ҮЗЭХ 1) смотреть, видеть see, look, watch;
2) проверять, пробовать; испытывать check up, examine, test, taste, try;
3) считать, рассматривать, думать consider, think, regard, believe;
4) изучать, учить, learn, study;
5) читать, просматривать read;
кино үзэх смотреть фильм see a film;
дуурь үзэх слушать оперу listen to an opera;
музей үзэх посещать музей visit the museum;
телевиз үзэх смотреть телевизор watch a TV;
шалгаж үзэх проверять examine;
хянаж үзэх контролировать control, check up;
хүчээ үзэх пробовать силу try one's strength;
амсаж үзэх пробовать на вкус taste;
хамгийн чухалд үзэх считать самым важным consider it the most important;
үүргээ гэж үзэх считать своим долгом consider it to be one's duty;
гадаад хэл үзэх изучать иностранный язык study a foreign language;
ном үзэх: а) читать книгу read a book;
б) учиться, ходить в школу go to school, study;
бэрхшээл үзэх испытывать трудности, встретить трудности face with difficulties, meet difficulty;
◇ *үзэн ядах* ненавидеть, презирать hate, dislike, detest.

ҮЙЛ 1) деяние, дело, действие, поступок deed, act, affair;
2) рок, судьба fate, destiny
3) шитьё sewing, needlework;
үйл ажиллагаа деятельность activities, activity;
хувьсгалт үйл ажиллагаа революционная деятельность revolutionary activities;
нийгмийн үйл ажиллагаа общественная деятельность public work;
ухамсарт үйл ажиллагаа сознательная деятельность conscious activity;
үйл хэрэг, үйл явдал дело, событие act, event;

сайн үйл благородный поступок good deed;
муу үйл дурной поступок evil deed;
үйлийн үр рок, судьба fate, destiny, cause and effect;
үйлээ үзэх, үйлээ эдлэх страдать, мучиться suffer;
үйл хийх шить, заниматься шитьём do needlework.

ҮЙЛДВЭР промышленность, индустрия industry;
том үйлдвэр крупная промышленность large-scale industry;
хүнд үйлдвэр тяжёлая промышленность heavy industry;
хөнгөн үйлдвэр лёгкая промышленность light industry;
хүнсний үйлдвэр пищевая промышленность food industry;
уул уурхайн үйлдвэр горно-рудная промышленность mining industry;
нэхмэлийн үйлдвэр текстильная промышленность textile industry;
олзворлох үйлдвэр добывающая промышленность extractive industry;
боловсруулах үйлдвэр обрабатывающая промышленность manufacturing industry;
үйлдвэрийн газар промышленное предприятие industrial enterprise;
үйлдвэрийн бүтээгдэхүүн продукция производства, промышленная продукция industrial outpoot; industrial production
аж үйлдвэрийн бараа промышленные товары manufactured goods;
үйлдвэрийн район industrial region, industrial area;
үйлдвэрийн үндсэн салбарууд основные отрасли промышленности main branches of industry;
үйлдвэр-хөдөө аж ахуйн орон индустриально-аграрная страна industrial and agrarian country.

ҮЙЛДВЭРЛЭЛ производство production, manufacture
нийгмийн үйлдвэрлэл общественное производство public production;
социалист үйлдвэрлэл социалистическое производство socialist production;
таваарын үйлдвэрлэл товарное производство commodity production;
нөхөн үйлдвэрлэл воспроизводство reproduction;
хэрэглээний зүйлийн үйлдвэрлэл производство предметов потребления production of consumer goods;
үйлдвэрлэлийн арга методы производства production methods;
үйлдвэрлэлийн харьцаа производственные отношения relations of production;
үйлдвэрлэлийн хэрэгсэл средства производства means of production;
үйлдвэрлэлийн процесс производственный процесс process of production;
үйлдвэрлэлийн сургалт производственное обучение industrial training;
үйлдвэрлэлийн төлөвлөгөө производственный план production plan;
оюутны үйлдвэрлэлийн дадлага производственная практика студентов practical training for students;
үйлдвэрлэлийн даалгавар производственное задание output programme;
үйлдвэрлэлийн хүчин чадал производственная мощность producing capacity.

ҮЙЛДВЭРЛЭХ производить, изготовлять, делать produce, manufacture, make;
үйлдвэрлэх хүч производительные силы productive forces;
үйлдвэрлэх хүчний хөгжил развитие производительных сил development of productive forces;
үйлдвэрлэх хүчний байршил распределение производительных сил distribution of productive forces.

ҮЙЛДВЭРЧИН: *үйлдвэрчний эвлэл* профессиональный союз (профсоюз) trade union, labour union;
Үйлдвэрчний Эвлэлийн Төв Зөвлөл Центральный Совет Профсоюзов Central Council of the Trade Union;
үйлдвэрчний эвлэлийн гишүүн член профсоюза member of trade union;
үйлдвэрчний эвлэлийн хөдөлгөөн профсоюзное движение trade union movement.

ҮЙЛДЭХ делать, производить, совершать make, produce

ҮЙЛС: *ажил үйлс* дела works.

ҮЙЛЧИЛГЭЭ обслуживание, услуги service, utilities
эмнэлгийн үйлчилгээ медицинское обслуживание medical service;
нийтийн ахуй үйлчилгээ коммунально-бытовое обслуживание communal and daily service.

ҮЙЛЧЛЭГЧ обслуживающий servant;
гуанзны үйлчлэгч официант, официантка waiter, waitress;
онгоцны үйлчлэгч стюардесса stewardess;

үйлчлэгч хүмүүс обслуживающий персонал service staff, personal staff.

ҮЙМҮҮЛЭХ мешать, беспокоить, вызывать переполох, приводить в замешательство disturb, disorganize, cause somebody to be in trouble, get somebody into trouble.

ҮЙМЭХ суетиться, толкаться, беспокоиться bustle, become disturbed, be excited.

ҮЙМЭЭН паника, суета, смятение bustle, panic, disorder;
үймээн самуун мятеж, беспорядки revolt, rebellion;
хөл үймээн суета, переполох, толкотня crowd, turmoil.

ҮЙРМЭГ крошки, мелкие куски crumb, fragment;
талхны үйрмэг крошки хлеба crumb of bread.

ҮЙРҮҮЛЭХ рассыпать; крошить, размельчать spill; crumble, crumb; break into small pieces.

ҮЙРЭХ раздробляться, измельчаться crumble, reduce to fragments.

ҮЛ не, no, not;
үл болно воспрещается, нельзя, не допускается not permitted, be prohibited;
орж үл болно! вход воспрещён! no admittance!
Тамхи татаж үл болно! Курить воспрещается! No smoking!
үл таних хүн незнакомец, незнакомый человек stranger, unfamiliar person;
үл хөдлөх хөрөнгө недвижимое имущество immovable property;
үл мэдэг, үл ялих незаметно, слегка unnoticeably, slightly;
үл барам не только... но и; даже not only but also; even;
үл мэдэгч болох притворяться незнающим pretend not to know;
үл тоох, үл ойшоох пренебрегать, игнорировать neglect, disregard, ignore

ҮЛГЭН: *үлгэн салган* очень слабо, еле...еле, едва very weak, feebly, flabbly.

ҮЛГЭР I пример, образец; модель, форма example, model, pattern; sample, sketch
үлгэр жишээ, үлгэр дүүриал пример, образец example, model;
үлгэр жишээ/үлгэр дүүриал авах брать пример take as an example;
үлгэр жишээ болох подавать пример, стать образцом, служить примером become a model, serve as an example;
үлгэр жишээ болгох приводить в пример, следовать примеру, ставить в пример cite as an example, follow the example, set an example, use as an example;
үлгэр жишээ үзүүлэх показать пример show an example.

ҮЛГЭР II сказка, сказание tale, story;
ардын үлгэр народная сказка folk tale;
ёгт үлгэр басня fable;
шог үлгэр юмористическая сказка funny tale;
үлгэр домог легенда миф legend, myth;
үлгэр туульэпос epos;
үлгэрийн орон сказочная страна fairy land;
үлгэр хэлэх, үлгэр ярих рассказывать сказки tell stories.

ҮЛГЭРЛЭХ приводить пример; сравнивать take as an example; compare
үлгэрлэвээс, үлгэрлэн хэлвэл например for example, for instance.

ҮЛДЭГДЭЛ 1) остаток, излишек remainder, remnant, surplus;
2) пережиток survival;
хуучин нийгмийн үлдэгдэл пережитки старого общества a survival of old society.

ҮЛДЭХ оставаться быть излишним remain, stay, be left; be superfluous;
гэртээ үлдэх оставаться дома remain at one's home;
вургаан цаг болоход хэдхэн минут үлдээд байна до шести остаётся несколько минут it is a few minutes short of six;
энэ миний сэтгэлд үүрд үлдэнэ это навсегда останется в моей памяти it will always remain in my memory;
юу ч үлдсэнгүй ничего не осталось nothing remains;
арваас тавыг хасахад тав үлдэнэ от десяти отнять пять останется пять if you take five from ten, five remains
амьд үлдэх остаться в живых survive, come through;
өнчин үлдэх остаться сиротой become an orphan;
өртэй үлдэх остаться в долгу be in debt.

ҮЛДЭЭХ оставлять, покидать; сохранять leave, cause to remain; reserve; keep;
ардаа хол үлдээх оставлять далеко позади leave far behind.
өөртөө үлдээх оставлять за собой reserve for oneself;
хичээлийн дараа үлдээх оставлять после уроков keep in after school.

ҮЛЭМЖ, ҮЛЭМЖХЭН значительный, большой; значительно, очень, весьма considerable, great; considerably, very, much; many;
үлэмж тооны в огромном количестве, большого количества in great number;
үлэмж сайн весьма хороший very good.

ҮЛЭЭХ дуть, раздувать blow;
салхи үлээнэ ветер дует the wind blows.

ҮМХ кусочек morsel;
үмх талх кусочек хлеба a morsel of bread.

ҮНГЭХ мять rumple, crumple
хувцас үнгэх мять одежду rumple clothes.

ҮНДЭС, ҮНДСЭН 1) корень root; 2) основа, основание, базис; источник, начало, происхождение base, basis, foundation, beginning, source, origin; 3) национальность; национальный nationality; national; 4) коренной, основной radical, fundamental, basic, principle, main;
үндэс суурь основа, фундамент basis, foundation;
эх үндэс начало, основа origin, ground;
онолын үндэс теоретическая основа theoretical principles;
эдийн засгийн үндэс экономическая основа economic basis;
үгийн үндэс основа слова stem;
үндэс болгох брать за основу take as a basis;
олон улсын харилцаа международное отношение international relations;
гадаад харилцаа внешние связи, внешние сношения foreign relations;
дипломат харилцаа дипломатические отношения diplomatic relations;
эдийн засгийн харилцаа экономические отношения economic relations;
худалдааны харилцаа торговые связи / отношения trade relations;
соёлын харилцаа культурные связи cultural relations;
найрамдалт харилцаа дружеские отношения friendly relations;
сайн хөршийн харилцаа добрососедские отношения good neighbourly relations;
хэвийн харилцаа нормальные отношения normal relations;
агаарын харилцаа воздушная связь aerial communication;
вам харилцаа средства коммуникации means of communication;
харилцаа тогтоох устанавливать связь/ отношения establish relation, make a contact;
харилцаа таслах порвать связь, разорвать отношения cut relations.

ХАРИЛЦАХ иметь связь, иметь контакты, быть в связи, сноситься have a relation, have a contact, be related, communicate;
харилцан ойлголцох взаимопонимание mutual understanding;
харилцан туслалцах взаимно помогать друг другу, взаимопомощь mutual aid;
харилцан туслалцах гэрээ договор о взаим опомощи mutual assistance treaty;
харилцан бие биеэ хүндэтгэх взаимное уважение друг друга mutual respect each other;
харилцан зөвшөөрөлцөх прийти к взаимному / обоюдному соглашению come to a mutual agreement;
харилцан ашигтай хамтын ажиллагаа взаимновыгодное сотрудничество mutually-advantageous co-operation;
захидлаар харилцах переписываться с кем-либо correspond with somebody.

ХАРИН однако, только, но, а, but, on the contrary.

ХАРИУ ответ; ответный answer, reply, response; return, in return, back;
захидлын хариу, хариу захидал ответное письмо return letter;
хариу айлчлал ответный визит return visit;
хариу арга хэмжээ ответные меры retaliatory measures;
хариу цохилт ответный удар return blow;
хариу авах получить ответ;, мстить obtain a reply, get a return; take revenge, avenge;
хариу өгөх давать ответ give an answer;
хариу хэлэх отвечать answer;
хариу илгээх, хариу явуулах отправлять ответ, посылать ответ send an answer, send back.

ХАРИУЛАХ I 1) отвечать answer, reply, respond;
2) возвращать, давать обратно return, repay, pay back;
асуултад хариулах отвечать на вопросы answer a question;
ачийг хариулах отблагодарить, оплачивать за услугу return somebodys kindness, return a favour, requite.

ХАРИУЛАХ II пасти tend, graze, pasture;
мал хариулах пасти скот graze cattle, pasture cattle.

ХАРИУЛТ I ответ answer, reply;
асуулт хариулт вопрос и ответ question and answer.

ХАРИУЛТ II сдача change;
хариултаа авах получить сдачу get change

ХАРИУЦАХ нести ответственность, отвечать be responsible, answer;
толгойгоороо хариуцах отвечать головой stake one's life on something.

ХАРИУЦЛАГА ответственность responsibility;
хариуцлага хүлээх нести ответственность, взять на себя ответственность carry responsibility, take upon oneself the responsibility;
хариуцлагад татах привлекать к ответственности make answer, make answerable;
хариуцлагатан ответственный responsible;
хариуцлагатай эрхлэгч ответственный редактор editor-in-chief;
хариуцлагатай ажилтан ответственный работник executive;
хариуцлагатай даалгавар ответственное задание main task;
хариуцлагатай үе / цаг критический момент critical moment, crucial moment;
хариуцлагагүй безответственный irresponsible.

ХАРИХ возвращаться, вернуться return, go back;
гэртээ харих идти домой обратно, возвращаться домой go back home, return home;
нас харих стареть grow old.

ХАРЛАХ чернеть turn black, grow black.

ХАРУУЛ караул, стража, охрана guard, watch, patrol;
хүндэт харуул почётный караул guard of honour;
харуулын алба караульная служба guard duty;
харуулын байр караульная будка, караульное помещение sentry-box;
харуулд зогсоох стоять в карауле, нести караул keep guard, be on guard;
харуулд гарах вступать в караул, стоять на часах mount guard, stand watch;
харуул солих сменять караул change the guard, relieve the guard.

ХАРУУЛАХ показывать, заставлять смотреть show, cause to look.

ХАРУУЛДАХ ожидать, сторожить, поджидать с нетерпением wait, observe, keep watch.

ХАРЦ взгляд, взор look, gaze, stare, glance;
зөөлөн харц нежный взгляд gentle look;
ширүүн харц суровый взгляд severe look;
муухай харц, хорсолтой харц свирепый взгляд, враждебный взгляд glare;
харцаа тусгах бросить взгляд glance, cast a glance;
харцаа чиглүүлэх направить взгляд direct one's eyes;
харцаа шилжүүлэх перевести взгляд shift one's gaze, turn one's eyes;
харцаа тогтоох приковать взгляд fix one's eyes.

ХАРЦУУЛ мужчины, мужики man, men, fellows.

ХАРШ дворец palace.

ХАРШ 1) чуждый, враждебный alien, hostile;
2) несовместимый, противоположный, антиincompatible, opposite, anti-;
харш үзэл суртал враждебная идеология alien ideology;
шинжлэх ухаанд харш антинаучный antiscientific;
хуулинд харш незаконный illegal.

ХАРЬчужой, чуждый; иноземный strange, foreign, alien; outlandish;
харь газар чужая земля, чужая страна, чужбина foreign land, foreign country;
харь хэл иностранный язык foreign language;
харийн дайсан, харийн булаан эзлэгчид внешние враги, иностранные захватчики foreign enemy, foreign aggressors.

ХАРЬЦАА 1) отношение, связь relation, attitude;
2) соотношение, пропорция correlation, proportion, ratio;
үйлдвэрлэлийн харьцаа производственные отношения relations of production;
хүчний харьцаа соотношение сил correlation of forces;
эелдэг харьцаа вежливое отношение kind treatment.

ХАРЬЦАНГУЙ относительный, сравнительный; относительно, сравнительно relative, comparative; relatively, comparatively;
харьцангуй үнэн относительная правда relative truth;
харьцангуй онол теория относительности theory of relativity

ХАРЬЦАХ 1) относиться, иметь отношение have a relation, concern, have to do;
2) обращаться, относиться treat;
эелдэг харьцах относиться вежливо treat somebody kindly.

ХАРЬЦУУЛАХ сравнивать, сопоставлять compare, confront;
урьдах жилтэй харьцуулвал по сравнению с прошлым годом in comparision with the last year.

ХАРЬЯА подчинённый подведомственный, находящийся в ведении subordinate, within the jurisdiction.

ХАРЬЯАЛАГДАХ быть подведомственным, быть подчинённым be under somebody's jurisdiction, be subordinate.

ХАРЬЯАЛАХ иметь отношение, ведать bear relation, be in charge.

ХАРЬЯАТ 1) подданный subject;
2) подчинённый subordinate;
гадаадын харьяат иностранный подданый foreign subject.

ХАСАХ I 1) убавлять, уменьшать, сокращать diminish, lessen, reduce, decrease;
2) вычитать, отнимать deduct, substract;
3) исключать, отчислять exclude, except, expel, strike off;
4) лишать deprive, bereave;
хурдыг хасах убавлять скорость reduce the speed;
эрхийг хасах лишать кого-либо прав deprive somebody of rights.

ХАСАХ II 1) отрицательный negative;
2) минус minus;
хасах тоо отрицательное число negative number;
хасах тэмдэг знак вычитания, минус minus sign.

ХАТААХ I сушить, высушивать dry;
өвс хатаах сушить сено dry the hay;
угаасан хувцас хатаах сушить бельё dry the linen.

ХАТААХ II закаливать temper, steel.

ХАТАХ сохнуть, высыхать, засыхать; увядать dry up, get dry; wither.

ХАТГАЛГА 1) подстрекательство instigation, incitement;
2) воспаление, пневмония, колющая боль twinge, pneumonia, shooting-pain;
өдөөн хатгалга провокация provocation;
уутгины хатгалгаа воспаление лёгких inflammation of the lungs

ХАТГАМАЛ вышивание, вышивка embroidery, fancy-work, fine needle-work.

ХАТГАХ 1) колоть, уколоть stab, prick;
2) вышивать embroider;
3) кусать, жалить bite, sting, bite off;
4) подстрекать, инспирировать incite, instigate;
5) втыкать, вонзать; водружать stick, thrust; erect, hoist;
вүүгээр гараа хатгах уколоть руку иглой prick one's hand with a needle;
жадаар хатгах колоть штыком thrust with bayonet;
өдөөн хатгах подстрекать, провоцировать instigate.

ХАТУУ твёрдый, крепкий, прочный, жёсткий; суровый, строгий hard, strong, firm, solid; cruel, severe;
хатуу газар, хатуу хөрс твёрдая земля, твёрдый грунт firm soil;
хатуу хавтас твёрдый переплёт stiff binding;
хатуу сэтгэл жестокое сердце hard heart;
хатуу итгэл твёрдая уверенность firm belief;
хатуу шийдвэр твёрдое решение firm decision;
хатуу үнэмшил твёрдое убеждение strong conviction;
хатуу үг суровое слово hard words;
хатуу сахилга бат железная дисциплина stern discipline;
хатуу шалгалт суровое испытание stern test, severe trial;
хатуу хууль суровый закон drastic law;
хатуу шийтгэл суровое наказание severe punishment;
хатуу арга хэмжээ суровые меры drastic measures;
хатуу үнэ твёрдая цена fixed price;
хатуу архи крепкая водка strong drinks;
хатуу дарлал / мөлжлөг жестокая эксплуатация brutal exploitation;
хатуу зовлон жестокое страдание cruel suffering;
хатуу мах жёсткое мясо tough meat;
хатуу вагон жесткий вагон hard-seated carriage;
амьдралын хатуу сургуулийг туулах, хатуу амьдрал туулах пройти суровую жизненную школу go through a hard school of experience;
хатуу чихтэй тугой на ухо hard of hearing.

ХАТУУЖИЛ закалка; стойкость, выносливость endurance, hardness, staying-power, fortitude;

үзэл суртлын хатуужил идейная закалка ideological training;
тэсвэр хатуужил гаргах проявить стойкость display fortitude;
хатуужилтай выносливый, стойкий hardened, enduring;
хатуужилгүй невыносливый, нестойкий unstable.

ХАТУУЖИХ закаляться, становиться стойким endure, harden oneself,

ХАТУУРАХ затвердевать, становиться твердым harden, become hard.

ХАТУУРХАХ стараться быть строгим; быть чересчур требовательным try to be strict; be too demanding.

ХАХАХ подавиться, поперхнуться suffocate, choke.

ХАХУУЛ взятка, подкуп bribe;
хахуул өгөх дать взятку bribe, give a bribe;
хахуул авах брать взятку take bribe

ХАЦАР щека cheek;
хоёр хацрыг үнсэх поцеловать в обе щеки kiss on both cheeks;
хацар руу нь алгадах ударить кого-либо по щеке give somebody a slap in the face.

ХАЧИН интересный, несбыкновенный, странный interest, unusual; strange;
хачин хүн странный человек strange man;
хачин явдал интересный случай queer thing;
хачин сонин очень интересный very interesting.

ХАЧИР гарнир garnish.

ХАШАА забор, загон, ограда; двор fence, pen; court;
малын хашаа загон для скота enclosure, cattlebarns;
мал хашаанд хаших загонять скот в загон pen cattle.

ХАШГИРАЛДАХ кричать (о многих) shout together.

ХАШГИРАХ кричать, орать cry, shout, scream, yell.

ХАШИН ленивый, медлительный lazy, slow;
хашин морь ленивый конь a slow horse.

ХАШИР бывалый, опытный experienced;
хашир хүн опытный человек experienced person;
хашир суух набираться опыта, становиться опытным become experienced, get some experience;
хашир малчин опытный скотовод experienced cattle-breeder.

ХАШИРЛАХ осторожничать, проявлять осторожность be cautious, be careful

ХАШИХ загораживать, перегораживать enclose, fence in, block up.

ХАЯА край, нижний край edge, lower part of something;
тэнгэрийн хаяа горизонт horizon, skyline.

ХАЯГ адрес addres *сгэрийн хаяг* домашний адрес home adress
захиаг хаягаар хүргэх доставить письмо по адресу deliver a letter at the adress

ХАЯГДАЛ отбросы garbage, refuse, waste matter;
үйлдвэрийн хаягдал производственные отбросы industrial waste products.

ХАЯГДАХ теряться, быть потерянным; быть покинутым be lost be thrown; be abandoned, be left behind

ХАЯГЛАХ адресовать adress

ХАЯЛТ: *ажил хаялт* забастовка, стачка strike;
бүх нийтийн ажил хаялт всеобщая забастовка general strike;
түр зуурын ажил хаялт временная забастовка short-term strike;
суугаа ажил хаялт сидячая забастовка, итальянская забастовка sit-down strike;
ажил хаялт зарлах объявить забастовку announce the strike.

ХАЯЛЦАХ: *үнэ хаялцах* аукцион auction;
үнэ хаялцуулан худалдах продавать с аукциона sell by auction.

ХАЯХ 1) бросать, кидать throw, fling;
2) покидать abandon, reject,
3) терять lose;
4) переставать, бросать give up, leave off;
чулуу хаях/шидэх бросать камни throw stones, hurl stones;
гэр бүлээ хаях бросить/оставлять семью desert one's family;
тамхиа хаях бросить курить give up smoking, leave off smoking;
сургуулиа хаях бросить учебу drop one's studies, give up one's studies;
ажил хаях забастовать strike, go on strike;

цонхоор гаргаж хаях выбросить в окно throw out of the window;
шүлс/цэр хаях выплюнуть split out.

ХИАМ колбаса sausage.

ХИВС ковёр carpet;
хивсний үйлдвэр ковровая фабрика carpet factory.

ХИЙ 1) воздух; газ air, gaz;
2) зря, впустую; бессодержательный, пустой to no purpose, for nothing, idle;
агаарын хий атмосфера atmosphere;
хий дамжуулах хоолой газопроводная труба gas-pipe;
хийн зуух газовая плита gas stove;
хий дэмий зря, напрасно to no purpose, in vain;
хий чалчаа, хоосон чалчаа пустая болтовня idle talk;
хий мөрөөдөл пустые мечты castles in the air;
хий үзэгдэл галлюцинация, призрак hallucination, ghost;
хий ханиалга сухой кашель dry cough.

ХИЙД монастырь cloister, monastery.

ХИЙЛ скрипка violin.

ХИЙЛДЭХ играть на скрипке play the violin.

ХИЙЛГЭХ заставить делать, дать делать, побудить делать cause to do, give to do.

ХИЙЛЦЭХ делать вместе do together.

ХИЙЛЭХ накачивать воздух, надувать воздух pump full, full by pumping;
дугуй хийлэх накачивать шину inflate a tire.

ХИЙМОРЬ: *хий морьтой* удачливый, счастливый lucky;
хий морьгүй неудачливый unlucky.

ХИЙМЭЛ искусственный artificial, man-made;
хиймэл торго искусственный шелк artificial silk;
хиймэл цэцэг искусственные цветы artificial flowers
хиймэл шүд зубные протезы, искусственные зубы artificial teeth, false teeth;
дэлхийн хиймэл дагуул искусственный спутник Земли satellite.

ХИЙСВЭР абстрактный, отвлеченный abstract;
хийсвэр ухагдахуун абстрактное понятие abstract notion;
хийсвэр санаа /бодол отвлеченная идея abstract idea;
хийсвэр тоо отвлеченное число abstract number.

ХИЙСВЭРЛЭЛ абстракция abstraction.

ХИЙСВЭРЛЭХ абстрагировать abstract.

ХИЙСГЭХ развеять; сдувать blow away, blow about.

ХИЙСЭХ нестись, развеваться flutter, wave, blow.

ХИЙХ 1) делать, производить do, make, act;
2) класть, наливать put, pour, fill;
3) носить wear;
та юу хийж байна? что вы делаете? what are you doing?
ажил хийх работать work, do a work;
хичээл хийх заниматься, посещать урок attend a class;
гэрийн даалгавар хийх делать домашнее задание do a home task;
дасгал хийх делать упражнение do exercise;
дадлага хийх проходить практику, практиковаться do practice, do practical work;
илтгэл хийх делать доклад make report;
лекц хийх делать лекцию deliver a lecture;
хурал хийх провести собрание call a conference, convene a meeting;
алдаа хийх делать ошибку make a mistake;
яриа хийх проводить беседу give a talk;
гэрээ/ хэлэлцээр хийх заключить договор/соглашение make a treaty, make an agreement;
айлчлал хийх делать визит pay a visit;
хүлээн авалт хийх устраивать прием hold a reception;
тооцоо хийх делать расчет, производить расчет make a calculation, settle;
дүгнэлт хийх делать вывод draw a conclusion;
оролдлого хийх делать попытку make an attempt;
засвар хийх делать ремонт, ремонтировать repair, carry out repairs;
хоол хийх готовить обед prepare a food, prepare a dinner;
хувцас хийх сшить одежду sew a dress;
ан хийх охотиться hunt;

аялал хийх организовать экскурсию, совершить экскурсию make a tour, travel;
өглөөний дасгал хийх делать утреннюю гимнастику do morning exercises;
· *тус хийх* помогать help;
· *саад хийх* препятствовать hinder, prevent;
аяганд цай хийх наливать чай в чашку pour out a cup of tea;
· *давс хийх* положить соль, солить salt;
· *бээлий хийх* носить перчатки, натягивать перчатки wear gloves, put on gloves;
· *шил хийх* носить очки wear a glasses;
· *бөгж хийх* носить кольцо wear a ring;

ХИЛ граница, рубеж boundary, border, frontier;
улсын хил государственная граница state frontier;
хилийн овоо пограничный знак border marker;
хилийн харуул пограничный караул, пограничная охрана frontier guards;
хилийн будлиан пограничный инцидент frontier incident;
хилийн боомт пограничный пост, пограничная застава frontier post;
хилийн шугам пограничная линия borderline;
хилийн цаана за границей abroad;
хилийн чандаас из-за границы from abroad;
хил нийлэх, хил залгах граничить border, be conterminous;
хил нэвтрэх, хил давах перейти границу cross the frontier.

ХИЛС ложный, несправедливый, клеветнический false, injust, unfair;
хилс хэрэг ложное обвинение, клевета false accusation.

ХИЛЧИН пограничник frontier guard, borderguard.

ХИЛЭГНЭХ гневаться, сердиться be angry.

ХИЛЭН I бархат, вельвет velvet.

ХИЛЭН II гнев, ярость, anger, ire, wrath, fury.

ХИЛЭНЦ грех sin.

ХИЛЭНЦЭТ грешный, греховный sinful.

ХИНШҮҮ гарь smell of burning.

ХИР I 1) мера, предел; способность, возможность measure, limit; ability, capacity
2) около, приблизительно about
3) как, каким образом, в какой степени how, in what degree;
хир хэмжээ, мера, предел, возможность limit, capacity;
хир хэмжээгээр, хир чадлаараа, хир тэнхээгээрээ по мере своей возможности, по мере своих сил all in one's power, within one's capacity;
хирээ мэдэх знать свою меру, знать силы know one's limits, know one's capacity;
хэрээ мэдэхгүй не знающий своих сил, не знающий своих способностей, преоценивающий свои силы overestimate one's ability;
үдийн хирд к полудню by the noon;
нэг жил хир около одного года about one year, within a year;
аль хир, хир вэрэг как, в какой мере, в какой степени how, in what degree;
таны бие хир вэрэг байна? как вы себя чувствуете? how is your health?
тэнд хир олон хүн байна? сколько там людей? how many persons are there?

ХИР II грязь dirt, mud;
хиртэй хувцас, угаах хувцас грязное бельё washing;
хиргүй чистый pure, clean;
хир болох становиться грязным, загрязняться become dirty, become soiled

ХИРИЙН заурядный, обыкновенный, обычный ordinary, commonplace, usual;
хирийн хүн чадахгүй не каждый человек сумеет это сделать not everybody can do it, not everybody is able to do it.

ХИРТЭХ загрязняться, пачкаться become dirty.

ХИРТҮҮЛЭХ делать грязным, запачкать, испачкать soil, dirty, make dirty.

ХИРТЭЛТ затмение eclipse;
нарны хиртэлт солнечное затмение solar eclipse;
сарны хиртэлт лунное затмение lunar eclipse;
бүтэн хиртэлт полное затмение total eclipse;
хагас хиртэлт частичное затмение partial eclipse.

ХИЧНЭЭН сколько how much, how many;
та хичнээн номтой вэ? сколько у вас книг? how many books have you?

ХИЧЭЭЛ I старание, усердие, прилежание, активность diligence, endeavour, effort, activity.

ХИЧЭЭЛ II занятие, урок lesson, studies, class;
монгол хэлний хичээл уроки монгольского языка the mongolian lessons;
хичээл хийх проводить урок, давать урок conduct a lesson, give a lesson;
хичээл давтах повторять урок repeat a lesson, review a lesson;
хичээл таслах пропускать урок/занятие miss a class, miss a lecture;
хичээл хүмүүжлийн ажил учебно-воспитательная работа teaching and educational work;
хичээлийн цаг часы занятий school hours;
хичээлийн жил учебный год academic year;
хичээлийн хуваарь расписание уроков time-table of lessons;
хичээлийн төлөвлөгөө учебный план curriculum.

ХИЧЭЭЛЛЭХ заниматься, учиться study, attend a class
биейн тамир спортоор хичээллэх/ оролдох заниматься спортом go in for sports, indulge in sports

ХИЧЭЭНГҮЙ старательный, аккуратный diligent, assiduous, painstaking, accurate.

ХИЧЭЭНГҮЙЛЭХ усердствовать, быть старательным be zealous, be cautious, be attentive

ХИЧЭЭХ стараться, усердствовать, пытаться endeavour, try, attempt, make an effort;
байдгаараа хичээх стараться изо всех сил do one's utmost, try one's best;
хувиа хичээх думать только про себя, быть эгоистичным take care of one's own life, be egoistic

ХОВ I сплетня gossip, tittle-tattle;
хов вөөх сплетничать slander.

ХОВ II *хов хоосон* совершенно пустой entirely empty

ХОВДОГ жадный, алчный greedy, avid, covetous

ХОВДОГЛОХ жадничать, быть жадным be greedy.

ХОВОР, ХОВОРХОН редкий, скудный; редко rare, scarse, uncommon; rarely, seldom;
ховор ном редкая книга rare book;
ховорхон сайхан бүсгүй девушка редкой красоты girl of uncommon beuty;
ховор(хон) амьтан редкое животное rare animals;
маш ховор очень редко very seldom.

ХОВОРДОХ редеть, становиться редким grow scanty, become rare.

ХОВХ; *ховх цохих* выбивать knock out;
ховх татах оторвать, сорвать tear off, pull off.

ХОВХЛОХ сдирать, отдирать strip off, strach off, tear off, rip off

ХОВХРОХ отдираться, срываться fall off, peel off.

ХОГ сор, отбросы, мусор litter. sweepings, dust, rubbish.
хог тарих, хог хаях сорить, мусорить litter;
хогийн сав мусорный ящик dust-bin;
хог хаях нүх мусорная яма dust-hole.

ХОГШИЛ имущество property, belongings.

ХОДООД желудок stomach;
ходоодны шүүс желудочный сок gastric juice;
ходоодны өвчин желудочное заболевание gastric disease.

ХОЁР два two; second;
хоёрдугаар второй
хоёр сар два месяца two months;
хоёрдугаар сар февраль February;
хоёр дахь өдөр вторник Tuesday;
хоёр зуу двести two hundred;
хоёр мянга две тысячи two thousand;
хоёр давхар двойной double;
хоёр давхар байшин двухэтажный дом two-storeyed house;
хоёр талтай двухсторонний bilateral, two sided;
үзэг харандаа хоёр ручка и карандаш a pen and a pencil;

хоёртоа хүүхэд двухлетний ребенок a child of two, two-year-old child

ХОЁРХОН только два only two

ХОЁУЛ вдвоём, оба, обе two together, both;
та хоёул вы вдвоём, вы оба both of you;
бид хоёул мы оба, мы вдвоём both of us

ХОЖДОХ опаздывать; отставать be late, be overdue;
ажлаас хождох опаздывать на работу be late for the work;
таван минут хождох опаздывать пять минут be five minutes late

ХОЖИГДОХ проигрывать lose;
хөзөр тоглож хожигдох проигрывать в карты lose at cards

ХОЖИМ потом, впоследствии, после afterwards, then, later, later on;
хожим хойно потом later on

ХОЖИХ выиграть, выигрывать win, gain;
өрсөлдөгчөө хожих выигрывать у своего противника beat one's opponent;
цаг хожих выиграть время gain time.

ХОЖУУ позднее, попозже late, tardy.

ХОЖИМДОХ см. Хождох. see **Хождох**

ХОЙГ полуостров peninsula.

ХОЙГУУР севернее; на севере; сзади, позади to the north; in the back, around the back, behind;
хойгуур суух сидеть позади sit in the back;
таныг байхгүй хойгуур при вашем отсутствии, когда вас не было in your absence.

ХОЙНО 1) север, на севере north, to the north;
2) сзади, позади, за behind;
3) после, потом, спустя later, after;
байшингийн хойно сзади дома behind the house;
хоёр сарын хойно после двух месяцев, спустя два месяца, через два месяца after two months, in two months.

ХОЙНООС 1) с севера from north;
2) сзади from the back, from behind;
хойноос дагах, хойноос нь явах идти вслед за кем-нибудь, следовать за кем-либо follow, go after.

ХОЙТ 1) северный north, northern;
2) задний back, hind, rear;
3) следующий, будущий next, future, coming;
хойт зүг явах идти/ ехать на север go north;
хойт хэсэг задняя часть back part; hinder part;
хойт туйл северный полюс north pole;
вүүн хойт северо-восток north-east;
баруун хойт северо-запад north-west;
хойт хөл задние ноги hind legs;
хойт дугуй заднее колесо rear wheel;
хойт үе будущее поколение future generation;
хойт жил следующий год next year;
хойт эх мачеха step-mother;
хойт эцэг отчим stepfather.

ХОЙТОН; *хойтон жил* следующий год next year

ХОЙЧ будущее future;
хойч үе будущее поколение future generation;

ХОЙШ 1) на север, к северу to the north, northwards;
2) назад back, backwards;
3) после after, since;
хойш ухрах пятиться, сделать шаг назад move backwards, make a step back;
хойш тавих отодвинуть назад put off, delay, postpone;
хойш татах тянуть назад, оттягивать, затягивать, pull back, withraw
хойш суух сесть сзади; уклоняться от работы, лениться sit back; deviate from work, be lazy;
хойш яарах торопиться назад, торопиться идти назад hurry to go back;
хойш хийх оставлять на будущее запасаться put away, save, keep;
хойш урагшаа взад и вперёд up and down, back and forth;
хойшоо бай! назад! прочь back! get back!
надаас хойш после меня after me;
түүнээс хойш с того времени, с тех пор since that time, since then.

ХОЙШГҮЙ не позднее, не позже not later.

ХОЙШЛОГДОХ откладываться, отсрочиваться postpone, delay, put off

ХОЙШЛОХ откладываться, отсрочиваться put off,postpone.

ХОЙШЛУУЛАХ откладывать. отсрочивать put off, postpone, delay, put aside, adjourn;
эцсийн шийдвэрийг хойшлуулах отложить окончательное решение. put off the final decision;
хэлэлцээрийг хойшлуулах отложить переговоры adjourn the talks;
уулзалтыг хойшлуулах отложить встречу put off a meeting;
өрөг хойшлуулах отложить партию adjourn a game.

ХОЙШЛУУЛШГҮЙ неотложный pressing, urgent;
хойшлуулшгүй хэрэг неотложное дело urgent business.

ХОЛ 1) даль; далеко distance; far, far off;
2) гораздо, несравнено much, far, incomparably
би эндээс хол суудаг я живу далеко отсюда I live far from here;
холын зай дальнее расстояние long distance;
холын хамаатан дальний родственник distant relative;
хол дээр, хол илүү гораздо лучше far better, much better.

ХОЛБОГДОЛ причастность, отношение connection, relation;
ач холбогдол значение significance;
их ач холбогдолтой байх иметь большое значение be of great importance.

ХОЛБОГДОХ быть связанным, иметь отношение, относиться связываться be connected, have relation, associate;
гэмт хэрэгт холбогдох быть причастным к преступлению be involved in a crime

ХОЛБОГДУУЛАХ: *үүнтэй холбогдуулан* в связи с этим in connection with it.

ХОЛБОО связь, контакт, союз; ассоциация, федерация tie, link, contact, connection, communication, union, association, federation;
нягт холбоотой байх быть/ стоять в тесной связи be closely connected;
нягт холбоо тогтоох установить тесную связь establish close links;
холбоогоо таслах прерывать связь break off relations;
Холбооны яам Министерство связи Ministry of communication.

ХОЛБООТ союзный, федеративный union, federal;
Зөвлөлт Холбоот Улс Советский Союз Soviet Union.

ХОЛБООТОН союзник allies.

ХОЛБООЧИН связист communication worker; signaller, signal man.

ХОЛБОХ соединять, связывать tie together; bind, connect, link;
онолыг практиктай холбох связывать теорию с практикой link theory with practice;
хувь заяагаа холбох связывать свою судьбу throw in one's lot, link one's destiny;
амьдралаа холбох жениться get married, marry.

ХОЛДОХ 1) удаляться, отдаляться, отстраняться move off, move away, become distant
2) быть слишком далеким be too far;
эргээс холдох удаляться от берега move off from the shore.

ХОЛДУУЛАХ удалять, отдалять move off, remove.

ХОЛИЛДОХ смешиваться, перемешиваться mix, interblend, intermingle.

ХОЛИМОГ: *холимог тэжээл* комбикорм mixed feed.

ХОЛИХ смешивать, перемешивать, подмешивать mix, mix up, intermix, intermingle.

ХОЛЬЦ, ХОЛЬЦОО примесь, смесь admixture.

ХОМС, ХОМСХОН скудно, маловата scanty, little, few.

ХОМХОЙ жадный, алчный greedy, covetous.

ХОНГИЛ дупло; пещеро hollow; cave;
модны хонгил дупло дерева hollow of a tree.

ХОНГИО гильза cartrige-case.

ХОНГОР простодушный, добродушный; милый openhearted, simplehearted; dear, darling.

ХОНЖВОР выигрыш, выгода gain, profit, winnings
хонжворт выгодный, выигрышный winning lottery;
хонжворт сугалаа лотерея, выигрышный билет lottery ticket;
хонжворт зээл выигрышный заем lottery loan

ХОНЖОО выгода, прибыль profit, gain;
хонжоо харах искать прибыль seek profit;
ашиг хонжоо олох получать прибыль get a profit, receive a profit;
хонжоо гаргах извлечь выгоду benefit, derive benefit.
ХОНЗОГНОХ мстить, отомстить revenge, take vengeance.
ХОНЗОН месть vengeance, revange.
ХӨНӨГ сутки twenty four hours;
долоо хоног неделя week;
соёл урлагийн арав хоног декада литературы и исскуства ten-day literature and art festival'
вам хоногийн мөнгө суточные daily allowance.
ХОНОГЛОХ оставаться на ночь stay for the night
ХОНОГШИХ запечатлеваться в памяти оставаться в памяти be stamped upon somebody's memory, be engraved upon somebody's memory.
ХОНОХ ночевать, проводить ночь spend the night, pass the night;
хээр хонох ночевать под открытым небом spend the night in the open.
ХОНХ звонок; колокол bell;
цахилгаан хонх электрический звонок electric bell;
хаалганы хонх дверной звонок door bell;
хонх цохих ударить в колокол strike the bell;
хонх дугарах звонить в колокол ring the bell;
хонхон дуу колокольный звон peal, chime.
ХОНХОЙХ иметь ямку, иметь углубление have a hollow, have a depression
ХОНХОЙЛГОХ делать углубление, делать ямку make a hollow, dig a hole
ХОНХОР углубление, выбойна, впадина hollow, depression, cavity, dent
нүдний хонхорхой глазная впадина eye-socket;
вамын хонхор выбойна на дороге pot-hole;
хацрын хонхор ямочка на щеке dimple;
алганы хонхор углубление на ладони the hollow of the palm;
хонхор газар котловина hollow, depression, cave-in
ХОНШООР морда, рыло; носок muzzle; snout; nose, toe:
гутлын хоншоор носок обуви toe of a boat.
ХОНЬ овца sheep
эм хонь овцематка ewe;
эр хонь кастрированный баран, валух castrated ram, wether;
хонины мах баранина mutton, lamb;
хонины нэхий овчина sheepskin;
хонины ноос овечья шерсть fleece.
ХОНЬЧИН чабан, пастух, овец sheepherd.
ХООЛ еда, пища, кушанье, блюдо food, meal, dish;
өглөөний хоол завтрак breakfast;
үдийн хоол, өдрийн хоол обед lunch, dinner;
оройн хоол ужин supper;
хоолны өмнө перед едой before food, before meal;
хоолны дараа после еды after food, after meal;
хоолны үеэр, хоол идэх вуур во время еды, за едой while eating, during a meal;
сувиллын хоол диетический стол invalid cookery;
гэрийн хоол домашний стол plain cooking;
махан хоол мясной стол, мясная пища animal food;
цагаан хоол молочное блюдо milk dish;
хоол зөөгч официантка, официант waitress, waiter;
хоолны давс поваренная соль table salt, common salt;
хоолны халбага столовая ложка table spoon;
хоол хийх готовить кушанье cook, prepare a meal;
хоол идэх есть, обедать take food, dine;
хоол шингээх, хоол боловсруулах усвоение пищи, пищеварение digest food, digestion;
хоолны хордлого пищевое отравление food poisoning;
халуун хоол горячая пища hot food, hot meals.
ХООЛЛОХ питаться, обедать feed, eat food;
сайн хооллох хорошо питаться have good food.
ХООЛОЙ 1) горло throat;
2) голос voice;
3) труба pipe, tube;
амьсгалын хоолой, буруу хоолой дыхательное горло windpipe;
хоолой сөөх охрипнуть grow hoarse;

хоолой засах откашливаться, прочищать горло clear one's throat;
бүдүүн хоолой густой голос, низкий голос deep voice, low voice;
нарийн хоолой тонкий голос, высокий голос high voice;
нарийн хоолой тонкий голос, высокий голос high voice;
сөөнгө хоолой хриплый голос hoarse voice;
төмөр хоолой металлическая труба metal tube, iron tube;
нефть дамжуулах хоолой нефтепроводная труба oil pipe-line;
хий дамжуулах хоолой газопроводная труба gas-pipe;
уурын дулаагуурын хоолой труба парового отопления steam-heat pipe.

ХООРОНД 1) между between, in between; inter-;
2) между тем, как, в то время как; пока while, meanwhile;
хоёр уулын хооронд между двумя горами between two mountains;
та бид хоёрын хооронд между нами between you and me'
хоёроос гурван цагийн хооронд между двумя и тремя часами between two and three o'clock;
намайг эзгүй хооронд в моё отсутствие; в то время, когда меня не было in my absence, while I was absent;
хоёр нарны хооронд ажиллах работать от зари до зари work from morning to night, work from night to morning;
нүд ирмэхийн хооронд в мгновение ока, мгновенно in the twinkling of an eye;
хоёрын хооронд ни то ни сё neither one thing nor the other;
хот хоорондын тээвэр междугородные перевозки interurban transport.

ХООСОН 1) пустой, порожний empty, vacant, vain; deserted;
2) бедный, нищий poor;
хоосон сав пустая посуда empty container;
хоосон ам, хоосон үг пустые слова, пустая болтовня mere words, empty words, idle talk;
хоосон санаархал, хоосон мөрөөдөл пустые мечты castles in the air;
хоосон газар пустое место, необитаемое место uninhabited place;
хоосон хонох ночевать с голодным желудком, лечь спать без ужина go to sleep without eating;
гар хоосон буцах возвращаться с пустыми руками return empty-handed;
хоосон хүн бедняк, бедный человек, нищий, poor man; beggar;
хоосон цай уух пить только один чай drink tea only.

ХООСРОХ 1) становиться пустым, опоражниваться become empty;
2) беднеть, разорять, нищать become poor, ruin oneself

ХОР 1) яд, отрава poison, toxic;
2) вред зло harm, damage; evil;
3) зависть envy;
могойн хор змейный яд venom;
галын хор огнетушитель fire extinguisher;
вургийн хор проявитель developer;
хор хөнөөл вред, ущерб damage, harm;
хор шар зависть envy;
хор уух принять яд take poison;
удаан үйлчлэх хор медленно действующий яд slow poison;
хор хүргэх причинить вред harm, do harm;
хор малтах, хор хөдөлгөх возбуждать зависть excite envy in somebody, rouse somebody's envy;
хоргүйгээр без вреда without detriment.

ХОРВОО вселенная, земля universe, world.

ХОРГОДОХ укрываться, прятаться, находить убежище seek shelter, take shelter, find shelter;
бороноос хоргодох укрываться от дождя take shelter from the rain;
хоргодох газар приют, убежище refuge, asylum.

ХОРГООХ задерживать, не пускать detain, delay, keep off.

ХОРДЛОГО отравление poisoning;
хоолны хордлого пищевое отравление, диспепсия food poisoning, dyspepsia

ХОРДОХ 1) отравляться be poisoned, poison oneself.
2) завидовать envy.

ХОРДУУЛАХ отравлять poison.

ХОРИГ запрет, препятствие, вето interdiction, obstacle, veto;
хориг тавих наложить запрет, наложить вето impose a ban, put a veto.

ХОРИГДОЛ узник, заключенный prisoner;
улс төрийн хоригдол политический заключенный political prisoner

ХОРИГДОХ 1) быть прегражденным be blocked up;
2) быть заключенным be imprisoned.

ХОРИГЛОХ запрещать, воспрещать forbid, interdict, prohibit;
атомын зэвсгийг хориглох запрещение атомного оружия prohibition of atomic weapons.

ХОРИО запрет, запрещение, воспрещение interdiction, prohibition;
гэрийн хорио домашний арест house arrest'
хориотой затретный forbidden;
хориотой тоглоом запретная игра prohibited game;
хориотой бүс запретная зона restricted area.

ХОРИХ 1) запрещать, воспрещать forbid, interdict, prohibit
2) отговорить dissuade;
3) заключать в тюрьму, бросить в тюрьму imprison somebody,put somebody into prison.

ХОРОГДОЛ убыль, потеря diminution, decrease; loss;
төлийн хорогдол потеря молодняка loss of young livestocks.

ХОРОГДОХ уменьшаться, убавляться; сокращаться diminish, decrease• lessen.

ХОРОГДУУЛАХ уменьшать, убавлять, сокращать diminish, decrease, lessen;
хоёр дахин хорогдуулах сокращать вдвое cut by twice;
вардлыг хорогдуулах сократить расходы cut down expenses;
орон тоог хорогдуулах сокращать штат reduce the establishment, cut the staff;

ХОРОМХОН моментально, мгновенно instantly, in a moment.

ХОРОН ядовитый; язвительный, колкий poisonous; caustic, biting;
хорон санаа злой замысел, коварство evil intent;
хорон үг колкие слова, язвительное замечание caustic words, biting remarks.

ХОРОО 1) комитет committee;
2) полк regiment;
3) район, квартал region, district
Намын Төв Хороо Центральный Комитет партии Central committee of the party;
Намын хороо партийный комитет party committee;
гүйцэтгэх хороо исполнительный комитет executive committee;
байнгын хороо постоянный комитет standing committee;
бэлтгэл хороо подготовительный комитет preparatory committee;
намын хянан шалгах хороо комитет партийного контроля party control committee;
залуучуудын эвлэлийн төв хороо центральный комитет союза молодёжи central committee of the youth league.

ХОРООЛОЛ район, квартал region, block;
орон сууцны шинэ хороолол новые жилые кварталы new housing estates, new blocks of flats.

ХОРООХ 1) убавлять, уменьшать, сокращать diminsh, decrease, lessen;
2) казнить execute, put to death;
газар хороох сокращать расстояние shorten the distance;
тоо хороох уменьшать количество diminish the number.

ХОРОХ убавляться, сокращаться diminish, decrease.

ХОРСОЛ ненависть, злоба, отвращение hatred, detestation, abhorrence;
өшөө хорсол ненависть hatred.

ХОРСОХ I ненавидеть, таить злобу hate, detest.

ХОРСОХ II чувствовать жгучую боль have a burning pain.

ХОРТ, ХОРТОЙ 1) ядовитый, токсичный poisonous, toxic;
2) вредный, злостный harmful, unhealthy, malicious;
хорт хий ядовитый газ poison gas;
хорт бодис ядовитое вещество poisonous substance;
хорт могой ядовитая змея venomous snake;
хорт дайсан коварный враг insidious enemy;
хортой эм вредное лекарство harmful medicine;
ажлын хортой нөхцөл вредные условия работы unhealthy conditions of work

эрх мэдлээ хортойгоор ашиглах злоупотреблять властью, злоупотреблять своим положением abuse one's power, abuse one's position.

ХОРХОЙ I насекомое, червь, моль insect, worm, moth;
цох хорхой жук beetle;
шанаган хорхой головастик tadpole;
хорхой идсэн шүд кариозный зуб carious tooth;
хорхой идэх: а) червоточина worm-hole;
б) повреждение молью, изъеденный молью moth-eating.

ХОРХОЙ II аппетит, желание, охота appetite, desire, longing, wish;
хорхой хүрэх, хорхой хөдлөх сильно хотеть, страстно желать, гореть желанием have a passion, eagerly desire, burn with desire;
хорхойгоо дарах умерять свой аппетит keep down one's appetite, moderate one's appetite;
хорхой хөдөлгөх, хорхой хүргэх вызывать аппетит, вызывать желание tempt the appetite, excite the appetite.

ХОРШОО 1) кооперация, кооператив co-operation, co-operative
2) магазин store, shop;
хоршоо дэлгүүр магазины stores.

ХОРШООЛОЛ кооперирование, кооперация co-operation, co-operative;
үйлдвэрийн хоршоолол производственная кооперация producting co-operative system;
өд хэрэглэгчдийн хоршоолол потребительская кооперация consumers, co-operative societies;
хөдөө аж ахуйн хоршоолол сельскохозяйственная кооперация agricultural co-operative societies;
хоршооллын хөдөлгөөн кооперативное движение the co-operative movement.

ХОРШООЛОХ кооперировать, co-operate, combine into co-operation, organize in a co-operative.

ХОРЬ, ХОРИН двадцать twenty;
хорьдугаар двадцатый twentieth;
хорьдугаар зуун двадцатый век twentieth century;
хорин хоёр двадцать два twenty two;
хорин мянга двадцать тысяч twenty thousand.

ХОС пара; парный pair, couple; twin;
хос гутал пара сапог, пара ботинок pair of boots, pair of shoes;
хос хосоор попарно in pairs, two by two, two and two
хосгүй бесподобный, превосходный, несравненый matchless, peerless, incomparable, excellent.

ХОСЛОЛ сочетание, комбинация combination.

ХОСЛОХ сочетаться, комбинировать combine.

ХОСЛУУЛАХ сочетать combine;
онол практикийг хослуулах сочетать теорию с практикой bring into concord theory with practice.

ХОТ 1) город city, town;
2) группа юрт camp of several yurts;
нийслэл хот столица, столичный город capital;
гол хот главный город chief town;
хот тосгон город и деревня town and country;
хотын хүн ам городское население urban population;
хотын захиргаа муниципалитет, городское управление municipality;
хотын төв центр города the centre of a city;
хотын зах гарч явах выехать за город go to the country, go out of town;
хотруу явах пойти / поехать в город go to town;
хот айл группа юрт camp of yurts.

ХОХИРОЛ убыток, ущерб, урон loss, damage, detriment;
гарз хохирол потеря loss;
хохирол учруулах наносить ущерб cause damage, do damage;
хохирол учрах, хохирол хүлээх нести урон, понести ущерб suffer damage, suffer a loss;
хохирлыг нөхөх компенсировать убыток, возмещать убыток pay damages, recover losses;
хохиролтой убыточный, невыгодный unprofitable, disadvantageous;
хохиролгүй без ущерба without prejudice, without loss;
хохирол их биш байв ущерб был невелик the damage was not great.

ХОХИРОХ терпеть ущерб, нести урон be damaged, suffer loss;
хохирогч этгээд потерпевший victim.

ХОХЬ 1) утрата, неудача misfortune, mischance;
2) бедный poor.

ХОЦРОГДМОЛ отсталый backward, retarded;
хоцрогдмол орон отсталая страна undeveloped country.

ХОЦРОХ 1) отставать; оставаться позади fall behind, drop behind, lag behind;
2) оставаться remain, be left;
3) отставать be slow;
амьдралаас хоцрох отставать от жизни lag behind the life;
би энд хоцроно я остаюсь здесь I shall remain here;
миний цаг хоёр минут хоцорч байна мои часы отстают на две минуты my watch is two minutes slow, my watch loses two minutes

ХОЧ прозвище, кличка nickname.

ХОШИГНОХ шутить joke, jest.

ХОШИГНОЛ шутка, юмор joke, jest, humour.

ХОШИН шутливый, юмористический, шуточный, комический witty, humorous, playful, funny; comic;
хошиг үг, хошин яриа анекдот, смешной рассказ,
шутка joke, funny story;
хошин жүжиг комедия, сатира comedy, satire.

ХОШОЙ дважды twice;
хошой баатар дважды герой twice hero;
хошой аварга дважды чемпион twice champion,

ХОШУУ 1) клюв beak, bill;
2) заостренная часть чего-либо, наконечник sharp point, tip, forepart;
вааны хошуу хобот trunk;
таван хошуу пятиконечная звезда five-pointed star;
таван хошуу мал пять видов скота five kinds of domestic animals;
анжисны хошуу сошник у плуга ploughshare;
харандааны хошуу наконечник для карандаша point-protector.

ХОШУУЧ майор major.

ХОШУУЧЛАХ быть в авангарде, лидировать be at the head, lead, be in the lead.

ХӨВГҮҮН юноша youth.

ХӨВӨН вата, хлопок cotton, cotton wool;
хөвөнтэй хөнжил ватное одеяло quilt;
хөвөн хураалт хлопкоуборка cotton-harvesting;
хөвөн хураагч машин хлопкоуборочная машина cotton-picking machine;
түүхий хөвөн хлопок-сырец raw cotton.

ХӨВӨӨ 1) набережная, побережье, берег shore, beach, bank;
2) край edge.

ХӨВӨХ плавать, дрейфовать float, drift.

ХӨВСГӨР рыхлый friable, loose.

ХӨВЧ лес forest.

ХӨВЧИН весь, целый, все, whole, all;
хөвчин дэлхий весь мир, вся планета whole world.

ХӨГ I гармония; настройка tune, cord.

ХӨГ II; *хөгийн, хөгтэй* смешной, забавный ridiculous, funny;
хөгийн хүн странный человек, чудак strange man, queer man.

ХӨГЖИЛ 1) развитие, прогресс, расцвет, рост development, progress, growth;
2) веселье gaiety;
аж үйлдвэрийн хөгжил развитие промышленности development of industry;
оюун ухааны хөгжил умственное развитие mental development;
хөгжилтэй, а) развитой developed;
б) весёлый, жизнерадостный merry, gay, cheerful.

ХӨГЖИЛТ развитие, прогресс development, growth.

ХӨГЖИЛДӨХ веселиться, забавляться, развлекаться amuse, enjoy oneself, make merry.

ХӨГЖИМ 1) музыка music;
2) музыкальный инструмент musical instrument
сонгодог хөгжим классическая музыка classic music;

хөгжимд/хөгжмийн аялгуунд бүжиглэх танцевать под музыкой dance to the music;
хөгжмийн сургууль музыкальная школа music school;
хөгжмийн сонсгол музыкальный слух an ear for music;
үлээвэр хөгжим духовой оркестр wind instrument, brass band;
үндэсний хөгжим национальный инструмент national musical instruments.

ХӨГЖИМДӨХ играть на музыкальном инструменте play in musical instrument.

ХӨГЖИМЧИН музыкант musician.

ХӨГЖИНГҮЙ развитой developed, highdeveloped;
хөгжингүй социалист нийгэм развитое социалистическое общество high-developed socialist society;
хөгжингүй социалист орон страна развитого социализма high-developed socialist country.

ХӨГЖИХ развиваться, прогрессировать, процветать develop, be in progress, prosper..

ХӨГЖӨӨН веселье, забава, развлечение merriment, amusement, gaiety;
хөгжөөн дэмжигчид болельщики fans, enthusiasts.

ХӨГЖҮҮЛЭХ, ХӨГЖӨӨХ развивать develop, make progress.

ХӨГЛӨРӨХ валяться lie about, be scattered about.

ХӨГШИД старцы, старики elders.

ХӨГШИН старый old, aged;
хөгшин болох стареть grow old

ХӨГШРӨХ стареть grow old.

ХӨДЛӨХ двигаться, трогаться, шевелиться move, begin to move, start, be off, stir;
галт тэрэг хөдлөв поезд тронулся the train started off;
тэр байрнаасаа хөдөлсөнгүй он не двинулся с места he did not budge;
салхи хөдлөв ветер поднялся the wind has risen;
хөдлөлгүй суух сидеть не шевелясь sit without stirring;
сэтгэл хөдлөх быть тронутым be touched of emotions

ХӨДӨЛГӨХ приводить в движение, двигать ;трогать, шевельнуть set in motion, move, stir, shake;
гараа хөдөлгөх двигать рукой, шевелить рукой move one's hand, stir one's hand;
хөдөлгөх хүч движущие силы motive power, motive forces.

ХӨДӨЛГӨӨН 1) движение motion, movement;
2) езда, ходьба traffic;
тасралтгүй хөдөлгөөн непрерывное движение continuous movement;
хувьсгалт хөдөлгөөн революционное движение revolutionary movement;
ажилчны хөдөлгөөн рабочее движение working-class movement;
үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн национально-освободительное движение national liberation movement;
энхтайвны төлөө хөдөлгөөн движение за мир, движение в защиту мира peace movement;
дэлхийн коммунист хөдөлгөөн мировое коммунистическое движение world communist movement;
олон улсын коммунист ажилчны хөдөлгөөн международное коммунистическое рабочее движение international communist and worker's movement;
гудамжны хөдөлгөөн уличное движение street traffic
галт тэрэгний хөдөлгөөн железнодорожное движение railway traffic, train traffic.

ХӨДӨЛГҮҮР двигатель motor, engine;
дотоод шаталтын хөдөлгүүр двигатель внутреннего сгорания internal-combustion engine;
атомын хөдөлгүүр атомный двигатель atomic propulsion, atomic engine.

ХӨДӨЛМӨР труд work, labour;
бүтээлч хөдөлмөр созидательный/творческий труд creative labour, constructive labour;
оюуны хөдөлмөр умственный труд mental work, brain work;
биеийн хөдөлмөр физический труд manual labour, physical labour;
нийгмийн тустай хөдөлмөр общественно-полезный труд socially useful labour;
хөдөлмөр өдөр трудодень work-day;

хөдөлмөр хамгаалал охрана труда labour protection;
хөдөлмөр зохион байгуулалт организация труда organization of labour;
хөдөлмөрийг шинжлэх ухааны үндэстэй зохион байгуулах научная организация труда scientific organization of labour;
хөдөлмөрийн бүтээмж производительность труда productivity of labour, labour productivity;
хөдөлмөрийн нөхцөл условия труда working condition;
хөдөлмөрийн чадвар трудоспособность ability to work, capacity for work;
хөдөлмөрийн дэвтэр трудовая книжка work-book;
хөдөлмөрийн сахилга бат трудовая дисциплина labour discipline;
хөдөлмөрийн нөөц трудовые ресурсы, трудовые резервы manpower; labour reserves;
хөдөлмөрийн хууль трудовой кодекс labour code, labour law;
хөдөлмөрийн хуваарь разделение труда division of labour;
хөдөлмөрийн хүмүүжил трудовое воспитание physical training;
хөдөлмөрийн орлого трудовой доход earned income;
үргүй хөдөлмөр, хий хөдөлмөр напрасный труд lost labour, wasted labour
хөдөлмөрийн сэхээтэн трудовая интеллегенция working intelligentsia.

ХӨДӨЛМӨРЛӨХ трудиться, работать work, labour, toil;
найман цаг хөдөлмөрлөх работать восемь часов work eight hours,
манай оронд хүн бүхэн хөдөлмөрлөх эрхтэй в нашей стране каждый имеет право на труд in our coutry everybody has the right to work;

ХӨДӨЛМӨРЧ трудолюбивый hard-working, assiduous, industrious.

ХӨДӨЛМӨРЧИН трудящийся working
хөдөлмөрчин олон түмэн трудящиеся массы working masses.

ХӨДӨӨ 1) худон, сельская местность, степь country side, rural district open steppe;
2) сельский, деревенский, провинциальный rural, country;
хөдөөгийн хүн ам сельское население rural population;
хөдөөгийн амьдрал сельская жизнь country life;
хөдөөгийн залуус сельская молодёжь village youth;
хөдөө газар, хөдөө нутаг сельская местность country-side;
хөдөө аж ахуй сельское хозяйство agriculture, rural economy;
хөдөө аж ахуйн нэгдэл сельскохозяйственное объединение agricultural co-operative.

ХӨЗӨР игральные карты, козырь card, trump;
хөзөр тоглох, хөзөр тавих играть в карты play cards.

ХӨЛ 1) нога; лапа foot, leg, pad;
2) ножка, ножки; дно leg, stand, base; bottom
3) суета, суматоха, переплох bustle, alarm, trouble;
хөл гар руки и ноги hands and feet;
урьд хөл передние ноги forelegs;
хойд хөл задние ноги hind legs;
баруун хөл левая нога right leg;
хиймэл хөл искусственная нога artificial leg;
хөл нийлүүлэн явах, хөлөө олох идти в ногу keep in step;
